

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-14</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>15-61</i>
<hr/>	
<i>1. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл</i>	<i>15-16</i>
<i>2. “Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл</i>	<i>16-17</i>
<i>3. Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	<i>17-26</i>
<i>4. Гол нэр төрлийн зарим бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилтийн болон хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтийн асуудлаар холбогдох байгууллагуудын мэдээлэл сонсох</i>	<i>26-61</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 05 дугаар сарын 03-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 58,6 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 57 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Ганибал, Б.Энхбаяр, Т.Энхтүвшин;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар.

Нэг. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Цэрэнпунцаг: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 13 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Цэрэнпунцаг: “Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 8
Бүгд: 12
33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтын хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Цэрэнпунцаг: Горимын санал дэмжигдсэн тул дээрх батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 13 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Цогтгэрэл, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хуулийн хэлтсийн ахлах шинжээч Н.Жамъянхүү, “Монголын эрх зүйн судалгаа хөгжлийн төв” ТББ-ын хуульч, судлаач Р.Лхагвабаяр, Хөвсгөл аймгийн Засаг даргын Аялал жуулчлалын зөвлөх О.Мөнхнасан, “Азийн аялал жуулчлалын холбоо”-ны тэргүүн Ж.Пүрэвсүрэн, “Лоок Монголиа” ХХК-ийн захирал Т.Баттулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгаагүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж,

төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсний дагуу санал хураалт явуулав.

Ц.Цэрэнпунцаг: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ш.Адьшаа, Х.Булгантуяа, Т.Доржханд, М.Оюунчимэг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.Энэ хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэр дэх аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “Хөтөч” гэсний өмнө “Аялал жуулчлалын мэргэжилтэй, эсхүл” гэж, мөн зүйлийн 10.2.2 дахь заалтын “үндэсний” гэсний өмнө “хууль тогтоомж,” гэж, 10.3 дахь хэсгийн “журмыг” гэсний өмнө, 10.4 дэх хэсгийн “чиг үүргийг” гэсний өмнө “болон мэргэжлийн ур чадварын зэрэглэл тогтоох” гэж тус тус нэмж, мөн 10.4 дэх заалтын “журмын дагуу” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.2 дахь хэсэг нэмэх:

“10.2.Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэхэд энэ хуулийн 10.1-д заасан шаардлага хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл.Даатгал

15.1.Тур оператор, аяллын агент нь үйл ажиллагаандаа алдаа гаргасны улмаас үйлчлүүлэгчид учруулсан хохирлыг нөхөн төлөх зорилгоор хариуцлагын даатгалд заавал даатгуулна.

15.2.Өндөр уулын авиралт, спорт агнуур, олзворын ан, усны гүнд шумбах, авто спорт, нисдэг тэрэгний аялалд оролцох жуулчин, жуулчны хөтөч-тайлбарлагч, мэргэшсэн сургагч багш, зааварлагч нь гэнэтийн ослын даатгалд заавал даатгуулна.

15.3.Энэ хуулийн 15.2-т зааснаас бусад эрсдэл бүхий аялалд оролцох жуулчин, жуулчны хөтөч-тайлбарлагч, мэргэшсэн сургагч багш, зааварлагч нь гэнэтийн ослын даатгалд даатгуулж болно.

15.4.Энэ хуулийн 15.2-т заасан даатгалд хамруулах үйл ажиллагааг аялал жуулчлалын байгууллага хариуцан зохион байгуулна.

15.5.Энэ хуулийн 15.1, 15.2-т заасан даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хяналт тавих журмыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Санхүүгийн зохицуулах хороотой хамтран батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийн “хамгаалах, байгаль, түүх, соёлын өвийг” гэснийг “байгаль, түүх, соёлын өв, аялал жуулчлалын нөөцийг” гэж, 19.5 дахь хэсгийн “мөрдөгдөх техникийн зохицуулалтад нийцсэн газар зохион байгуулалтын болон” гэснийг “аялал жуулчлалын үйл ажиллагаа, газар ашиглалтад холбогдох техникийн зохицуулалт, стандартыг мөрдөх бөгөөд түүнд нийцсэн” гэж, 19.7 дахь хэсгийн “газар зохион байгуулалтын нэгдсэн санд” гэснийг “газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд” гэж, 19.9 дэх заалтын “аймаг, нийслэлийн асуудал” гэснийг “аймаг, нийслэлийн аялал жуулчлалын асуудал” гэж, мөн 19 дүгээр зүйлийг 16 дугаар зүйл болгон өөрчилж, 19.12 дахь хэсгийн “газар нутгийн” гэснийг, 19.6 дахь хэсгийн “газар зохион байгуулалтын болон” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.8.Орон нутгийн аялал жуулчлалын бүс нь менежментийн төлөвлөгөөтэй байна. Орон нутгийн аялал жуулчлалын бүсийн газар зохион байгуулалтын асуудлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.9 дэх хэсэг нэмэх:

“19.9.Улсын аялал жуулчлалын бүсэд хамаарах аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд аялал жуулчлалын газрын ашиглалт, хамгаалалтын асуудлыг тусгаж, хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 19.5-д заасан техникийн зохицуулалт, стандартыг мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.15 дахь хэсэг нэмэх:

“19.15.Улсын болон орон нутгийн аялал жуулчлалын бүсэд үйл ажиллагаа эрхлэх аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгч хоорондын орон зайн төлөвлөлтөд холбогдох техникийн зохицуулалт, стандартыг заавал дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 4

Бүгд: 12

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.13 дахь заалт нэмэх: “

“4.1.13.“Аялал жуулчлалын бүсийн менежментийн төлөвлөгөө” гэж аялал жуулчлалын бүсийн байгалийн нөөц, түүх, соёлын дурсгалыг хамгаалах, зүй зохистой ашиглах, сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглэсэн богино болон дунд хугацааны төлөвлөгөөг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийг 17 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

17 дугаар зүйл.Отоглох цэг

17.1.Улсын аялал жуулчлалын бүс болон улсын тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын эрэлт, байгаль орчны даацыг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага отоглох цэг байгуулах байршлыг тогтооно.

17.2.Энэ хуулийн 17.1-д заасан улсын тусгай хамгаалалттай газар нутагт отоглох цэгийг улсын төсвийн, тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны, олон улсын төслийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар байгуулна.

17.3.Энэ хуулийн 17.1-д заасан улсын тусгай хамгаалалттай газарт отоглох цэгийн менежментийг тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа хэрэгжүүлэх бөгөөд менежментийг гэрээний үндсэн дээр хуулийн этгээд, орон нутгийн иргэнээр гүйцэтгүүлж болно.

17.4.Энэ хуулийн 17.1-д заасан улсын аялал жуулчлалын бүс нь улсын тусгай хамгаалалттай газартай давхцаагүй тохиолдолд тухайн аялал жуулчлалын бүс дэх отоглох цэгийн менежментийг гэрээний үндсэн дээр хуулийн этгээд, орон нутгийн иргэнээр гүйцэтгүүлж болно.

17.5.Энэ хуулийн 17.4-т заасан отоглох цэгийн менежментийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх этгээдийг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сонгон шалгаруулна.

17.6.Энэ хуулийн 17.1-д заасан улсын тусгай хамгаалалттай газарт отоглох цэгийн үйлчилгээний хураамж авах, зарцуулахтай холбогдсон харилцааг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулна.

17.7.Отоглох цэг нь байнгын, эсхүл түр байж болох бөгөөд стандартын шаардлага хангасан байна.

17.8.Отоглох цэгт олон нийтийн аюулгүй байдлыг хангах харилцааг Цагдаагийн албаны тухай хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.6 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.1.3 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийг 26 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“26 дугаар зүйл.Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо

26.1.Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нь тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, жуулчны хөтөч-тайлбарлагч, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгчийн нэгдэл бүхий, ашгийн төлөө бус нийтийн эрх зүйн хуулийн этгээд байна.

26.2.Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нь аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцогчдыг сургалт, зөвлөгөө, мэдээлэл, мэргэжлийн арга зүйгээр хангах, аялал жуулчлалын байгууллагын ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрмийг батлах болон энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

26.3.Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны дүрэм, удирдлагын бүтэц, санхүүжилт, зохион байгуулалтын бусад асуудлыг бүх гишүүдийн хурлаар бие даан шийдвэрлэнэ.

26.4.Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нь тухайн жилийн үйл ажиллагааны тайлангаа дараа оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, олон нийтэд нээлттэй мэдээлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 32 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32 дугаар зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт

32.1.Энэ хуулийн 26.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг үүсгэн байгуулах хурлыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хууль батлагдсан өдрөөс хойш 90 хоногийн дотор зохион байгуулна.

32.2.Энэ хууль батлагдсан өдрөөс өмнө байгуулагдан аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага хамтран энэ хуулийн 26.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг үүсгэн байгуулна.

32.3.Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 32.1-д заасан хуралд оролцох байгууллагыг нээлттэй бүртгэх ба тур оператор,

аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зохистой харьцааг хангаж хурлыг зохион байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулав.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн Гуравдугаар бүлгийн гарчгийг “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮС” гэж өөрчилж, 13 дугаар зүйлийг 18 дугаар зүйл болгон Гуравдугаар бүлэгт тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн Дөрөвдүгээр бүлгийн гарчгийг “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТАЛААР ТӨРИЙН БОЛОН НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГА, МЭРГЭЖЛИЙН ХОЛБООНЫ БҮРЭН ЭРХ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.5 дахь заалтын “хуулийн” гэсний дараа “6.5, 20.5,” гэж, 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтын “боловсруулах” гэсний дараа “, хэрэгжүүлэх асуудлаар санал гаргах” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.11.аялал жуулчлалын дэд бүтцийг бий болгоход дэмжлэг үзүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

1.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөх.

“1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 10.14 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“10.14.Аялал жуулчлалын тухай хууль зөрчих

1.Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага нь үйлчилгээний стандарт, техникийн зохицуулалт, зэрэглэлд тавигдах шаардлагыг зөрчиж үйл ажиллагаа явуулсан бол хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

1/33 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“4.Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр байгаль хамгаалал, соёл, аялал жуулчлалыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах шаардлагаар төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглахтай холбоотой харилцаанд энэ хуулийн 27.12-т заасан журам үйлчлэхгүй бөгөөд хүсэлтийг үндэслэн гэрээ байгуулж ашиглуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

2/33 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Аялал жуулчлалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д заасан аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх, бий болгох зорилгоор газар ашиглах хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд газар ашиглах эрх олгоход Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 10-т заасныг үндэслэн сонгон шалгаруулалтыг хялбаршуулсан журмаар энэ хуульд заасны дагуу явуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Амьтны тухай хуульд доор дурдсан агуулгатай 29² дүгээр зүйл нэмсүгэй:

1/29² дүгээр зүйл.Тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах, барих тусгай зөвшөөрлийн дуудлага худалдаа зохион байгуулах

29².1.Агнуурын амьтныг тусгай зориулалтаар агнах, барих эрхийг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлд заасны дагуу нээлттэй дуудлага худалдааны журмаар олгох бөгөөд дуудлага худалдааг цахим хэлбэрээр явуулж болно.

29².2.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 26.3-д заасны дагуу гаргасан Засгийн газрын шийдвэр, агнуурын нарийвчилсан төлөвлөгөөг үндэслэн, тусгай зориулалтын ан амьтан агнах, барих тоо хэмжээг аймаг, нийслэл тус бүрээр тогтооно.

29².3.Дуудлага худалдааг тусгай зориулалтаар агнах, барих амьтны тоо хэмжээг баталсан шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор нийтэд мэдээлж, 30 хоногийн дотор аймаг, нийслэлийн Засаг дарга зохион байгуулна.

29².4.Дуудлага худалдааг явуулах хугацааг товлосон шийдвэрийг дуудлага худалдаа явагдахаас 14-өөс доошгүй хоногийн өмнө гаргах ба дараах мэдээллийг тусгана:

29².4.1.дуудлага худалдаа явуулах он, сар, өдөр, цаг, хаяг;

29².4.2.тухайн аймагт ноогдох дуудлага худалдаанд оруулах тусгай зориулалтаар агнах, барих амьтны тоо, төрөл зүйлийн жагсаалт;

29².4.3.дуудлага худалдааны босго үнэ, дэнчингийн хэмжээ, төлөх хугацаа;

29².4.4.хуульд заасан бусад.

29².5.Энэ хуулийн 29².4.3.-т заасан дуудлага худалдааны босго үнэ нь тухайн амьтны Засгийн газраас тогтоосон жишиг үнийн 20 хувь байна.

29².6. Дуудлага худалдааны дэнчин нь энэ хуулийн 29².5-д заасан босго үнийн 50 хувь байх бөгөөд дэнчинг дуудлага худалдаанд оролцохоос 24 цагийн өмнө урьдчилан төлж, бүртгүүлсэн байна.

29².7. Дуудлага худалдаанд ялсан оролцогчийн дэнчинг дуудлага худалдааны үнийн дүнд оролцуулан тооцох ба ялаагүй оролцогчийн дэнчинг 14 хоногийн дотор буцаан олгоно.

29².8. Дуудлага худалдаанд хоёр, түүнээс дээш этгээд оролцох хүсэлтээ ирүүлж, үнийн санал өгсөн тохиолдолд дуудлага худалдааг хүчинтэйд тооцно.

29².9. Дэнчин төлж бүртгүүлсэн этгээд, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч дуудлага худалдаанд оролцоно.

29².10. Дуудлага худалдаанд ялсан этгээд нь дуудлага худалдааны үнийг дуудлага худалдаа дууссанаас хойш ажлын таван өдрийн дотор төлнө.

29².11. Дуудлага худалдааны ялагч нь энэ хуулийн 29².10-т заасан хугацаанд дуудлага худалдааны үнийг төлөөгүй тохиолдолд дэнчингээ алдах ба дараагийн өндөр үнийн санал гаргасан этгээдэд санал тавина.

29².12. Дуудлага худалдаанд хоёр, түүнээс дээш оролцогч оролцоогүй, эсхүл үнэ хаялцаагүй, эсхүл энэ хуулийн 29².11-т зааснаар дараагийн өндөр үнийн санал гаргасан оролцогчид тавьсан саналыг хүлээн аваагүй тохиолдолд дуудлага худалдааг хүчингүй болгож, 14 хоногийн дотор хоёр дахь дуудлага худалдааг явуулна.

29².13. Дуудлага худалдааны ялагч нь агнуурын бүс нутгийн менежмент хариуцагч бол тусгай зөвшөөрлийг өөрийн менежмент хариуцдаг агнуурын бүс нутаг дээр бүртгүүлж, баталгаажуулна.

29².14. Дуудлага худалдааны ялагч нь агнуурын бүс нутгийн менежмент хариуцагчаас өөр этгээд бол тухайн аймгийн аль нэг агнуурын бүс нутгийн менежмент хариуцагчтай ан агнуулах гэрээ байгуулна.

29².15. Аймаг, нийслэлийн Засаг дарга дуудлага худалдааны төлбөр, агнуурын нөөц ашигласны төлбөр, хураамжийг төлсөн баримт, энэ хуулийн 29².14-т заасан гэрээг үндэслэн ан агнах тусгай зөвшөөрөл олгоно.

29².16. Энэ хуулийн 29².15-д заасан тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхгүй.

29².17. Дуудлага худалдааны үнийн дүнгийн орлогыг Төсвийн тухай хуулийн 23.7.4, 23.9.4-т заасны дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

29².18. Дуудлага худалдаанаас орсон орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэний дараа үнийн дүнгийн 20 хувийг агнуурын бүс нутгийн амьтны нөөцийг хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээнд зориулан менежмент хариуцагчид олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 2

Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Амьтны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.9 дэх заалтын “бүх төрлийн” гэснийг “моторын багтаамж нь 50, түүнээс дээш морины хүчтэй моторт” гэж, 29¹ дүгээр зүйлийн гарчгийн “Дуудлага худалдаа зохион байгуулах” гэснийг “Ховор амьд амьтны цуглуулга хийх, үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих тусгай зөвшөөрлийн дуудлага худалдаа зохион байгуулах” гэж, 29¹ дүгээр зүйлийн 29¹.2 дахь хэсгийн “мөн хуулийн 26.3-т заасны дагуу Засгийн газраас тусгай зориулалтаар агнах, барих амьтны тоо хэмжээг баталсан” гэснийг “эрх бүхий байгууллагын” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн “хассугай.” гэсний өмнө “, 29¹ дүгээр зүйлийн 29¹.1 дэх хэсгийн “тусгай болон” гэснийг тус тус” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6 дугаар зүйл.Энэ хуулийг Аялал жуулчлалын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн гаргасан, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, Б.Баттөмөр нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 39 минут хэлэлцэж дуусав.

Дөрөв. Үнийн өсөлтийн талаар холбогдох яамны мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, мөн банкны Ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир, Мөнгөний бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Н.Ургамалсүвд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхөлөг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хангамжийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Ч.Ариунтуяа, мэргэжилтэн Д.Отгонжаргал, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга Ц.Уртнасан, мөн газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхханд, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, зар сурталчилгааны газрын дарга Ц.Тэрбиш, Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга М.Баяраа, мөн албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэцэцэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, мөн газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Т.Тунгалаг, Монголын банкны холбооны гүйцэтгэх захирал Л.Амар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт Д.Отгонбаатар нар байлцав.

Хүнсний гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилтийн тухай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхөлөг, Нөөцийн махны борлуулалттай холбоотой мэдээллийг Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дарга М.Баяраа нар тус тус танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Ж.Бат-Эрдэнэ, Т.Аубакир, Г.Тэмүүлэн, Д.Батлут, Ц.Сандаг-Очир Д.Өнөрболор, М.Оюунчимэг нарын тавьсан асуулгад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхөлөг, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын дарга Ц.Уртнасан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Ц.Цэрэнпунцаг нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Хүнсний гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийн талаар холбогдох байгууллагуудын мэдээллийг сонслоо.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 56 минут үргэлжилж, 18 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 77.8 хувийн ирцтэйгээр 15 цаг 53 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
12 цаг 57 минут

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Цэрэнпунцаг: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Жамбалын Ганбаатар гишүүн өвчтэй, Нянтайн Ганибал гишүүн чөлөөтэй, Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн чөлөөтэй, Төмөртоогогийн Энхтүвшин гишүүн чөлөөтэй. Ингээд бусад гишүүд ирсэн байна. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 55.6 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай /Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий/,

Хоёрт, “Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл Засгийн газрын тусгай сангуудын асуудлаар хянан шалгалт явуулах тухай Байнгын хорооны 2023 оны 7 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн хэсгээс боловсруулсан,

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд Засгийн газар 2022 оны 11 сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн эцсийн хэлэлцүүлэг,

Дөрөв, Гол нэр төрлийн зарим бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилттэй танилцах гэсэн 4 асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Ажлын хэсгийн бүрэлдэхүүний талаарх тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1. Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Б.Баттөмөр Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүд Т.Доржханд Улсын Их Хурлын гишүүн, Д.Өнөрболор Улсын Их Хурлын гишүүн, Цогтгэрэл Улсын Их Хурлын гишүүн, С.Чинзориг Улсын Их Хурлын гишүүн.

2. Ажлын хэсэг мэргэжил арга зүйн тусалцаа үзүүлэх мэдээллээр

хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжлийн албан хаагчдыг ажиллуулахыг ажлын хэсэг Б.Баттөмөрт зөвшөөрсүгэй.

Тогтоолын төсөл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна санал хураалт явуулъя.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл тогтоолыг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гишүүдээ санал хураалт. Гишүүдийн 60 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

13.00 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

“Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Ажлын хэсгийн удирдамж батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 7 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1. Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр баталсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, эдгээр сангууд байршиж байгаа мөнгөн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт эрсдэлээс хамгаалах талаар

санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийн удирдамжийг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолыг нь хэрэгжүүлэн хяналт тавьж ажиллахыг Эдийн засгийн байнгын хороо Ц.Цэрэнпунцагт даалгасугай.

Төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Алга байна.

Санал санал хураалт явуулж эхэлье ээ.

“Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санаа томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Жавхлан гишүүнээр микрофон. Жавхлан гишүүн та горимын санал гаргах уу? Жавхлан гишүүний микрофоныг нээе дээ.

Б.Жавхлан: Энэ сая орж ирсэн хэд хэдэн гишүүдийн микрофон нь массаад явчихлаа.

Би саяынхыг минийх бүртгэлд орсонгүй энийгээ солиод ингэсэн тэр хооронд санал хураалт явчихлаа. Уучлаарай. Дахиж явуулж өгөөч ээ. Саяын санал хураалтыг хүчингүй болгоод.

Ц.Цэрэнпунцаг: Жавхлан гишүүний гаргасан горимын саналаар саяын хураасан санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гишүүдийн 58.3 хувийг нь дэмжиж санал дэмжигдлээ.

Энд саяын санал хүчингүй болсон учраас дахин санал хураалт явуулъя анхааралтай байгаарай гишүүд ээ.

Санал хураалт. Гишүүдийн 66.7 хувиар санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

“Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын хэлэлцүүлэг дуусаж, тогтоол батлагдлаа.

13.03 цаг.

Дараагийн асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал гурав.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулна.

Ганхуяг гишүүний микрофоныг нээе.

Х.Ганхуяг: Энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Засгийн газраас 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр өргөн мэдүүлсэн Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг ажлын хэсэг 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр хуралдан эцсийн хэлэлцүүлэг бэлтгэлээ. Төслүүдэд хуралдаан даргалагчаас гүйцээн тусгуулах чиглэл өгсөн болон түүнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулгын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-д заасны дагуу санал хураалгах 26 зарчмын зөрөөтэй саналын томъёолол бэлтгэн та бүхэнд тараасан болно оо.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгийн бэлдсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсэж байна.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийг танилцуулъя.

Бат-Өлзийн Бат-Эрдэнэ Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сүхбаатарын Цогтгэрэл Байгаль орчин, аялал жуулчлалын яамны ТНБД, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Ренчинпүрэвийн Лхагвабаяр Монголын эрх зүйн судалгаа хөгжлийн төв ТББ-ын хуульч, судлаач, Олдохын Мөнхнасан Хөвсгөл аймгийн Засаг даргын аялал жуулчлалын зөвлөх, Төмөрдашийн Баттулга Лок Монголиа ХХК-ийн захирал, Мөнх-Од Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын бодлогын газрын дарга.

Ажлын хэсгийн танилцуулгаас асуух асуулттай Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү? Байна уу? Кнопоо дараарай. Жавхлан гишүүнээр тасалъя.

Жавхлан гишүүн асуултаа асууя.

Б.Жавхлан: Зарчмын зөрүүтэй санал хураах үед хэлье.

Ц.Цэрэнпунцаг: Өөр саналтай гишүүн алга байна. Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч санал хураалгаагүй үлдсэн саналууд болон анхны хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн боловч ажлын хэсгийн зүгээс дахин санал хураалгахаар бэлтгэсэн саналуудаар санал хураалт явуулж эхэлье ээ.

**Нэг.Хуралдаан даргалагчаас
гүйцээн боловсруулах чиглэл өгсөн
саналын томъёолол:**

1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.Энэ хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэр дэх аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Ажлын хэсэг Х.Ганхуяг, Ш.Адьяа, Х.Булгантуяа, Т.Доржханд, М.Оюунчимэг /Цаашид “ажлын хэсэг” гэх/ Санал хураалт.

Гишүүдийн 66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “Хөтөч” гэсний өмнө “Аялал жуулчлалын мэргэжилтэй, эсхүл” гэж, мөн зүйлийн 10.2.2 дахь заалтын “үндэсний” гэсний өмнө “хууль тогтоомж,” гэж, 10.3 дахь хэсгийн “журмыг” гэсний өмнө, 10.4 дэх хэсгийн “чиг үүргийг” гэсний өмнө “болон мэргэжлийн ур чадварын зэрэглэл тогтоох” гэж тус тус нэмж, мөн 10.4 дэх заалтын “журмын дагуу” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.2 дахь хэсэг нэмэх:

“10.2.Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэхэд энэ хуулийн 10.1-д заасан шаардлага хамаарахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 15 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл.Даатгал

15.1.Тур оператор, аяллын агент нь үйл ажиллагаандаа алдаа гаргасны улмаас үйлчлүүлэгчид учруулсан хохирлыг нөхөн төлөх зорилгоор хариуцлагын даатгалд заавал даатгуулна.

15.2.Өндөр уулын авиралт, спорт агнуур, олзворын ан, усны гүнд шумбах, авто спорт, нисдэг тэрэгний аялалд оролцох жуулчин, жуулчны хөтөч-тайлбарлагч, мэргэжсэн сургагч багш, зааварлагч нь гэнэтийн ослын даатгалд заавал даатгуулна.

15.3.Энэ хуулийн 15.2-т зааснаас бусад эрсдэл бүхий аялалд оролцох жуулчин, жуулчны хөтөч-тайлбарлагч, мэргэжсэн сургагч багш, зааварлагч нь гэнэтийн ослын даатгалд даатгуулж болно.

15.4.Энэ хуулийн 15.2-т заасан даатгалд хамруулах үйл ажиллагааг аялал жуулчлалын байгууллага хариуцан зохион байгуулна.

15.5.Энэ хуулийн 15.1, 15.2-т заасан даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хяналт тавих журмыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Санхүүгийн зохицуулах хороотой хамтран батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийн “хамгаалах, байгаль, түүх, соёлын өвийг” гэснийг “байгаль, түүх, соёлын өв, аялал жуулчлалын нөөцийг” гэж, 19.5 дахь хэсгийн “мөрдөгдөх техникийн зохицуулалтад нийцсэн газар зохион байгуулалтын болон” гэснийг “аялал жуулчлалын үйл ажиллагаа, газар ашиглалтад холбогдох техникийн зохицуулалт, стандартыг мөрдөх бөгөөд

түүнд нийцсэн” гэж, 19.7 дахь хэсгийн “газар зохион байгуулалтын нэгдсэн санд” гэснийг “газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд” гэж, 19.9 дэх заалтын “аймаг, нийслэлийн асуудал” гэснийг “аймаг, нийслэлийн аялал жуулчлалын асуудал” гэж, мөн 19 дүгээр зүйлийг 16 дугаар зүйл болгон өөрчилж, 19.12 дахь хэсгийн “газар нутгийн” гэснийг, 19.6 дахь хэсгийн “газар зохион байгуулалтын болон” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.8.Орон нутгийн аялал жуулчлалын бүс нь менежментийн төлөвлөгөөтэй байна. Орон нутгийн аялал жуулчлалын бүсийн газар зохион байгуулалтын асуудлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.9 дэх хэсэг нэмэх:

“19.9.Улсын аялал жуулчлалын бүсэд хамаарах аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд аялал жуулчлалын газрын ашиглалт, хамгаалалтын асуудлыг тусгаж, хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 19.5-д заасан техникийн зохицуулалт, стандартыг мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.15 дахь хэсэг нэмэх:

“19.15.Улсын болон орон нутгийн аялал жуулчлалын бүсэд үйл ажиллагаа эрхлэх аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгч хоорондын орон зайн төлөвлөлтөд холбогдох техникийн зохицуулалт, стандартыг заавал дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Намайг протоколд тэмдэглэхээрэй. Минийх эсрэг гарсан байна шүү. Би дэмжиж өгсөн шүү.

9.Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.13 дахь заалт нэмэх: “

“4.1.13. “Аялал жуулчлалын бүсийн менежментийн төлөвлөгөө” гэж аялал жуулчлалын бүсийн байгалийн нөөц, түүх, соёлын дурсгалыг хамгаалах, зүй зохистой ашиглах, сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглэсэн богино болон дунд хугацааны төлөвлөгөөг.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

10.Төслийн 20 дугаар зүйлийг 17 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

17 дугаар зүйл.Отоглох цэг

17.1.Улсын аялал жуулчлалын бүс болон улсын тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын эрэлт, байгаль орчны даацыг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн

захиргааны төв байгууллага отоглох цэг байгуулах байршлыг тогтооно.

17.2.Энэ хуулийн 17.1-д заасан улсын тусгай хамгаалалттай газар нутагт отоглох цэгийг улсын төсвийн, тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны, олон улсын төслийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар байгуулна.

17.3.Энэ хуулийн 17.1-д заасан улсын тусгай хамгаалалттай газарт отоглох цэгийн менежментийг тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа хэрэгжүүлэх бөгөөд менежментийг гэрээний үндсэн дээр хуулийн этгээд, орон нутгийн иргэнээр гүйцэтгүүлж болно.

17.4.Энэ хуулийн 17.1-д заасан улсын аялал жуулчлалын бүс нь улсын тусгай хамгаалалттай газартай давхцаагүй тохиолдолд тухайн аялал жуулчлалын бүс дэх отоглох цэгийн менежментийг гэрээний үндсэн дээр хуулийн этгээд, орон нутгийн иргэнээр гүйцэтгүүлж болно.

17.5.Энэ хуулийн 17.4-т заасан отоглох цэгийн менежментийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх этгээдийг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сонгон шалгаруулна.

17.6.Энэ хуулийн 17.1-д заасан улсын тусгай хамгаалалттай газарт отоглох цэгийн үйлчилгээний хураамж авах, зарцуулахтай холбогдсон харилцааг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулна.

17.7.Отоглох цэг нь байнгын, эсхүл түр байж болох бөгөөд стандартын шаардлага хангасан байна.

17.8.Отоглох цэгт олон нийтийн аюулгүй байдлыг хангах харилцааг Цагдаагийн албаны тухай хуулиар

зохицуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт

Гишүүдийн 80.0 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

11.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.6 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 70.0 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

12.Төслийн 25 дугаар зүйлийн 25.1.3 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 80.0 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

13.Төслийн 27 дугаар зүйлийг 26 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“26 дугаар зүйл.Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо

26.1.Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нь тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, жуулчны хөтөч-тайлбарлагч, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгчийн нэгдэл бүхий, ашгийн төлөө бус нийтийн эрх зүйн хуулийн этгээд байна.

26.2.Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нь аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцогчдыг сургалт, зөвлөгөө, мэдээлэл, мэргэжлийн арга зүйгээр хангах, аялал жуулчлалын байгууллагын ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрмийг батлах болон энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

26.3.Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны дүрэм, удирдлагын бүтэц, санхүүжилт, зохион байгуулалтын бусад асуудлыг бүх гишүүдийн хурлаар бие даан шийдвэрлэнэ.

26.4. Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нь тухайн жилийн үйл ажиллагааны тайлангаа дараа оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, олон нийтэд нээлттэй мэдээлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 80.0 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

14. Төслийн 32 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32 дугаар зүйл. Шилжилтийн үеийн зохицуулалт

32.1. Энэ хуулийн 26.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг үүсгэн байгуулах хурлыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хууль батлагдсан өдрөөс хойш 90 хоногийн дотор зохион байгуулна.

32.2. Энэ хууль батлагдсан өдрөөс өмнө байгуулагдан аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага хамтран энэ хуулийн 26.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг үүсгэн байгуулна.

32.3. Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 32.1-д заасан хуралд оролцох байгууллагыг нээлттэй бүртгэх ба тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зохистой харьцааг хангаж хурлыг зохион байгуулна. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 80.0 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-т заасны дагуу хэлэлцэх санал:

15. Төслийн Гуравдугаар бүлгийн гарчгийг “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮС” гэж өөрчилж, 13 дугаар зүйлийг 18 дугаар зүйл болгон Гуравдугаар бүлэгт тусгах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 80.0 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

16. Төслийн Дөрөвдүгээр бүлгийн гарчгийг “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТАЛААР ТӨРИЙН БОЛОН НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГА, МЭРГЭЖЛИЙН ХОЛБООНЫ БҮРЭН ЭРХ” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 70.0 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

17. Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.5 дахь заалтын “хуулийн” гэсний дараа “6.5, 20.5,” гэж, 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтын “боловсруулах” гэсний дараа “, хэрэгжүүлэх асуудлаар санал гаргах” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 80.0 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

18. Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.11. аялал жуулчлалын дэд бүтцийг бий болгоход дэмжлэг үзүүлэх;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 70.0 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Одоо дагасан хуулиуд руу орж байна.

Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол

Нэг.Хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн саналын томъёолол:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөх.

“1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 10.14 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“10.14.Аялал жуулчлалын тухай хууль зөрчих

1.Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага нь үйлчилгээний стандарт, техникийн зохицуулалт, зэрэглэлд тавигдах шаардлагыг зөрчиж үйл ажиллагаа явуулсан бол хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 80.0 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-т заасны дагуу хэлэлцэх санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

1/33 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“4.Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр байгаль хамгаалал,

соёл, аялал жуулчлалыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах шаардлагаар төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглахтай холбоотой харилцаанд энэ хуулийн 27.12-т заасан журам үйлчлэхгүй бөгөөд хүсэлтийг үндэслэн гэрээ байгуулж ашиглуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 70.0 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

2/33 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Аялал жуулчлалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д заасан аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх, бий болгох зорилгоор газар ашиглах хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд газар ашиглах эрх олгоход Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 10-т заасныг үндэслэн сонгон шалгаруулалтыг хялбаршуулсан журмаар энэ хуульд заасны дагуу явуулж болно Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 80.0 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-т заасны дагуу хэлэлцэх санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Амьтны тухай
хуульд доор дурдсан агуулгатай 29²
дүгээр зүйл нэмсүгэй:

1/29² дүгээр зүйл.Тусгай
зориулалтаар агнуурын амьтан агнах,
барих тусгай зөвшөөрлийн дуудлага
худалдаа зохион байгуулах

29².1.Агнуурын амьтныг тусгай зориулалтаар агнах, барих эрхийг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлд заасны дагуу нээлттэй дуудлага худалдааны журмаар олгох бөгөөд дуудлага худалдааг цахим хэлбэрээр явуулж болно.

29².2.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 26.3-д заасны дагуу гаргасан Засгийн газрын шийдвэр, агнуурын нарийвчилсан төлөвлөгөөг үндэслэн, тусгай зориулалтын ан амьтан агнах, барих тоо хэмжээг аймаг, нийслэл тус бүрээр тогтооно.

29².3.Дуудлага худалдааг тусгай зориулалтаар агнах, барих амьтны тоо хэмжээг баталсан шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор нийтэд мэдээлж, 30 хоногийн дотор аймаг, нийслэлийн Засаг дарга зохион байгуулна.

29².4.Дуудлага худалдааг явуулах хугацааг товлосон шийдвэрийг дуудлага худалдаа явагдахаас 14-өөс доошгүй хоногийн өмнө гаргах ба дараах мэдээллийг тусгана:

29².4.1.дуудлага худалдаа явуулах он, сар, өдөр, цаг, хаяг;

29².4.2.тухайн аймагт ноогдох дуудлага худалдаанд оруулах тусгай зориулалтаар агнах, барих амьтны тоо, төрөл зүйлийн жагсаалт;

29².4.3.дуудлага худалдааны босго үнэ, дэнчингийн хэмжээ, төлөх хугацаа;

29².4.4.хуульд заасан бусад.

29².5.Энэ хуулийн 29².4.3.-т заасан дуудлага худалдааны босго үнэ нь тухайн амьтны Засгийн газраас тогтоосон жишиг үнийн 20 хувь байна.

29².6.Дуудлага худалдааны дэнчин нь энэ хуулийн 29².5-д заасан босго үнийн 50 хувь байх бөгөөд дэнчинг дуудлага худалдаанд оролцохоос 24 цагийн өмнө урьдчилан төлж, бүртгүүлсэн байна.

29².7.Дуудлага худалдаанд ялсан оролцогчийн дэнчинг дуудлага худалдааны үнийн дүнд оролцуулан тооцох ба ялаагүй оролцогчийн дэнчинг 14 хоногийн дотор буцаан олгоно.

29².8.Дуудлага худалдаанд хоёр, түүнээс дээш этгээд оролцох хүсэлтээ ирүүлж, үнийн санал өгсөн тохиолдолд дуудлага худалдааг хүчинтэйд тооцно.

29².9.Дэнчин төлж бүртгүүлсэн этгээд, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч дуудлага худалдаанд оролцоно.

29².10.Дуудлага худалдаанд ялсан этгээд нь дуудлага худалдааны үнийг дуудлага худалдаа дууссанаас хойш ажлын таван өдрийн дотор төлнө.

29².11.Дуудлага худалдааны ялагч нь энэ хуулийн 29².10-т заасан хугацаанд дуудлага худалдааны үнийг төлөөгүй тохиолдолд дэнчингээ алдах ба дараагийн өндөр үнийн санал гаргасан этгээдэд санал тавина.

29².12.Дуудлага худалдаанд хоёр, түүнээс дээш оролцогч оролцоогүй, эсхүл үнэ хаялцаагүй, эсхүл энэ хуулийн 29².11-т зааснаар дараагийн өндөр үнийн санал гаргасан оролцогчид тавьсан саналыг хүлээн аваагүй тохиолдолд дуудлага худалдааг хүчингүй болгож, 14 хоногийн дотор хоёр дахь дуудлага худалдааг явуулна.

29².13. Дуудлага худалдааны ялагч нь агнуурын бүс нутгийн менежмент хариуцагч бол тусгай зөвшөөрлийг өөрийн менежмент хариуцдаг агнуурын бүс нутаг дээр бүртгүүлж, баталгаажуулна.

29².14. Дуудлага худалдааны ялагч нь агнуурын бүс нутгийн менежмент хариуцагчаас өөр этгээд бол тухайн аймгийн аль нэг агнуурын бүс нутгийн менежмент хариуцагчтай ан агнуулах гэрээ байгуулна.

29².15. Аймаг, нийслэлийн Засаг дарга дуудлага худалдааны төлбөр, агнуурын нөөц ашигласны төлбөр, хураамжийг төлсөн баримт, энэ хуулийн 29².14-т заасан гэрээг үндэслэн ан агнах тусгай зөвшөөрөл олгоно.

29².16. Энэ хуулийн 29².15-д заасан тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхгүй.

29².17. Дуудлага худалдааны үнийн дүнгийн орлогыг Төсвийн тухай хуулийн 23.7.4, 23.9.4-т заасны дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

29².18. Дуудлага худалдаанаас орсон орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэний дараа үнийн дүнгийн 20 хувийг агнуурын бүс нутгийн амьтны нөөцийг хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээнд зориулан менежмент хариуцагчид олгоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ дээр асуух уу?

Гишүүдийн 80.0 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 70.0 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

3.Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл. Амьтны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.9 дэх заалтын “бүх төрлийн” гэснийг “моторын багтаамж нь 50, түүнээс дээш морины хүчтэй моторт” гэж, 29¹ дүгээр зүйлийн гарчгийн “Дуудлага худалдаа зохион байгуулах” гэснийг “Ховор амьд амьтны цуглуулга хийх, үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих тусгай зөвшөөрлийн дуудлага худалдаа зохион байгуулах” гэж, 29¹ дүгээр зүйлийн 29¹.2 дахь хэсгийн “мөн хуулийн 26.3-т заасны дагуу Засгийн газраас тусгай зориулалтаар агнах, барих амьтны тоо хэмжээг баталсан” гэснийг “эрх бүхий байгууллагын” гэж тус тус өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 80.0 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

4.Төслийн 5 дугаар зүйлийн “хассугай.” гэсний өмнө “, 29¹ дүгээр зүйлийн 29¹.1 дэх хэсгийн “тусгай болон” гэснийг тус тус” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 80.0 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

5.Төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6 дугаар зүйл. Энэ хуулийг Аялал жуулчлалын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал дэмжигдлээ.

Ажлын хэсгээс гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Одоо гишүүдээс гарсан саналаар санал хураалт явуулна.

Гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулъя.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

Нэмүү өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн I дүгээр зүйлийн нэг дэх хэсгийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан.

Саналаа тайлбарлаж хэлэх үү? Жавхлан гишүүний микрофоныг нээе.

Б.Жавхлан: Гишүүдийнхээ өдрийн мэндийг ирье.

Өнгөрсөн Баасан гаргийн Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар үдээс хойш нэр бүхий гишүүд санал гаргаад энэ Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэ хууль дээр тэр 1.1 дүгээр хэсэгтэй холбоотой заалт гаргаад ингээд дэмжигдсэн юм. Үгүй ээ яах вэ тэрэн дээр Бямбацогт сайдын гаргасан санал гаргасан зорилгыг бас хүндэтгэж үзэх шалтгаан байгаа л даа. Мэдээж одоо энэ дотоодын нислэгийн билет тийзний үнэ нэлээн өндөр байгаа юм. Тэгээд welcome to Mongolia энэ аялал жуулчлалын жилийг зориулаад ч тэр энэ тийзний үнүүдийг буулгах ийм л зорилготой байсан юм. Тэгээд бид нар энэ талаар сайн ярилцсан. Засгийн газар дээрээ ч ярилцсан. Өчигдөр бүүр Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр ч энэ асуудал яригдсан. Тэндээс ингээд зөвлөмж ингээд баталгаажиж албажиж гарч байгаа. Тэнд юу дурдагдсан бэ гэхээр ер нь өнөөдрийг хүртэл цалин жишээ нь 23 салбарын хууль дээр НӨАТ-ын асуудал мөн 20 гаран хуулийг дагаад ингээд энэ тэнцвэртэй бодлого алдагдаад татварын нэгдсэн бодлого дээр энэ

нэлээн том ийм цоорхой үүсгээд цалингийн хувьд ч тэр хөрөөний эрх ишг ийм харилцан тэнцвэргүй салбар болгон өөр өөрсдийнхөө хуульд энийг зохицуулалт хийчихдэг. Төрийн албаны цалингийн тогтолцоог Засгийн газраас нэгдсэн байдлаар бодлого хэрэгжүүлэх боломжгүй. Татвар дээр ч мөн адилхан. НӨАТ дээр ийм асуудлууд үүсэж байгаа учраас энэ асуудлуудыг 3 түвшиндээ Ерөнхийлөгч, Их Хурлын дарга, Ерөнхий сайд гээд яг засаглалуудынхаа түвшинд институцүүдийн түвшинд энэ асуудлуудыг зөвхөн Засгийн газар дээрээс ирсэн саналыг үндэслэж ингэж хэлэлцэж байхаар ингэж зөвлөмж гарч байгаа юм.

Тэгээд ер нь яах вэ тэгээд 5 дахь өдөр би тайлбарлаж чадаагүй юм. Тэгээд би үдээс хойш нь нэг өөр томилолттой болчихоод хурал дээр байж чадаагүй бас миний буруу.

Ингээд гишүүддээ бүрэн мэдээлэл өгч чадаагүй. Тэгэхээр бас алс аймагт байдаг гишүүд үнэхээр тэр тийзний үнэ буурчихна гэж бодоод л энэ дээр ингээд санал өгсөн болов уу гэж ингэж бодож байгаа. Гэтэл одоо энэ НӨАТ-ыг буулгаснаар энэ маань тийм санасан үр дүндээ хүрэхгүй. Эсрэгээрээ бүүр ингээд НӨАТ-ын системийг энэ гинжин татварын энэ ийм системийг дундаас нь тасалж хаяад бүүр ингээд тийзний өртөг өсөх ийм зүйл рүүгээ. Дээрээс нь одоо бид далд эдийн засгийг арайхийн бууруулж ийм зөв чиглэл рүүгээ явж байгаа энэ хандлагыг буцаагаад далд руу оруулах ийм сэдлүүдийг өгүүлэх. Ар араасаа дахиад энэ НӨАТ-ыг чөлөөлөх ийм зүйл рүү уруу татаж ингэж явах учраас энэ ер нь болохгүй нь ээ.

Тийм учраас үр дүн гарахгүй зүйлийн төлөө ийм том системээ эвдээд яах вэ гэдэг ийм бид шийдэлд нэгдсэн байр суурь дээр хүрсэн байгаа юм. Тийм учраас гишүүд сая Байнгын хорооны даргын уншиж танилцуулсан томъёоллыг дэмжиж өгнө үү гэж санал гаргаж байгаа юм.

Тийм, баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Сая Жавхлан сайд гаргасан горимынхоо санал дээр тайлбар хэллээ. Ингээд горимын гаргасан саналтай холбоотойгоор Баттөмөр гишүүн үг хэлье ээ.

Б.Баттөмөр: Жавхлан сайдын саяын хэлж байгаа санааг саналыг дэмжиж байна. Энэ НӨАТ-аар ингэж их оролдоод байх буруу шүү дээ. НӨАТ-аа ингэж чөлөөлөх биш чөлөөлчихсөн байгаа. Одоо энэ чинь НӨАТ-аа чөлөөлчихсөн асар их олон байна. Хасалт хийнэ гээд байж байгаа. Буцаан олголт гээд. Асар их олон чөлөөлөлтүүд байж байгаа байхгүй юу. Татвар чинь тэгш шударга байх ёстой. Тэр 50 саяас доош бол ингээд бас байхгүй болгочихсон байна. Тэгээд НӨАТ дээрээ бол энэ хамруулах чиглэлд их олон зүйлийн бодлого ийм шаардлага байгаа шүү. Ялангуяа НӨАТ бол татвараас гадна энэ бүртгэлийн систем шүү дээ. Далд эдийн засгийг ил болгох энэ чиглэлд юу яаж байгаа юм.

Энэ онгоцны энэ бүх сэлбэг тэр газар дадлагажуулах барих юмнууд нь бүгд НӨАТ-аас чөлөөлөгдсөн явж байгаа шүү дээ. Тийм учраас саналыг дэмжиж байна. НӨАТ дээрээ бол ажиллах шаардлага байгаа Жавхлан сайдаа.

Ц.Цэрэнпунцаг: Жавхлан сайд бүр саналаа тодорхой тайлбарлачихлаа. Тэгэхээр энэ 2/3-оор гишүүд ээ санал өгч байгаа гишүүдийн 2/3-оор дэмжигдэх ёстой юм шүү. Тэгээд саналаа идэвхтэй өгөөрэй. Ингээд санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гишүүдийн 80 хувийн дэмжлэгээр санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч Х.Ганхуяг уншиж танилцуулна.

Дараагийн асуудалдаа оръё.

Ажлын хэсгийнхэнд баярлалаа, явж болно.

Ажлын хэсгийнхэн наашаа суучхаарай. Наашаа шахаад суучих. Хөдөө аж ахуйн яамнаас хэн байна гараа өргө дөө. Танай сайд хаана байна?

Гол нэр төрлийн зарим бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилтийн болон хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтийн асуудлаар холбогдох байгууллагуудын мэдээллийг сонсох

Мах гурилын үнэ өсөөд байна шүү дээ. Тэгээд танай сайд хаана байна? Сайд руугаа хэлээрэй. Танилцуулгаа явуулчихъя.

Энэ танилцуулгыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд Н.Ганхөлөг хийнэ. Ажлын хэсгийн 4 номерын микрофоныг нээе.

Н.Ганхөлөг: Байнгын хорооны дарга, гишүүд та бүхнийхээ энэ өдрийн мэндийг дэвшүүлъя. Хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хадгалах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 4 сарын 15-ны өдөр баталсан гол нэр төрлийн зарим бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль Засгийн газрын 2022 оны Гурил, махны үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 174 дүгээр тогтоолыг тус тус баталсан.

Уг тогтоолд нөөцийн мах бэлтгэн нийлүүлэх аж ахуйн нэгжид 130 тэрбум, гурил үйлдвэрлэгч аж ахуйн нэгжид 100 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг нэг жилийн хугацаатай жилийн 3-6 хувийн хүүтэй олгож, зээлийн хүүгийн 10.65 хувьтай тэнцүү хэмжээний хөнгөлөлтийг Улсын төсвөөс санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн.

Жишсэн хүн амаар тооцоход Монгол Улсын нийт хүн амын хэрэгцээнд 121.7 мянган тонн мах 225.3 мянган тонн гурил буюу 300.4 мянган тонн улаан буудай хэрэгцээтэй байна уу? Байна аа.

Эхний удаад мах, гурилын нөөц бүрдүүлэлтийн талаар мэдээлэл танилцуулъя.

Нийслэлийн хүн амын 2023 оны хаврын улирлын хэрэгцээнд зориулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монгол банкттай хамтран нөөцийн мах бэлтгэлийн эх үүсвэрийг банкны саналд үндэслэн урт хугацаатай репо арилжаагаар 2 банкнаас 53.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг мах бэлтгэн нийлүүлэгч 12 аж ахуйн нэгжид олгож нийслэлийн хүн амын 2023 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан 7900 тонн үхэр, хонь, ямааны махыг бэлтгэн нөөцөлсөн.

Бэлтгэж нөөцөлсөн махыг 3 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн үхрийн ястай махыг 10700 төгрөг, хонины ястай махыг 8600 төгрөг, ямааны ястай махыг 6400 төгрөгийн үнээр нийслэлийн 9 дүүргийн хүнсний 481 дэлгүүрээр, мөн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор өргөтгөсөн худалдааг амралтын өдөр бүр 34-35 байришилд ээлжлэн бас гаргаж байна. Өдөр бүр байнгын 8-10 цэгийг, тусгай цэгийг гарган бас ажиллуулж байна. Мөн хонины махыг гулуузаар 8300 төгрөгийн үнээр энэхүү эдгээр цэгүүдээр бас худалдаалж байна. Энэхүү ажлыг нийслэлтэй бас хамтран зохион байгуулж байна. Махны борлуулалт 5 сарын 2-ны өдрийн байдлаар үхрийн мах

283.5 тонн, хонины мах 856.9 тонн, ямааны 11.1 тонн нийт 1151.4 тонн махыг худалдаалж, нийт гүйцэтгэлийн 15 хувьтай байна. Нөөцийн махны худалдах үнийг Хүчит шонхор захын энэ оны 4 сарын 26-ны өдрийн бөөний дундаж үнэтэй харьцуулахад үхрийн ястай махыг 2450 төгрөг буюу 23 хувь, хонины ястай махыг 1900 төгрөг буюу 22.2 хувиар, ямааны мах 850 төгрөг буюу 13 хувиар, жижиглэнгийн дундаж үнэтэй харьцуулахад үхрийн ястай мах 6800 буюу 63 хувь, хонины ястай мах 4900 буюу 57 хувь, ямааны ястай мах 2850 төгрөг буюу 44.50 хувиар тус тус хямд үнэтэйгээр худалдаалагдаж байна.

Гурил дээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай.

Засгийн газрын 2022 оны гурил, махны үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх зарим арга хэмжээний тухай 174 дүгээр тогтоолоор Аж ахуйн нэгжийн төлөх хүүг жилийн 3 хувийн хүүтэй байхаар шийдвэрлэсэн боловч Монголбанкны Мөнгөний бодлогын хорооноос эдийн засаг, банк санхүүгийн зах зээлийн нөхцөл байдал, гадаад, дотоод орчны төлөв, эрсдэлийг эрсдэлийг харгалзан 2022 оны 6 ба 9 дүгээр сард бодлогын хүүг 3 нэгж хувиар нэмэгдүүлж, 12 нэгж хувь болгон өсгөсөн тул зээлийн суурь хүү өсөх, эх үүсвэрийн зардал нэмэгдэх эрсдэлээс болгоомжлон арилжааны банкнууд тус хөнгөлөлттэй зээлд оролцох боломжгүйгээ илэрхийлсэн учраас Засгийн газраас нэмэлт тогтоолыг оруулсан. Ингээд 436 дугаар тогтоолоор гурил үйлдвэрлэгч аж ахуйн нэгжийн төлөх зээлийн хүүг 6 нэгж хувь болгон нэмэгдүүлсэн. Үүнтэй холбогдуулан 2022 оны 12 сарын 20-ны өдрөөс эхлэн Хаан, Худалдаа хөгжил, Голомт гэсэн 3 арилжааны банкаар 50 аж ахуй нэгжид нийтдээ 35.2 тэрбум төгрөгийн зээлийг олгосон. Манай улс 2022 онд 349.8 мянган га талбайгаас 393.6 мянган тонн улаан буудай хураан авснаас гурил үйлдвэрлэлд 193 мянган тонн Хөдөө аж ахуйг дэмжих санд 21.9

мянган тонн, нийт 214.9 мянган тонн хүнсний улаан буудай гурил үйлдвэрлэн хүн амын хэрэгцээнд нийлүүлэх боломжтой байна.

Одоогоор гурилын үйлдвэрт 49.2 мянган тонн, Хөдөө аж ахуйг дэмжих санд 33 мянган тонн, үүнээс 11 мянган тонн нь 2021 оны ургац байгаа. Нийт 82.2 мянган тонн хүнсний улаан буудай болон 20.8 мянган тонн гурилын нөөцтэй байгаад гурилд шилжүүлэн тооцоход 4.2 сарын нөөцтэй байна. Олон улсад үүсээд байгаа хурцадмал байдал ковид цар тахлын дараах хямрал улс хоорондын ачаа тээврийн урсгал удааширалт зэргээс үүдэн газар тариалангийн үйлдвэрлэлд зайлиггүй шаардлагатай үр, бордоо, ургамал хамгааллын бодисыг зохистой хэмжээгээр хэрэглээгүй. Мөн цаг уурын нөхцөл байдал зэргээс шалтгаалан сүүлийн 2 жилд хураан авсан хүнсний улаан буудайн чанар доогуур үзүүлэлттэй буюу 70-80 орчим хувь нь 3, 4 дүгээр ангиллынх байна.

Иймд 2023 оны ургацын улаан буудайн гурил гарах хүртэлх хугацаанд хүн амын хүнсний хэрэгцээт гурилын нөөц бүрдүүлэх мөн гурилыг чанаржуулах зорилгоор 50 мянган тонн сайн чанарын хүнсний улаан буудайг импортлохыг Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлөөс Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны сайдад зөвлөмж болгосон.

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн тухайд бол хүнсний гол нөгөө нэрийн бүтээгдэхүүний нөөц 2023 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн байдлаар авсан судалгаагаар Улсын хэмжээнд 2.5 мянган тонн малын мах үүнд нөөцийн мах мах ороогүй байгаа. 65.7 мянган тонн гурил, гурилан бүтээгдэхүүн, 8.2 мянган тонн төрөл бүрийн будаа 0.2 мянган тонн хуурай сүү, 1.1 сая ширхэг өндөг, 6.6 мянган тонн ургамлын тос 24.1 мянган тонн төмс 39.8 мянган тонн хүнсний ногоо, 17.5 мянган тонн элсэн

чихэр, 0.5 мянган тонн давсны нөөцтэй байна.

Энэхүү нөөцийг хоногоор тооцвол хүнсний зохистой хэрэгцээнд тулгуурлан хүнсний нөөцийг тооцвол мах махан бүтээгдэхүүний нөөц 8 хоногийн нөөцтэй. гурил гурилан бүтээгдэхүүний нөөц 87 хоногийн нөөцтэй төрөл бүрийн будааны нөөц 61 хоног, хуурай сүүний нөөц 5 хоног, өндөгний нөөц нэг хоног, ургамлын тосны нөөц 107 хоног, төмсний нөөц 75 хоног, хүнсний ногооны нөөц 57 хоног, элсэн чихрийн нөөц 1988 давс 18 хоногийн нөөцтэй байна. Энэхүү нөөцийн судалгааг аймаг бүрийн ХАА-н газар дээрх тусгай бас программаар бид бүхэн бас 7 хоног тутам гаргаж байна.

Судалгаанд Улаанбаатар хот хөдөө хөдөө орон нутгийн худалдааны зах, төв дэлгүүрүүд, хүнсний үйлдвэрүүд дэх хүнсний нөөцийг хамруулсан. Нийслэл, орон нутгийн мухлаг, жижиг дэлгүүр, айл өрхийн түвшинд хадгалсан нөөц мөн хөдөө орон нутгийн төмс хүнсний ногооны жижиг зоорины нөөц ороогүй болно.

Дотоодын гурилын үйлдвэрүүдийн агуулахын улаан буудайн нөөцийг гурилд шилжүүлж тооцсон ийм мэдээлэл байгаа.

Мэдээлэл танилцуулж дууслаа.

Ц.Цэрэнпунцаг: Дараагийн мэдээллийг сонсьё. Тэгээд сүүлд нь ажлын хэсгийн танилцуулчихъя.

Одоо Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга Баяраа танилцуулга хийнэ. Хэдэн номер байна? Ажлын хэсгийн нэг номерын микрофоныг нээе.

М.Баяраа: Байнгын хорооны дарга гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Улаанбаатар хотын Ерөнхий менежер Баяраа.

Нөөцийн махны борлуулалттай холбоотой мэдээллийг товч хийе.

Хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх нийлүүлэлтийг тогтворжуулах зорилгоор Засгийн газрын 2022 оны гурил, махны үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх зарим арга хэмжээний тухай 174 дүгээр тогтоолын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас бэлтгэн нийлүүлэгч 12 аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, нийслэлийн хүн амын 2023 оны хаврын улирлын махны хэр хэрэгцээнд зориулан хонины мах 5587.9 тонн үхрийн мах 1738 тонн, ямааны мах 533 тонн, нийт 7858.9 тонн махыг бэлтгэн нөөцөлсөн. Нөөцийн махыг худалдаанд гаргах бэлтгэл ажлыг 2023 оны 2 дугаар сарын 10-ны өдрөөс эхлүүлж дараагийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байгаа. Хүн амын тоо нягтарилыг харгалзан нөөцийн махны худалдан борлуулах хүнсний дэлгүүрийн судалгааг шинэчлэн 9 дүүргийн хэмжээнд 481 хүнсний дэлгүүрээр нөөцийн мах худалдан борлуулахаар агентын гэрээг байгуулсан.

Хоёрт болохоор бэлтгэн нийлүүлэгч аж аж ахуйн нэгжүүдийн мах савлах уут, хаяг шошгыг бэлэн байдлыг хангуулж зураасан кодын мэдээллийг нийслэлийн татварын газарт хүргүүлж ажилласан.

Гуравт нийслэлийн 9 дүүргийн 481 хүнсний дэлгүүрийн удирдлага менежерүүдэд, 2 сарын 28-наас 3 сарын 3-ны өдөр нийслэлийн Татварын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, мал эмнэлгийн газартай хамтран сургалт зохион байгуулж, бар код таниулах, НӨАТ-аас чөлөөлөх тохиргоо хийж хөргөгч хөлдөөгчийг хүрэлцэхүйц хэмжээгээр бэлтгэн жин хэмжүүрийг баталгаажуулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байгаа.

Дөрөвт нь бэлтгэн нийлүүлэгч 12 аж ахуйн нэгжийн түгээлтийн 43

тээврийн хэрэгсэл замын хөдөлгөөний дугаарын хязгаарлалтгүй оролцох зөвшөөрлийг олгуулж авто тээврийн товчоодоор нэвтрэхэд хураамжаас чөлөөлүүлэх нөөцийн махны түгээлтийг саадгүй тасралтгүй ялгах нөхцөл боломжоор хангасан.

Бэлтгэл ажлыг хангуулсны үндсэн дээр нөөцийн махны худалдааг 3 сарын 15-ны өдрөөс 9 дүүргийн 481 хүнсний болон сүлжээ дэлгүүрээр үхрийн ястай махыг нэг килограммд 10700 төгрөг, хонины ястай махыг 8600 төгрөг, ямааны ястай махыг 6400 төгрөгөөр худалдан борлуулж эхэлсэн. Мөн нөөцийн махны өргөтгөсөн худалдааг 2023 оны 4 сарын 8-ны өдрөөс эхлэн 7 хоног бүрийн амралтын өдрүүдэд 4 удаа буюу 8 өдөр 33-35 байришилд, 4 сарын 17-ны өдрөөс ажлын 5 өдөрт 6-10 байришилд байнгын худалдааг зохион байгуулж байгаа. Өргөтгөсөн худалдаагаар нийт 695 тонн буюу 31500 ширхэг хонины гулууз махыг нэг килограммыг нь 8300 төгрөгөөр худалдан борлуулсан байгаа.

Нийт борлуулалт 5 сарын 2-ны байдлаар 1151 тонн, нийт бэлтгэсэн 7858 тонн махны 14.7 хувьтай байна. Үүнээс өргөтгөсөн худалдаагаар 695 тонн буюу 60 хувийг 481 хүнсний дэлгүүр болон сүлжээ дэлгүүрээр 456 тонн буюу 39.7 хувийг бол худалдан борлуулсан байгаа. Нөөцийн махны нийлүүлэлт, хүртээмж, чанар, аюулгүй байдал Улаанбаатар хотын ерөнхий менежерийн баталсан удирдамжийн дагуу Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Нийслэлийн Мал эмнэлгийн газар дүүргүүдийн Засаг даргын тамгын газар, татварын хэлтэст хамтран байнгын хяналт 50 ажиллаж байгаа. Нөөцийн махны хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр өргөтгөсөн худалдааг 7 хоног бүрийн амралтын өдөр 33-35 байришилд зохион байгуулж байгаа хэдий ч бэлтгэн нийлүүлэгч 12 аж ахуйн нэгжийн 8 аж ахуйн нэгж нь машин техник хүн хүчний

хүрэлцээ хангалтгүй байгаагаас нэг удаадаа 50-150 гулууз авчирч 2-оос дээш рейс хийж чадахгүй байна.

Ажлын өдрүүдэд нөөцийн махны худалдааг борлуулж буй хүнсний дэлгүүр болон сүлжээ дэлгүүрт түгээлт хийж байгаа тул бэлтгэн нийлүүлэгч 3-4 аж ахуйн нэгжийг нэг өдөрт 5-6 байршилд гарч байгаа ч мөн л машин техник хүн хүчний хүрэлцээгүйгээс тоо бас тогтворгүй байгаа. Зах зээл дээр махны үнэ өсөж буй гол шалтгаан нь ихэнх аймаг сумдад өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрч, мал туранхай байгаагаас шинэ махны нийлүүлэлт багассантай холбоотой гэж үзэж байгаа. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд өргөтгөсөн худалдааны цагийн хуваарийг 10-16 цаг байгааг нэг цагаар сунгаж 10-17 цаг болгож уртасгаж нэмэлт авто машинаар олон удаагийн рейс хийх, махны нийлүүлэлтийг сайжруулах.

Хоёрт болохоор амралтын өдрүүдэд гаргаж буй өргөтгөсөн худалдааны байршилын тоог арваар нэмэгдүүлж 45-д хүргэх,

Гуравт, өргөтгөсөн худалдааны хяналтыг сайжруулж ченж нарт болон бусад замаар худалдуулахгүй байхад анхаарч дүүрэг хорооноос хяналт тавих, нарийвчилсан хуваарь гаргаж мөрдүүлэх,

Дөрөвт, дэлгүүрүүдийн захиалга, нийлүүлэлт, борлуулалт тавих хяналтыг эрчимжүүлэх,

Тавд, өргөтгөсөн худалдааны борлуулалт хийх, нэмэгдүүлэх зорилгоор нэг өдөрт 10 рейс хийх, 2-2.5 тонны даацтай бүхээгтэй машин түрээслэх, өдөрт 2.5 сая төгрөг, 5-6 дугаар сарын амралтын өдрүүдэд нийт 10-16 удаа өргөтгөсөн худалдаа зохион байгуулахад нийт тооцоолж үзэхэд 40 сая төгрөгийг нийслэлээс өөрсдөө шийдэж явахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийг танилцуулъя.

Б.Батдаваа Үндэсний статистикийн хорооны дарга, Г.Энхтайван Монголбанкны дэд ерөнхийлөгч, Н.Ганхөлөг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дэд сайд, Д.Ган-Очир Монголбанкны эдийн засагч, Д.Довчинсүрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга байна уу? Ц.Уртнасан Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга, М.Баяраа Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга, Д.Эрдэнэцэцэг Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн албаны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга, Б.Мөнхханд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Ц.Тэрбиш Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах зар сурталчилгааны газрын дарга, Л.Амар Монголбанкны холбооны гүйцэтгэх захирал, А.Нарантуяа Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга, Т.Тунгалаг Мал эмнэлгийн Ерөнхий газрын Мал амьтны эрүүл мэндийн газрын дарга, М.Оюунжаргал Үндэсний статистикийн хорооны Үндэсний статистикийн хэлтсийн дарга, Ч.Ариунтуяа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл хангамжийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Д.Отгонжаргал Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Ургамлын гаралтай хүнсний үйлдвэрлэл хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн.

Танилцуулгатай холбоотой асуулт асууж үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Аубакир гишүүнээр, Тэмүүлэн гишүүнээр тасаллаа.

Ингээд Баттөмөр гишүүн асуултаа асууя.

Б.Баттөмөр: Энд ч шийдвэр гаргадаг барьдаг хүмүүс байна уу, үгүй юү? Бид чинь юу сонсоод байна дарга? Энэ сайд нар нь хаачсан юм бэ? 70, 71 сая мал тоолуулсан тэгээд махныхаа асуудлыг гучин хэдэн жил шийдэж чадсангүй дээ. Махныхаа асуудлыг шийдэж чадахгүй макро, микро эдийн засаг яриад давхиад байдаг. Хөрсөн дээрээ буумаар байна шүү дээ нөхдүүд. Тэгээд л нэг сонин сонин л юм ярьцааж байна даа. Төвөгтэй байна шүү дээ энэ чинь. Энэ ард иргэдийн энэ инфляцаар дамжиж ард иргэдийн карманаас суйлж байгаа мөнгө замаа алдсан шүү дээ. 2020, 2021, 2022 оны инфляц хэдэн хувийн инфляцтай байгаа вэ?

Энд хариулаач. Энэ инфляцаас болоод ард иргэдийн карманаас хэчнээн төгрөг гарсан бэ? Энийг одоо тооцож байгаа юмнууд байна уу үгүй юү? Бүгдийг нь хувьд шилжвэл сайхан болно. Төр татвар аваад хөгждөг юм гэж байгаа юм. Яах вэ ер нь болно. Сонгодог эдийн засгийн онолоор тэгж ярьж болох байх. Гэхдээ Монгол Улс чинь өнөөдөр хүртэл зах зээлийн эдийн засагтаа бүрэн шилжиж чадаагүй байна шүү дээ. Хувийн хэвшилд хэтэрхий их эрх чөлөө өгөхөөр хувийн хэвшлийн монопол буцаад тогтдог. Тухайлбал гурилын үйлдвэр. Гурилаар тогтчихсон байж байгаа шүү дээ. 1400 төгрөг байж байгаад 2200, 2300 төгрөг болчихсон байж байгаа шүү дээ. Эм, хуурамч эм, дээрээс нь эмийн монопол эмийн үнэ ийм л байгаа шүү дээ.

Тэгээд 1 хэдэн хүн энд орж ирээд суугаад байдаг шийдвэр гаргах юу байдаггүй. Тэр сайд дарга нартай нь ярьсан нь дээр байлгүй дээ Засгийн газар дээр маш сайн ярьж ер нь энэ нэг хэдэн хүн биш энэ Засгийн газрын энэ холбогдох улсууд нь энд орж ирж ярих хэрэгтэй. Тэр саяын миний хэлсэн инфляц тэгээд инфляцаас алдсан нь ард иргэдийн карманаас алдсан мөнгө хэд байгаа вэ?

Хэн хариулах юм? Энэ асуултад хариулт авъя.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгээс Баттөмөр гишүүний асуусан асуултад хэн хариулах вэ? Монголбанкны дэд ерөнхийлөгч Энхтайван 3 номерыг нэе. Баттөмөр гишүүний асуусан асуултад хариулъя.

Г.Энхтайван: Инфляц 2023 оны 1 дүгээр улирлын төгсгөл 3 дугаар сард Улсын хэмжээнд 12.2 хувьтай байгаа. Улаанбаатар хотод 12.1 хувьтай байгаа. 4 дүгээр сарын байдлаар инфляц бол 12.1 хувиас бас тодорхой хэмжээгээр бага зэрэг буурч 11.1-11.4-ийн хооронд гарах болов уу гэсэн хүлээлттэй байна. Тун ойрын хугацаанд 4 дүгээр сарын инфляцыг Үндэсний статистикийн хорооноос зарлах байх. Инфляц ер нь одоо ингээд үндсэндээ 22 дахь сардаа дараалаад 2 оронтой тоонд буюу өндөр инфляцтай явж байна. Төв банкны зүгээс өнгөрсөн жил инфляц ард иргэдийн халааснаас хэдий хэмжээний төгрөг авч одсон бэ? Хэдий хэмжээний зардал өрхийн амьжиргаан дээр туссан бэ гэдэг дээр бол тодорхой хэмжээний судалгааг бол хийсэн. Инфляц дунджаар 15 орчим хувьтай байлаа гэхэд манай Улсын GDP-ийн 66-68 орчим хувь нь өрхийн эдийн засаг дээр суурилж байгаа. Яг ингээд яг энэ тооцоо хийгээд үзэхээр ойролцоогоор бол 3.5-4 их наяд төгрөгийг инфляцаар дамжиж ард иргэдийн буюу өрхийн амьжиргаанаас алга болсон гэсэн товч судалгаа байгаа.

Тэгэхээр инфляцыг богино хугацаанд яаралтай нам доор түвшинд барих Төв банкны зорилтот түвшинд энэ оны төгсгөлийн улирал буюу эсвэл дараа оны эхний улиралд багтааж инфляцыг нам доор түвшинд аваачих энэ ондоо багтаагаад инфляцыг нэг оронтой тоонд оруулах зайлиггүй бодлогын авч хэрэгжүүлэх үндсэн арга хэмжээ болоод байгаа. Тэгээд Төв банк бол энэ дээр шат дараатай бодлогын арга хэмжээнүүдийг аваад ажиллаж байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Баттөмөр гишүүн нэмж асуулт асууя.

Б.Баттөмөр: Чи нэг жилийнхийг ярьж байна. Миний сүүлийн 3 жилийн хугацаанд бол 13, 14 орчим их наяд төгрөг иргэдийнхээ карманаас инфляцаар дамжуулаад авчихсан байж байгаа шүү дээ бид нар. Би бол тэгж тооцож байна. Та нар шалгаж үзээрэй. Тийм тоо байгаа шүү. 13 орчим их наяд төгрөг. Өрхийн орлого өнгөрсөн жил эдийн засаг нь 4.8 хувиар өссөн нөгөө гадаад худалдаа 3.8 тэрбум долларын ашигтай гээд байдаг. Тэгтэл өрхийн орлого нь 0.7 хувиар өсчихсөн. Арван хэдэн хувийн инфляцтай. Үгүй ээ тэгээд яаж энэ Монгол хүн Монголд яаж амьдрах юм бэ энэ чинь. Амьдрах боломжгүй болчихсон байна шүү дээ.

Ц.Цэрэнпунцаг: Дахиж нэмж хариулчаад дахиад та тодруулаад асуучих. Саяын тоо баримт хэллээ шүү дээ Баттөмөр гишүүн. Сүүлийн 3 жил дээр нэг ийм тооцоо байна гээд. Статистикаас энэ дээд тал дээр бид нар Батдаваа дарга та мэдээлэл байна уу? Энд статистикийн мэдээлэл нэмээд өг дөө. Сүүлийн 3 жилд бэлэн мэдээлэл байвал сүүлийн 3 жилд инфляц тооцоход тийм өрхийн орлого сүүлийн 3 жил яаж өссөн юм. Сүүлийн 3 жилийн инфляц ямар байсан юм? Ингээд нэг харьцуулаад статистик мэдээлэл өгөөдөх.

Хоёр номер. Ажлын хэсгийн 2 номерыг нээгээрэй.

Б.Батдаваа: Улсын Их Хурлын эрхэм гишүүн Баттөмөр даргын асуултад хариулъя.

2020 оноос буюу сүүлийн 3 жилийн хугацаанд Монгол Улсад хэрэглээний сагс буюу үнийн түвшин дунджаар 3 сарыг өнөөдрийн энэ жилийн 3 сар хүртэл бол 34 хувь өсчхөөд байгаа. Энэ дотроо хамгийн их өсөлттэй явж байгаа бүтээгдэхүүн гэх юм бол хүнсний бүлгийн үнийн өсөлт байгаа. Хүнсний бүлэг

нийтдээ 56 хувиар 2020 оны эхнээс хойш өнөөдрийг хүртэл өсчихсөн байгаа. Энэ маань өөрөө өрхийн хэрэглээний зардал дээр ямар дарамт учруулж байна вэ гээд харахаар Үндэсний статистикийн хорооноос өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа гэж гаргадаг байгаа. Энэ судалгаанаас үзэхэд бол дунджаар нэг өрх сардаа 10 орчим килограмм мах 12 килограмм гурил, тэгээд өндөг, талх гээд иймэрхүү бүтээгдэхүүнүүд хэрэглэдэг гэж үзээд ингээд тооцоод үзэхээр ерөнхийдөө нэг жараад.

Ц.Цэрэнпунцаг: Батдаваа дарга гүйцээгээд хариулчих. 2 номер дээр гүйцээгээд хариулчих.

Б.Батдаваа: Өрхийн хүнсний хэрэглээний зардал дээр бол нэг 60-аад хувь буюу одоо 100 гаруй мянган төгрөг сар болгон зардал дээр нь дарамт болж орж ирж байна гэдэг тийм статистик мэдээлэл гарч байгаа. Энэ маань өөрөө өрхийн орлогын харилцан адилгүй байдал дээр янз бүрээр нөлөөлж байгаа. Бид нар статистикаас харахад хамгийн өндөр орлоготой бүлгийн өрхүүдийн дунджаар зардлын 8 хувийг хүнсний бүтээгдэхүүний зардал эзэлдэг бол бага орлоготой өрхүүд дээр энэ маань 30 гаруй хувь болоод явчихдаг. Энэ дотроо мах, гурилын хэрэглээ бол тэр хүнсний зардлынх нь бараг 70 орчим хувь руу дөхөөд ирдэг ийм зүйлтэй байгаа. Жил бүрийн хувьд инфляцын түвшин бас харилцан адилгүй бүтээгдэхүүнээр яаж байна? Энэ жилийн хувьд бол махны үнэ нэлээн өндөр үзүүлэлттэй явж байна. Малын хорогдол оны эхнээс нийт малын 0.8 хувь буюу 900 гаруй мянган мал хорогдсон нь бас нийлүүлэлт талд тодорхой хэмжээний нөлөө үзүүлж байгаа болов уу гэж харж байна. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Баттөмөр гишүүн тодруулж асууя.

Б.Баттөмөр: Асуусан асуултад гүйцэд хариулахгүй байна. Батдаваа

чамд тоо чи мэдэж байгаа шүү дээ. 34 хувийн үнийн өсөлт үүссэн. Хэдэн төгрөг иргэдийн карманаас гарсан бэ, нэмж. Энэ тоо л асуугаад байгаа шүү дээ би. Би бол 13 орчим их наяд төгрөг миний тооцооллоор тэгж байгаа юм. Та нар ямар тооцоо байна? Албан ёсны тоо байна уу? Монголбанкн дээр уг нь байх ёстой доо.

Ц.Цэрэнпунцаг: Энхтайван
Монголбанкнаас хариулъя. 3 номер.

Г.Энхтайван: Өнгөрсөн оны ДНБ-ий хэмжээ бол Улсын хэмжээнд нэг 48 орчим их наяд төгрөг байгаа. Энэ дээрээс яг статистик тооцоогоор аваад үзэхээр өрхийн эдийн засаг буюу өрхийн сектор бол ойролцоогоор ДНБ-ий 66-аас 68 хувийг эзэлж байгаа. Тэгэхээр энэ нь ойролцоогоор 32 орчим их наяд төгрөгийн өрхийн сектор байна гэсэн үг. Тэгэхээр 32 их наяд төгрөг дээр дунджаар 15 хувийн инфляц тооцохоор бол жилдээ Монгол Улсын нийт иргэдийн халааснаас 4 их наяд орчим төгрөг байгаа. Одоо аваад явчхаж байгаа гэсэн үг. Сүүлийн 3 жил дээр нь ингээд тооцоод үзэх юм түрүүн Батдаваа даргын хэлсэнчлэн жилийн 3 жилийн инфляц 34 хувьтай гэхээр бол ойролцоогоор ингээд тооцоод үзэхээр бол 12-14 орчим их наяд төгрөгийг өрхийн сектороос авч явсан гэж ойлгож болно.

Ц.Цэрэнпунцаг: Баттөмөр гишүүн та хариултаа бүрэн авах шиг боллоо. Тийм ээ. Тэгээд ер нь Баттөмөр гишүүнийг тэр нэг иймэрхүү багцаатай нэг байгаа байх гээд түрүүн тоог хэлсэн. Сая Монголбанкны дэд ерөнхийлөгч Энхтайван бас баталж хэлж байх шиг байна шүү. Тэгээд ямар хэмжээтэй энэ инфляц ард иргэд дээр энэ өрхүүдэд ямар хэмжээтэй ачаалал дарамт болж ирж байгааг та бүхэн тэгээд эндээс тодорхой сайн мэдэж байгаа.

Дээрээс нь сая түрүүн Батдаваа дарга ярьсан. Энэний чинь ялангуяа орлого багатай өрхүүдийн үндсэндээ

орлогынх нь 20 гаруй хувь нь мах, гурил 2 дээр явчхаж байна шүү дээ. Тэгээд өнөөдөр мах гурил хоёрынх нь үнэ өсөөд байгаа. Тэгээд л энэ дээр чинь л бид нар Их Хурлын гишүүд энэ дээр бас зах зээл энэ худалдаагаар яваад л үзэхэд л энэ мах гурил 2 үнэ өсчихсөн өсөөд л байна. Өдөр тутам 7 хоногоор өсөж байна гэж байна. Тэгэхээр энэ дээр яаж бодлого шийдвэр арга хэмжээ авах гэж байгаа гэж та бүгдээсээ асуух гээд өнөөдөр дуудсан яамны сайд алга байна.

Дээрээс нь дахиад энэнээс үргэлжлүүлж цаашидаа ер нь Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам эд нар ер нь ямар бодлоготой ямар арга хэмжээ авах гэж байгаа юм? Бас тодорхой хариултууд ард түмэн хүсэж байгаа байх гэж санаж байна. Ямар арга хэмжээ авах гээд байгаа юм. Энэ мэдээж Монголбанкны дэд ерөнхийлөгч та хэлж байна. Яаралтайхан шиг энэ инфляцаа буулгаж авчраад хэдхэн хоног нэг оронтой тоонд оруулаад тэгээд доош нь аваад ирэх гэж л зүтгэж байна гэж байгаа юм. Энэнийг чинь хүлээж байх хооронд энэ чинь ард түмэн хэцүү байна шүү дээ. Нэг давхар дан оронтой тоо руу оруулаад ирэх бол хэзээ бол гээд л оны багцаа л яриад байгаа шүү дээ. Ондоо багтаагаад л гээд л. Би одоо 2, 3 удаа сонссон юм. Ингээд цаашаа ярилцлаа. Ингээд Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Өнгөрсөн бүтэн сайн өдөр хэдэн гишүүд захуудаар явсан үнийн өсөлттэй холбоотой асуудлууд, гол нэрийн бараа бүтээгдэхүүнүүд хэдэн хувьтай, ямар хэмжээтэй үнэ нь өсөж байгаа. Инфляцын хэмжээ ер нь ямаршуу байна гээд энэ дээр яг бодит байдал дээр нь очиж танилцъя гээд явсан л даа.

Тэгээд энэ нэг их айхтар мэдэхгүй дээ ч биш ер нь тодорхой асуудал шийдэл гаргахын тулд бас урьдчилаад газар дээр нь очоод бас нэг биечлэн танилцсан нь дээр гэдэг утгаар Улсын Их Хурлын дарга үүрэг даалгавар өгөөд явсан болов

уу гэж бодож байгаа юм. Тэгээд та хэдээс биднээс нэг тодорхой хэмжээний асуудлууд шийдвэр гаргаад гол нь шийдэл чухал шүү дээ. Тэртээ тэргүй ард иргэд дээр хүндрэл байгаа гэдэг нь ойлгомжтой. Энэ бүтээгдэхүүний өсөлт байгаа нь ойлгомжтой.

Тэгэхээр энэ яамдууд ер нь яг юу бодоод байгаа юм. Яг юу хийж чадах юм. Тэрийгээ нэг хариулаад өгөөч. Сая зүгээр л танилцуулга явчихлаа.

Баахан аж ахуйн нэгжүүдэд 100, 140 тэрбум төгрөгүүд өгсөн юм байна 3-6 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлүүд өгсөн юм байна. Энэ мах гурилынхаа үнийг тогтворжуулах гээд өгсөн юм байна. Тэгээд нэг асуулт байгаад байна. Хагас жилийн өмнө байсан махны үнэ хэд байгаад, одоо хэд болсон, гурилын үнэ хагас жилийн өмнө хэд байгаад одоо хэд болсон. Яг юун дээрээс л өсөөд байгаа юм.

Цаашидаа яг ямар арга хэмжээ авах юм? Энэ дээр энэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамныхан хариулаадхаач. Бид бол яах вэ Улсын Их Хурлын гишүүд тодорхой бодлогууд гаргаж ирээд, Улсын Их Хурлаас тогтоолууд гаргаж ирээд явж байгаа шүү дээ. Засгийн газар дээр үүрэг даалгавруудыг чинь өгөөд явж байгаа. Засгийн газар чинь тодорхой хэмжээний мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлээд явж байгаа. Өөрөөр хэлбэл та нар. Тэгээд бид яах юм. Мянга одоо хаихичаад ер нь яах юм? Эцсийн эцэст гүйцэтгэгч нь бол та нар байгаа биз дээ. Тэгээд та нараас бодлого гарч ирэхгүй та нараас зүгээр танилцуулга гараад хөвөөд ингээд сайхан албан тушаал хашаад загнаад сайхан цэрэг, дарга нар яваад ер нь ямар хэрэг байгаад байгаа юм?

Тийм болохоор наад дэд сайд мэдэхгүй энэ залуу хүүхэд хэзээ орж ирсэн билээ? Жил боллоо гэвэл үү энэ чинь саяхан томилогдсон уу. Тэгэхдээ ер нь бол энэ ажил хариуцаж байгаа хүмүүс

хэлээдэх дээ. Яг өмнө чинь ямар байж байгаад одоо ямар арга хэмжээ авах гээд байгаа юм? Юунаас болоод өсөөд байгаа юм. Цаашидаа өсөх юм уу, өсөхгүй юм уу? Өснө гэж байгаа бол одоо энэ ард түмнийхээ өмнө шууд хэл л дээ. Тэр сайд чинь байхгүй байгаа хойгуур чи өөрөө хариуцаад нэгэнт орж юм чинь хэлмээр байна. Энэ чигээрээ яваад байна гэж байгаа бол одоо хэдүүлээ зарлая. Бид нар үнийн өсөлтийг барьж чадахгүй гэдгээ. Барьж чадна гэж байгаа бол арга хэмжээ ямар арга хэмжээ авах юм тэрийгээ л хэлээдэх л дээ. Тэгээд хариултад юу яачхаад дахиад тодруулъя.

Ц.Цэрэнпунцаг: Ж.Бат-Эрдэнэ гишүүн маш тодорхой асуулт асуусан шүү. Хагас жилийн өмнө ямар байсан юм, ямар зөрөө байна, одоо ямар болчихоод байгаа юм?

Дээрээс нь энэ учир шалтгаанууд нь юунаас болоод ингээд өсөөд байгаа юм бэ гээд. Ингээд өсөөд тэр учир шалтгааныг нь зөв тодорхойлчихсон байгаа яг ямар арга хэмжээ авах гэж байгаа юм байна гээд ийм 3 тусдаа асуулт байна шүү. Ажлын хэсгийн 4 номер. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дэд сайд Ганхөлөг.

М.Ганхөлөг: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

Хүнс, хөдөө аж ахуйн яамны зүгээс энэ гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбогдолтой хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг аваад ажиллаж байгаа тухай би танилцуулгад дурдсан. Махан дээр гол бас энэ үнийн өсөлтийн эсрэг гол бид бүхний авч байгаа ажил бол энэ махны нөөцийн мах бэлтгэлийн ажил байгаа. Цаашидаа бол энэ нөөцийн мах бэлтгэлийн ажлын хувь түгээлтийг нийслэлтэй хамтран зохион байгуулж байгаа цэгүүдийн тоог нэмэгдүүлэх. Мөн үүнтэй холбогдолтой тээврийн асуудал бусад энэ зохион байгуулалтын асуудлууд

дээр нэн тэргүүнд анхаарч ажиллана гэдэг тухай бас танд хэлэхээр байна.

Махны үнэ нэмэгдэж байгаа хэд хэдэн гол шалтгаанууд байгаа. Өнгөрсөн жилийн хувьд өвөлжилтийн бэлтгэл байдал цас нэлээн ихтэй бас хүндэвтэр ийм өвөлжилтийг бид бүхэн давсан байгаа. Үүнтэй холбогдолтой төл алдалтын байдал нэлээн өндөр ийм хэмжээнд гарсан. Мөн жил болгоны хаврын үеүдэд махны үнэ өсөж байгаа. Өнгөрсөн жилийн нөөцийн махны дундаж үнэлгээтэй нэлээн тэнцүү байдлаар энэ жилийн бас үнүүд гарсан гэдгийг бас та бүхэндээ бас хэлье.

Цаашидаа нөөцийн махны нэг юу нэмэгдүүлэхээсээ гадна энэ дамжуулан худалдаалж байгаа ченжүүдийн энэ далд эдийн засгийг нэлээн илрүүлэх энэ чиглэл дээр бас хамтран ажиллах энэ ажлуудыг бас нэмэгдүүлэх шаардлагатай гэж бас яамны зүгээс тодорхой шийдэл саналуудыг бас хэлмээр байна. Мөн дээрээс нь малчдын хувьд илүү бэлчээрийн гэхээсээ илүүтэй ийм фермерийн аж ахуй жилийн 4 улирлын энэ аж ахуйг хөгжүүлэх энэ чиглэлийн суурь асуудлуудыг бас шийдэх нэн шаардлагатай. Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас өнгөрсөн 2022 оны 10 сараас эхлэн махны экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр нэлээдгүй олон арга хэмжээнүүдийг бас авч ажиллаж байгаа. Үхрийн махнаас бусад махан дээр үндсэндээ квотгүйгээр үндсэндээ экспортод гаргаж байна.

2022 оны тухайн үеийн нийт дүнгээс 2023 оны эхний улирлын дүн давсан ийм үзүүлэлттэй гараад явж байгаа. Энэ нь бас махны үнэ дээр нэмэгдэх ийм үр дүнгүүд бас гарч байгаа. Гурилын хувьд бол нийт орцыг бүрдүүлж байгаа хэд хэдэн ер нь олон улсын түвшиндээ хүнсний бүтээгдэхүүний үнэ ковид цар тахал болон энэ Оросын, Украйны энэ дайнтай холбогдолтой тээвэрлэлтийн асуудлууд дээр нэлээн өндөр ийм өөрчлөлтүүд гарч яг улаан

буудай үйлдвэрлэх энэ үед шаардлагатай байгаа тээврийн асуудал, мөн дээрээс нь орц найрлага бордоо, үр ургамлын бодисын асуудлууд бас нэмэгдсэнтэй шууд хамааралтай ийм үзүүлэлтүүд бас байгаа.

Тухайн үед үр тариа тариалах үеийн тээвэрлэлтийн асуудал мөн дээрээс нь бензин шатахуунтай холбогдолтой энэ асуудлуудаас үүдээд яг одоо нэгж улаан буудайг үйлдвэрлэх энэ зардлууд өссөнтэй холбогдолтойгоор улаан буудайн үнэ бас өсөөд байгаа. Одоо дэлхийн жишгийн хувьд ч гэсэндээ ийм бас байдалтай байгаа. Улаан буудайн үнийг бууруулах чиглэлээр хэд хэдэн удаагийн зээлийн төслүүдийг санаачлаад ингээд зохион байгуулсан. Өнгөрсөн жилийн хувьд бол 5 аж ахуйн нэгжид 35.2 тэрбум төгрөгийн зээлийг олгосон. Энэхүү зээлийг бас тодорхой хугацаанд хугацааны хувьд бас оройтсон ийм асуудлууд бас манай яаман дээр бас байгаа. Цаашидаа нэлээн эртнээс энэхүү шийдвэрүүдийг дагаж хэрэгжүүлэх шаардлагуудтай. Илүү олон банкнуудыг хамруулах бид бүхэн бэлтгэсэн төлөвлөсөн энэ зээл олголтынхоо бас тодорхой дүнд хангалттай бас зээлээ олгож чадаагүй ийм асуудлууд бас яаман дээр байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Ганхөлөг сайдаа тэгээд л яах вэ баахан оношоо л тавьж байх шиг байна. Зүгээр яах вэ би одоо бас Бат-Эрдэнэ гишүүн нэмээд асууна тийм ээ. Тодорхой хариулсангүй шүү. 3 асуудлыг тойроод л буудаад байх юм. Энэ 2023 онд энэ хавар төрж байгаа төл энэ махны үнэ нэмэгдэхэд ямар хамаатай юм бэ? Энэ хавар төл гарахаар яах гэж байсан юм. Мах бэлдэх гэж байсан юм уу? Тийм энэ чинь энэ махны үнэ нэмэгдэхэд 2023 оны бид нар энэ 5 сард махны үнэ ярьж байхад энэ 2023 онд төрөх гэж байгаа төл тэнд ямар нөлөө үзүүлчихсэн юм. Та нар оношоо ингэж тогтоож байвал ерөөсөө яаж энэ асуудлыг шийдэх вэ дээ.

Ж.Бат-Эрдэнэ гишүүн нэмэлт асуултаа асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Сайд нарыг нь дуудаж байж хариултуудаа авч байж яг ямар бодлого барих юм гэдгийг нь ярихгүй бол зүгээр хэдүүлээ цаг алдаад л байна л даа. Тэгээд ажлаа мэдэж байгаа ч амьтан алга. Мэдэхгүй байгааг чинь ч мэдээд л байгаа юм л даа. Ажлыг ингэж хийдэггүй л байхгүй юу даа. Яг махны үнээ барихын тулд юу хэрэгтэй юм. Ерөөсөө надаа ойлголт өгсөнгүй шүү дээ. Тээврийн асуудал ярих шиг болоод далд эдийн засгаа өөрчилнө гээд хэлчих юм. Далд эдийн засаг гэж яг юуг хэлээд байгаа юм. Юу нь болохгүй байгаад байгаа юм. Юу нь болохгүй болоод энэ нөөцийн махан дээр чинь энэ далд эдийн засгийн асуудлууд юуны махны үнэ нэмэгдэж байгаа тэр далд эдийн засаг чинь яг яаж нөлөөлөөд байгаа юм.

Хоёр дугаарт эдийн засгаа ерөнхийдөө мал аж ахуй тал руугаа нэлээн сайжруулъя гэж байх шиг байна. Жоохон дөхүүлээд хаячих шиг боллоо. Тэгээд энд чинь ямар бодлогууд байх юм. Тэгж байж.

Ц.Цэрэнпунцаг: Түрүүн Ж.Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асуухдаа хугацаагаа гүйцээгээгүй учраас Бат-Эрдэнэ гишүүнд 3 минут өгье. Асуултаа гүйцээж асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Нөөцийн махыг сайжруулна гээд тэгж байна. Ойлголтоор бол нөөцийн мах сайжруулаад ихэсгэсэнээрээ махны үнийг барьчих юм шиг л сая надад бол тийм л ойлголт өгөх шиг боллоо. Нөөцийн махныхаа асуудлуудыг яаж сайжруулах гээд байгаа юм.

Хоёрдугаарт нөөцийн махтай холбоотой асуудал чинь нэлээн хүнд байгаа шүү. Бид нарыг очиж үзэж байхад тэр Хүчит шонхор зах дээрээс ноднин жил бөөндөөд бөөндөөд тэр хуушуурны мах гэж нэрлэдэг юм байна

лээ. 3 дугаар зэрэглэлийн мах, хуушуурын мах, бүх хуушуурын махыг бүгдийг нь ченжүүд юунууд худалдаж аваад нөөцийнхөн худалдаж аваад явсан гэж байна лээ. Энийгээ мэдэж байгаа юу? Тэгээд бид нар тэр наад нөөцийн мах зарж байгаа газар чинь очсон шүү дээ. Үгүй ээ цөөхөн л хэдэн хүмүүс тэрийг чинь авдаг юм байна лээ шүү дээ. Ер нь гологдол махнуудыг л бид нар нөөцөд бэлдээд байгаа шүү дээ. Жилийн жилд ярьдаг шүү дээ. Тэгээд энийгээ яаж сайжруулах юм? Энэ мэнийхээ дотоод учир холбогдлыг нь ерөөсөө гаргаж ирж та нар чинь ярихгүй байгаад байна шүү дээ. 8 мянгаар зарж байгаа, 10 мянгаар зарж байгаа нөөцийн махнууд чинь хэдээр зарагдаад хэдээр зүгээр мөнгө угаагдаад яваад байгаа юм тэнд.

Гэтэл тэнд жинхэнэ аж ахуйн нэгжүүд нийлүүлж болох бололцоотой. Өөрийн гэсэн үнэхээр гайхалтай сайхан, намраараа шахуу, хөлдүү сайхан махнууд тэнд байж л байна шүү дээ. Тэгээд нөөцийн мах тэр хувийн хэвилийн өөрсдийн бэлтгэж байгаа мах хоёрын чинь хооронд тэнгэр газар шиг ялгаатай байгаад байна шүү дээ. Нөөцийн мах гэдгийг чинь эсвэл зүгээр шууд зарлачихъя. Нөөцийн мах буюу 3 дугаар зэрэглэлийн мах гээд хэдүүлээ тэгвэл зарлачихъя л даа. Яагаад нөөцийн мах чинь тэгвэл нэгдүгээр зэрэглэлийн, хоёрдугаар зэрэглэлийн, гуравдугаар зэрэглэлийн гээд эсвэл зэрэглэл зэрэглэлээрээ байж болдоггүй юм эсвэл. Тэгээд энэ гурилтай холбоотой асуудал дээр ерөөсөө тээвэр өслөө гээд нэг дуугарчих шиг байна.

Тээвэр чинь харин хямдраад байгаа шүү дээ уг нь бол. Тэгээд ерөөсөө учир холбогдлууд чинь гарч ирэхгүй байгаад байна шүү дээ. Тэгэхээр чинь яаж асуудал чинь цаашаа явах юм бэ энэ чинь. Тэгээд дахиад тайлбар хэлэх юм болов ууу, яах бол.

Ц.Цэрэнпунцаг: Хаанаас нэмж хариулах уу? 4 номер нэмээд хариул.

Шууд тодорхой асуудлуудаа ярь. Тойруулаад тэр танай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны ажлын төлөвлөгөө ямар жилийн төлөвлөгөө сонсох гэж байгаа биш. Тодорхой бид нар ямар ямар асуудлууд байгаа юм? Ингээд асуудлууд дээр нь бид нар мах, гурилын үнэ ялангуяа ингээж нэмэгдээд байна гээд энийг яагаад ингээд нэмэгдээд байгаа юм бэ гээд бид нар энд учрыг нь олох гээд сууж байна шүү дээ. Тэгээд 2 сая Бат-Эрдэнэ гишүүн асуулаа шүү дээ. Саяын тэр тээвэр чинь үнэ нь буугаад байдаг. Тэгээд яагаад нэмэгдээд байна? 4 номер гүйцээж хариулъя.

М.Ганхөлөг: Ойлголоо нөөцийн махтай холбогдолтой Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Нөөцийн махны бэлтгэлтэй холбогдолтой асуудал дээр бол бид бүхэн тухай бүрд нь бас чанарын шаардлагуудыг бас шалгаад яг гарч байгаа худалдаалж байгаа цэгүүд дээр, мэргэжлийн байгууллагуудтайгаа очиж бас ажиллаж байгаа. Тэгээд ямар нэгэн байдлаар Сав баглаа боодлын болон хадгалалтын аюулгүй байдал алдагдсан энэ тохиолдолд бид байнгын 109 дугаар дээр тусгай бас ийм өргөдөл гомдлуудыг хүлээж авч тэр даруйд нь шийдвэрлээд явж байгаа. Өнгөрсөн 3 удаагийн 35 орчим цэгүүд дээр худалдаалсан цэгүүд дээрх энэ гомдол өргөдлүүд бас яг Бат-Эрдэнэ гишүүний яг танилцуулж байгаагаас арай өөр байдалтай бас байгаа. Харьцангуй энэ жилийн нөөцийн мах бэлтгэлийн үр дүн энд бас иргэд олон нийт бас эерэг ийм сэтгэлгээтэй байгаа гэдгийг би бас тодруулж хэлье. Энэ дээр бол нэг бүрчлэн үндсэндээ бас ажиллаад гаргасан асуудал гомдлыг бол тухай бүрд нь шийдвэрлээд манай бас салбарын хяналтын газрынхан ажиллаад бас явж байгаа гэдгийг хэлмээр байна.

Гурилын үнийн өсөлт дээр холбогдолтой тээврийн асуудал дээр бол үндсэндээ гаднаас орж ирж байгаа үр, будаатай холбогдолтой, ургамал хамгааллын бодистой холбогдолтой энэ тээврийн асуудал удааширах техникийн

хугацаандаа орж ирж багтахгүй байх энэ зүйлүүд бас үндсэндээ бас нэлээн гол нөлөөллүүдийг үзүүлж байгаа тухай салбарынхан бас энэ танилцуулж байгаа.

Тэгээд энэ утгаар нь би бас тэр тээвэр тээврийн асуудлыг бас дурдаж танилцуулсан. Цаашидаа бол үндсэндээ хүнсний хувьсгалын хүрээнд бол Хүнс, хөдөө аж ахуйн яам бол өөрөө яг бие дааж тодорхой үйлдвэр байгуулах энэ аж ахуйн нэгжүүдтэйгээ өрсөлдөх энэ ажлуудыг үндсэндээ зохион байгуулахгүйгээр банкнуудаар дамжуулж энэ зээл, зээлийн татаасуудыг олгох энэ ажлуудыг зохион байгуулаад явж байгааг та бүхэн маань мэдэж байгаа. Эдгээр ажлуудын бүх ажлууд бол үндсэндээ зах зээлийн өрсөлдөөнийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх энэ чиглэлийн томоохон суурь асуудлуудыг үндсэндээ харсан ийм ажлууд байгаа. Арилжааны банкнууд дээрх зээлүүд олгогдоод эхэлсэн байгаа. Ингэснээрээ бол бид бүхний гол зорилго болсон мах бэлтгэлийн энэ бас үйлдвэрүүд илүү бас өргөжих энэ боломжууд бүрдэх энэ ажлууд хийгдээд ингээд явна гэж бас ойлгож болно.

Ц.Цэрэнпунцаг: Сая бас арилжааны банкнуудаараа дамжуулж зээл гаргаад байгаа гээд байсан. Энэтэй холбоотой ярьсан учраас арилжааны банкнуудын гүйцэтгэх захирал холбооны гүйцэтгэх захирал Амар захирал сууж байна тэ? Ямар зээлүүд, ямар ямар банкнуудаар хэчнээн төгрөг хааш нь өгчихсөн юм бэ? Мах, гурил, үнэ тогтворжуулах хууль хийсэн юм шүү дээ. Бид нар чинь хууль хийсэн хуультай гээд л хуулиа гаргачихсаны үр дүн нь гараад тэр хууль яаж үйлчилж байна гээд хуулийнхаа араас явахаар зэрэг яг чухам энэ нь тэрний үр дүн юм болов уу гээд гялтайж гялайхаар юм байхгүй байна шүү дээ. Тэгээд хэчнээн төгрөг хаанаас хаашаа гараад явчихсан юм. Ямар компаниуд гурилын компаниуд, ямар махны компаниуд тэр мөнгийг нь авсан юм. Нэр устай нь хэлээд өг.

Ажлын хэсгийн 3 номерыг. Ажлын хэсгийн 3 номер.

М.Ганхөлөг: *Цэрэнпунцаг гишүүний асуултад тодруулъя.*

Энэ гол нь Нэрийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийг тогтворжуулах тухай хуулийн 5.1.1 дээр мах, гурилын нөөц бүрдүүлэх, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах болон бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгжид эргэлтийн хөрөнгөд шаардагдах хөнгөлөлттэй санхүүжилтийг арилжааны банкны өөрийн эх үүсвэрээр олгох гэсэн тийм заалт байгаад байгаа.

Тэгээд яг энэ хүрээнд бол яг энэ хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд төв банкнаас хөрвөх чадвар сайтай активыг урт хугацаат репо арилжаагаар мөнгөжүүлэх замаар нөөцийн мах бэлтгэл дээр банкны эх үүсвэрийг дэмжиж ажилласан байгаад байгаа. Яг энэ хүрээнд бол Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 9 дүгээр сард 239 дүгээр тушаалаар нийлүүлэлтийн тасалдлаас үүсэж болзошгүй инфляцаас сэргийлэх үүднээс 63.3 тэрбум төгрөгийг урт хугацаат репо арилжаагаар махны бэлтгэн нийлүүлэгч нарт олгосон байгаад байгаа. Мөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголбанк хамтраад гурилын нөөц бүрдүүлэхэд зориулаад арилжааны банкны эх үүсвэрээр олгогдох зээлийн хүү болон зээлдэгчийн төлөх хүүгийн зөрүү 3.75 тэрбум төгрөгийн татаасыг арилжааны банкнуудад олгох нөхцөлтэйгөөр 35.2 тэрбум төгрөгийг 5 аж ахуйн нэгжид нэг жилийн хугацаатай олгосон байгаад байгаа.

Тэгээд яг энэ хууль маань өөрөө батлагдахдаа бол арилжааны банкны эх үүсвэрээр олгох гэдэг. Хуулийн ерөнхий концепцтой байсан учраас энэ дээр Төв банк арилжааны банкнуудтайгаа хамтраад арилжааны банкнуудын эх үүсвэрийг энэ чиглэлд ажиллахад нь

бодлогын дэмжлэг үзүүлэх хэлбэрээр бид бүхэн ажилласан байгаад байгаа. Тэгээд ер нь бол аж ахуйн нэгжүүдийн жагсаалтыг тухай бүрд нь холбогдох байгууллагуудад бид бүхэн хүргүүлэхэд бэлэн байгаад байгаа. Мөн хөдөө аж ахуйг дэмжих зээлийн хүрээнд эрүүл мэндээ хамгаалах эдийн засгаа сэргээх 10 их наядын хөтөлбөрийн хүрээнд хөдөө аж ахуйг дэмжих зээлийн хүрээнд бол нийтдээ 789.3 тэрбум төгрөгийн зээлийг 22 мянга гаруй зээлдэгчдэд олгосон байгаад байгаа. Үүнээс 97.6 тэрбум төгрөгийг махны нөөц бүрдүүлэх зорилгоор 25 зээлдэгчид олгосон. 46 тэрбум төгрөгийг гурил, тэжээл, ургамлын тосны зориулалтаар 9 зээлдэгчид олгосон байгаад байгаа. Малчдыг дэмжих зээл дээр 199 тэрбум төгрөгийн дүнтэй, 19870 малчинд зээл олгосон байгаад байгаа.

Мөн хүнсний хувьсгалын хүрээнд бол дараагийн зээлийн арга хэмжээг арилжааны банкнуудтай хамтраад авч хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Энэ дээр 2023 ондоо нийтдээ 1 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгоно. Энэ дээр Засгийн газрын зүгээс хүүгийн дэмжлэг 135.5 тэрбум төгрөгийг олгож явна. Энэ дээр бол 13 хувийн хүүгийн дэмжлэг бол олгогдоод явна гэсэн үг. Энэ дээр арилжааны нийт банкнууд 10 банк энэхүү хөтөлбөрт хамрагдаад явж байгаа. Одоогоор бол зээл судлагдаад явж байгаа байх. Ер нь бол арилжааны банкууд энэ дээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа.

Ц.Цэрэнпунцаг: *Аубакир гишүүн асуултаа асууя. Үгүй ээ арилжааны банкнууд тэгнэ л дээ 135 тэрбум төгрөг татвар төлөгчдийн мөнгөөр хүүг нь авах гэж байгаа юм чинь ер нь тун идэвхтэй гүйж л байж таараа. Энэ нэр ус тодорхой юмнуудын дараа гишүүд дахиад үргэлжлүүлээд асуух байх шүү. Та нар наад мэдээллээ бэлтгэж байгаарай.*

Аубакир гишүүн асуултаа асууя.

Т.Аубакир: Баярлалаа. Энэ үнийн өсөлт бас хэрээс хэтэрч байна л даа. Ард иргэдийн ахуй амьдрал асар хүнд байгаа. Бид нар бас гишүүд чинь бас нэг хэдэн сонгогчидтойгоо тойрог юман дээрээ очоод яг л айл амьтнаар ороод л хоршоо захаар нь ороод л явдаг л даа. Ард иргэдийн амьдрал үнэхээр хүнд байгаа. Бухимдахаас өөр арга байхгүй. Манай ажлын хэсгийн нөхдүүд ингээд судалгаа хийгээд л ороод ирсэн байна л даа. Хайран ч цаас тийм ээ. Бодвол гадаад, дотоодод сүрхий сургууль төгссөн л залуучууд байдаг байлгүй. Бид нарт яг ингээд нэг тоон статистик гаргаад ирэхээсээ илүү нэг бодлогын чанартай юм яриад ороод ирвэл энд сууж байгаа Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороод үргэлж нээлттэй байдаг шүү дээ. Хаалга үүд үргэлж нээлттэй, хэн ч, юу ч ярьж орсон бид нар үргэлж гарц гаргалгаа эрж хайж явдаг ийм Улсын Их Хурлын гишүүд байхгүй юу. Иймэрхүү судалгааг нэг чамбайхан айлын эхнэр ч хийчихнэ л дээ. Хилтэй амтай зах хоршоогоор их ордог айлын эхнэрүүд гурил тэдэн хувиар өсчихсөн байна, мах тэгчихсэн байна шүү гээд л ороод ирдэг л судалгаа л даа.

Бид нар эндээс гарц гаргалгаа яримаар байгаа юм. Хөдөө аж ахуйн дэд сайд ярьж байна л даа. Улаан буудайн үнийг бууруулахад бид нар зээл олгож байгаа тээврийн асуудал эд нар гаргалгаа биш ээ. Улаан буудайн үнэ бол энд зээл аваад эргэн нэг бол тээврийн ложистикийн асуудал шийдээд улаан буудайн үнэ буухгүй шүү дээ. Улаан буудайн үйлдвэрлэгчид бүх зүйлээ гаднаас импортоор авч байгаа. Хэрэглэж байгаа техник, сэлбэг хэрэгсэл, хор бордоо, гербицид, шатахуун бүгдийг нь бид нар гаднаас үнэтэй импортоор авч байгаа юмаар яаж хямдхан будаа үйлдвэрлээч ээ гээд шахах юм бэ? Улаан буудайн үнэ өснө гурилын үнэ өсөх нь тодорхой. Мянган төгрөгөөр авсан будаагаараа 1200 төгрөгийн гурил хийж байж зарж байж гурилын үйлдвэрүүд чинь амьдрах ёстой. Энэ гарц гаргалгаа биш л дээ. Бид

нар яг энэ хажууд байж байгаа Орос улс чинь өөрсдөө техникээ, шатахуунаа, хор бордоо, гербицидээ, сэлбэг хэрэгслээ өшөө дээр нь маш өндөр үржил шимтэй газар дээр тариад улаан буудай авч байгаа. Манайх шиг ийм эрс тэс уур амьсгалтай.

Тийм учраас энэ дээр гаргалгаа ярьж орж ирмээр байна залуучуудаа. Одоо сайд нартайгаа ярьдаг юм уу, яадаг юм. Бид нар Хөдөө аж ахуйн яамнаас ийм реформын чанартай юм хийх гэж байгаа юм. Эдийн засаг, хөгжлийн яам бид нар ингэж байна гээд ороод ирмээр байна шүү дээ. Шагираад суугаад байгаа ч юм шиг. Гишүүд нь өөрсдөө зах янз бүрийн юмаар яваад үнээ хүртэл судлаад одоо энэ сэтгүүлчид нь хүртэл гурилын үнэ асуугаад л махны үнэ асуугаад. Үгүй ээ мэдэхгүй хүн байж болно шүү дээ ер нь бол. Заавал нэг попрохдоо би энийг цээжилчихье гээд цээжлээд гүйгээд байх юм уу. Ер нь тийм учраас энэ дээр гаргалгаа янз бүрийн юмнууд яриад орж ирмээр байна. Жишээлбэл өнгөрсөн жил цементийнхээ үнийг алдсан манай Монгол Улс. Бас л цаг хугацаандаа Засгийн газраас нь байдаг ч юм уу холбогдох яам нь асуудал оруулж ирээгүй. Одоо яг энэ барилгын сезон эхлэх гэж байна. Дотоодод үйлдвэрлэж байгаа цементийн үнэ ийм байна.

Тийм учраас импортынх нь татвараар ингээд тохируулгыг нь хийе ээ гэдэг саналыг аль хэдийн гаргаад л явж байх ёстой. Гэтэл энэ ганцхан тэр Эрээний цаана байж байгаа Цементийн үйлдвэрийн чинь үнэ манайх хоёр чинь газар тэнгэр шиг ялгаатай байна шүү дээ. 600 мянган тонн цемент үйлдвэрлэж байхаар 300 мянгыг үйлдвэрлээд л үнэтэй зарах л асуудал. Энэ бүх тохируулга дээр залуучуудаа та нар л хийх ёстой.

Тийм учраас ингээд нэг нь асуугаад нөгөөдөх нь хариулж байгаа ч юм шиг нэг ийм асуудал. Бид нар мах үнэтэй байна, мал үнэтэй байна гээд үгүй энэ чинь малчин Аубакирын хонийг

би 200 мянгаар зарах гэж байна гэхэд нь үгүй ээ чи 100 мянгаар өг гэж бас болохгүй. Үгүй ээ малчдын бас л ахуй амьдрал шүү дээ. Энэ зуд зурхан энэ их үнэтэй хивэг тэжээлийн ард жишээлбэл өнөөдөр Баян-Өлгий аймагт нэг шуудай хивэг чинь Улаанбаатараас 2 дахин өндөр үнэтэй. Яагаад тэр бүс нутгийнх нь хивгийнх нь импортын татварт жоохон тохируулга хийгээд цаанаас оруулаад ирье. 1700 километр Улаанбаатараас хивэг зөөж байхаар цаанаас нь зургаан зуухан километр Горно Алтайскаас зөөчих ийм боломж байна гээд. Жишээлбэл яагаад тохируулга юмыг нь хийчихье гээд санаачилгатай ажилладаггүй юм бэ залуучуудаа.

Улсын Их Хурал сайд нар нь ингээд л юм яриад л байдаг, яриад л байдаг, яг дунд шатныхан дээр л очоод.

Ц.Цэрэнпунцаг: Аубакир гишүүн нэмж асуулт асууя.

Т.Аубакир: Яг дунд шатныхан дээр л очоод л гацдаг байхгүй юу. Яагаад гэвэл яг дунд шатны та бүхэн сайд нартаа мэдээлэл өгдөг. Бид нарт та нар мэдээлэл өгдөг. Тийм учраас залуучуудаа жоохон ажилламаар байна. Бүгдээрээ л гадаад дотоодод төгссөн мундаг л гунигтай л залуучууд л харагддаг юм байна лээ. Үгүй ээ та нар энэ чинь энэ улсын төлөө ажиллах ёстой шүү дээ. Тэгээд л чичлүүлж зүхүүлдэг нь энэ хэдэн сайд нар.

Тийм учраас залуучуудаа жоохон ажил хиймээр байна. Яг иймэрхүү судалгаа энэ тэрээр энүүгээр явахгүй. Энүүгээр явахгүй шүү дээ. Монголбанк жишээлбэл энэ дээр дүгнэлт хийх хэрэгтэй. Юмны үнэ өсчихлөө гээд л цалингаа нэмэх асуудал бид нар яриад явж байна. Юмны үнэ өслөө цалин нэмэгдлээ инфляц чинь дахиад л хэлбэлзэнэ. Ингээд л нэг ийм гинжин ийм л асуудал бид нар уул нь яриад байгаа юм. Та нар залуучууд минь жоохон юм

бодитой л хандмаар байна даа. Одоо жишээлбэл тэр хивэгний асуудал. Одоо энэ барилгын сезон эхлэх гэж байна энэ цементийнхээ татвар энэ тэрийг аль хэдийн яриад явж байх ёстой шүү дээ. Минийх асуулт биш санал даргаа.

Ц.Цэрэнпунцаг: Аубакир гишүүн санал хэллээ.

Тийм ээ хамгийн гол шаардаад байгаа санал нь байна шүү дээ. Шийдэлтэй ямар шийдэлтэй энэ асуудлыг яаж шийдэх гэж байгаа юм гээд ороод ирсэн. Өнөөдөр хүн бүхэн хэлсэн хэлээгүй мэдэж байна шүү дээ. Юмны үнэ нэмэгдчихээд байна энийг яаж шийдэх гэж байгаа юм болоо яах гэж байгаа юм ийх гэж байгаа юм бол гээд та бүгдээс ийм хүсэлт ийм хариултыг нь сонсох гээд бүгд хүсээд байна шүү.

Тэмүүлэн гишүүн асуултаа асууя.

Г.Тэмүүлэн: Яах вэ өнөөдөр бид хэд бас энэ Эдийн засгийн байнгын хороон дээр гол ярьж байгаа зүйл маань гол эдийн засгийн бодлого барьдаг Байнгын хороон дээрээ эдийн засгийнх нь бодлогоор ер нь бид нар яах ёстой юм бэ гэдэг асуудлыг л гаргаж ирэх гээд байгаа юм. Тэгээд үндсэндээ Сангийн яамныхан байхгүй байна. Эдийн засгийн яамныхан байхгүй байна. Сайд дарга, Төрийн нарийн бичиг, газар хэлтсийн дарга нар нь уг нь энд бодлогоо яримаар байх юм. Бид нарын ярих гээд байгаа асуудал эргээд энэ чинь амьдрал хүнд байна шүү дээ. Иргэдийн амьжиргаа орлого хүнд байна. Бизнесийн үйл ажиллагаанд хүндрэлүүд байна. Татварын ачаалал дарамтууд байна.

Тэгээд энэ гишүүдийн ярьж байгаа зүйлүүд л ер нь зүгээр яах вэ өнөөдрийн нөхцөл байдал, амьжиргаа, орлого хүнд байгаа учраас энэ жолоодлогогүй инфляцынхаа нөхцөл рүү орчих вий дээ л гэсэн болгоомжлол байгаад байгаа юм. Бид нар унтаад байж болохгүй. Эдийн засаг хүнд байгаа

цаг үе дээр. Гарц гаргалгаа шийдэл ирмээр байгаад байгаа юм. Яах вэ, өдөр тутмын амьдрал, амьжиргаа гээд ярихаар гол нэрийн бараа бүтээгдэхүүн, гурил, махны үнийн өсөлт, дизель түлшний үнэ гээд л хөдөө гээд л ялгаагүй л нэг асуудлууд байгаад байгаа юм.

Улсын Их Хурлаас энэ нийлүүлэлтийн тасалдал үүсэхээс чинь сэргийлсэн, үнийн өсөлт үүсэхээс чинь сэргийлсэн, хомсдол үүсэхээс сэргийлсэн энэ уг нь бодлого шийдвэрийг хангалттай гаргачихсан байхгүй юу. 2022 оны 6 сард буюу бараг одоогоос жилийн өмнө Улсын Их Хурлаас энэ хөрөнгө санхүүг нь шийдүүлж өгсөн. Улсын төсөвт суулгасан. Төр нэг талдаа ингээд оролцоод, интервенц хийгээд, санхүүжилтийг нь шийдүүлээд яваад байдаг үр дүн нь амьдрал дээр хэрэгжихгүй болчихоод байгаа юм.

Хэрэв тэгвэл төр ингэж оролцож интервенц хийж чадахгүй байгаад байгаа юм бол бид нар яах ёстой юм бэ? Хувийн хэвшилд нь тавиад хувийн хэшилээ дэмжээд явах эсрэгээрээ иргэдийн амьжиргаа орлогыг дэмжсэн инфляцтай уялдуулсан бодлогуудыг гаргаад явах ёстой юм уу, амьжиргааны орлогыг нь дэмжих бодлого юу байх ёстой юм бэ? Цалин, тэтгэвэр, тэтгэмж нь хүрэхгүй байна гэдэг асуудлууд.

Бизнесийн үйл ажиллагаатай холбоотой хүндрэл гээд аваад үзэхээр одоо ерөөсөө өнөөдөр үүсэж байгаа бүх зүйл дээр л гол номер нэг асуудал валютын л асуудал байгаад байгаа юм. Ханишийн асуудал. Сүүлийн 2 жил хангалттай өссөн. Эрс өссөн. Бууж байгаа зүйл байхгүй байгаад байна. Тэгээд л нөгөө нэг бараа бүтээгдэхүүн оруулж ирж байгаа, импортоор оруулж ирж байгаа аж ахуйн нэгж болгон дээр чинь л ачаалал болж байна. Хил гаалиар оруулж ирнэ.

Дараагийн том асуудал авлигын асуудал. Мэргэжлийн хяналт, гааль жижиг тэр бараа бүтээгдэхүүн оруулж ирж байгаа аж ахуйн нэгж болгон, хувь хүн болгон дээр чинь асуудал чирэгдэл хүндрэл үүсгээд байна л гэдэг асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр бид нарын хувьд энэ асуудлууд дээр нэгдсэн нэг шийдэл гаргая. Төсөв байна уу, татвар байна уу энэ бүх бодлогыг тодорхойлж гаргаж оруулж ирэх ёстой байгууллага чинь Засгийн газар байгаад байгаа юм. Татварын ачааллаа судалсан юм уу, дарамтыг нь судалсан юм уу нийгмийн даатгалын шимтгэл, нэмэгдсэн өртгийн албан татвар ч гэдэг юм уу энэ асуудлууд дээр яах ёстой юм бэ бид нар. Энийг л ярь гээд байгаа. Тэгээд Байнгын хорооны дарга ярья гэхээр Эдийн засгийн яам, Сангийн яам энийг асуудал хариуцсан байгууллагуудтайгаа бид нар бас яг асуудлуудаа яримаар байна. Улсын Их Хурал гаргасан бодлого шийдвэр эдийн засгийн энэ эрсдэлээс хүндрэл үүсэхээс сэргийлсэн энэ бодлого шийдвэрийнхээ хэрэгжилтүүдийг бас эргэж яримаар байна. Үр дүнтэй болж байна уу болохгүй байна уу? Энэ дээр үнэлэлт дүгнэлт өгмөөр байна.

Том зургаараа бид нар цаашидаа ер нь яаж энэ үнийн өсөлтөөс сэргийлэх бодлогыг ер нь хийх ёстой юм гэдэг нэг дүр зургаа гаргаад, зоригтой шийдэл гаргаад ингээд нэг явахгүй бол ингэж унтаа баймааргүй байна л гэдэг асуудал ярих гээд байгаа юм. Одоо тэгэхээр би зүгээр нэг талдаа энийг асуух асуулт бол их алга. Үндсэндээ төрөөс бид нар жишээ нь жишээ болгоод л би хэлж байгаа юм л даа. Хүнсний үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, газар тариалан, мал аж ахуй үйлдвэрийн салбарууд бид нар Улсын Их Хурлын тогтоолоор 2023 оны төсөв дээр нэг их наяд төгрөгийн хөнгөлөлттэй зээл. Тэдгээрээс Засгийн газрын хүүгийн дэмжлэгт 135.5 тэрбум төгрөг олгохоор төлөвлөөд Улсын төсөвт суулгачихсан. Энэ үр дүнтэй байна уу, үгүй юу. Аж ахуйн нэгж банкуудаас зээл авч байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Нэмэлт нэг минут.

Г.Тэмүүлэн: Энэ чиглэлийнх нь аж ахуйн нэгж байгууллагууд тэр иргэд чинь энэндээ хамрагдаж чадаж байна уу үгүй юу? Яг очоод хөдөө орон нутагт гэдэг юм уу эсвэл тэр суман дээр баг дээр хороон дээр очоод ярихаар би өөрөө үйлдвэрлэл эхэлдэг энэ чиглэлээр чинь ажилладаг надад тэр чинь бол ирэхгүй байна, хүртээмжгүй байна аа, бид нар тэгээд тэрийг чинь шалгуур шаардлагыг нь хангаж дийлэхгүй байна л гэдэг асуудал яриад байгаа юм.

Тэгэхээр бид нарын бодлого чинь хөрсөн дээрээ буухгүй байна. Үнэ бүтээгдэхүүн чинь нөлөөлөхгүй байна, хомсдол эрсдэлийг хамгаалж чадахгүй байна л гэдэг асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр шийдэл яримаар байна Байнгын хорооны дарга.

Тэгэхээр тусдаа одоо яг Эдийн засгийн яам, Сангийн яам хамтраад энэ шийдлээ ярья. Болохгүй байгаа бол, асуудал байгаа бол энэ асуудлуудаа ярья. Гарц гаргалгааг нь шийдлийг нь. Тэгээд дахиж зарлах юм уу яах юм. Одоо энэ дээр нэг тийм шийдлийг бид нар Улсын Их Хурлаас тодорхой энэ дээр шийдэл гаргахгүй бол иргэдийн амьжиргаа, орлогыг дэмжих, аж ахуйн нэгж байгууллагуудын бизнес үйл ажиллагаанд нь хүндрүүлж явж байгаа асуудлуудыг шийдэх шийдлийг ямар ч байсан гаргах ёстой гэж харж байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Тэмүүлэн гишүүн тодорхой саналууд хэллээ. Ер нь түрүүн ч Аубакир гишүүн хэлсэн. Бат-Эрдэнэ гишүүн хэлсэн. Хамгийн гол нь өнөөдөр орж ирээд яг асуудал ийм байна, тодорхой байна. Энэний гол нь оношилж тодорхойлсон тэр онош нь юу гэж оношилж байгаа юм бэ? Учир шалтгаан нь хаана байна гээд асуусан. Тэрэн дээр ингээд тойруулаад л ингээд ганц нэг ийм хариулт авлаа. Тэгэхдээ хамгийн гол нь гарц, гаргалгаа, шийдэл нь хаана байгаа юм бэ гээд.

Тэгэхээр өнөөдөр ийм бүрэлдэхүүнтэй бид нар та бүхэн тэнд суучаад бид бүхэн энд суугаад Засгийн газар маань ямар шийдэл бодолтой энийгээ энэ асуудал байгаа гэж үзэж байгаа бол энийгээ ингэж шийдэх гэж байгаа гээд нэг юм бид нарт хариулчих хүмүүс хэрэгтэй байна л даа. Одоо та хэд хариулахааргүй юм байна ер нь бол. Энийг цааш нь үргэлжлүүлж бид нар энэ асуулга, энэ мэдээллээ авах, энэ үйл ажиллагаагаа үргэлжлүүлж явуулах ёстой юм байна гэж дүгнэлт хийж байна.

Ингээд Батлут гишүүн асуултаа асууя.

Д.Батлут: Асуулт алга.

Ер нь гишүүдтэй ижил байр суурьтай байгаа. Тэгээд Улсын Их Хурал, Засгийн газраас уул нь тодорхой алхмууд аваад байгаа юм. Тэгээд нэг үг дамжуулж чихнээс чихэнд үг дамжуулж тоглодог тоглоом байдаг шүү дээ тийм ээ. Тэгээд нэг үг хэлэнгүүт хамгийн сүүлийн үр дүн ямар гардаг билээ. Зүгээр яг тийм л болчхоод байгаа байхгүй юу одоо. Тэгэхээр бид нар энэ дунд доод шатандаа хариуцлагын тогтолцоогоо нэлээн өндөржүүлэх ажлын гүйцэтгэл тал дээр санал санаачилга тал дээр нэлээн ахиц гаргах зайлшгүй шаардлага байгаа юм. Та бүхэн бодоод үзээрэй. Энд зүгээр хуулийн хэрэгжилттэй холбоотой тайлан мэдээллүүд л орж ирсэн байна. Өдөр болгон телевиз хэвлэл мэдээллийн байгууллагаар энэ мэдээллүүд явж байгаа. Яг үнэндээ Аубакир гишүүний хэлдэгчлэн бол овсгоотойхон айлын авгай гаргачхаар тоон мэдээллүүд яг үнэндээ.

Тэгэхээр бид нар арай өөр зүйл хүсэж байна л даа. Бид өнөөдөр нөхцөл байдлаа хэрхэн дүгнэж байгаа юм бэ? Махны үнэ өссөн байна, гурилын үнэ өссөн байна. Яг юунаас болсон юм бэ. Ямар учир шалтгаан байна гэж тэр шалтгааныг нь тодорхой болгочхоод түүнийг шийдэх арга зам нь ийм байна

гээд тодорхой санал санаачилгатай байх юм бол илүү тодорхой үр дүнгүүд гарна гэж харж байгаа.

Өнөөдөр үндсэндээ Улаанбаатар хотод бүгд төвлөрчихсөн байна. Алслагдсан аймгууд дээр магадгүй Улаанбаатар хотоос илүү давсан үнэлгээ үнийн инфляц явагдсан байхыг үгүйсгэхгүй. Түүн рүү харсан тодорхой үйл ажиллагаа чиглэлүүдээ хэрхэн зохион байгуулах юм. Бид нар боомтын сэргэлт гээд зөндөө, маш сайхан зүйлийг хийх гэж хичээж ярьж байгаа шүү дээ. Энэнтэй уялдуулсан хил хязгаар дээр, боомт дээр тухайн бүс нутгаас нь тэр импортын бараа бүтээгдэхүүнүүдийг нь авдаг, оруулж ирдэг үнийн өсөлт багатайгаар нийлүүлэх боломжуудыг хангадаг ч гэдэг юм гэдэг юм уу гээд. Үгүй ээ, бодоод, сэтгээд, хараад байвал маш олон гарц гаргалгаа байгаа гэж харж байгаа юм. Харамсалтай нь тийм гарц гаргалгаа хайж ажиллахгүй байгаа нь өнөөдөр нэг ингээд цаас хөөж ажиллаад байгаа нь бидний дутагдал байна. Яг энд сууж байгаа гишүүдийг бас тэгээд нэг асуудал тавьсан асуудлынх нь хүрээнд нэг цаасаар хуурна гэж байгаа бол бас тийм биш.

Бид нар чинь бас тойрог дээрээ энд тэнд очиж, иргэдтэй уулзаж байгаа, ярилцаж байгаа. Бас ч гэж болох болохгүй асуудлуудыг нь ойлгож байгаа гадарлаж байгаа.

Тийм учраас энэ дээр нэг жоохон эргэлт гаргамаар байгаа юм аа, манайхан залуучууд аа. Төрийн ажилд нэг мэргэжил боловсрол гээд л их дээд сургууль олон гадаад дотоод төгссөн гээд л юм яриад байдаг. Тэрнээсээ илүүтэй сэтгэл их чухал байдаг юм шүү дээ. Сэтгэл төрийн ажилд. Төрийн ажилд сэтгэл гаргаж ажиллаж байж л тодорхой үр дүн гардаг гэдгийг сайн ойлгож авах хэрэгтэй байгаа. Одоо та бүхэн статистик гээд л хар л даа. Статистик тоон мэдээлэл чинь яг хэр бодитой юм бэ өнөөдөр. Тэр мэдээлэл

цуглуулж байгаа орон зай чинь өөрөө хэр бодитой цуглуулж өгч байгаа юм бэ?

Мэдээлэл цуглуулж байх явцад ямар хүндрэлүүд гараад байгаа юм? Тэгвэл тэр хүндрэлүүдийг даван туулах ямар урамшууллын механизм шаардлагатай байгаа юм бэ гээд. Энэ чинь хууль, эрх зүйн хүрээнд ч гэсэн шийдэх олон асуудлууд байгаа шүү дээ. Өнөөдөр нийгмийн төлөөлөл мэдээлэл статистик. Тэгээд энэ статистикийн мэдээлэл маань үнэн зөв байж байж цаашидаа илүү зөв төлөвлөлтүүд илүү зөв хөрөнгө оруулалтууд гэдэг юм уу ингээд улс орны хөгжилтэй холбоотой юм ярих байхгүй юу. Гээд бид нар энэ асуудал дээрээ ч гэсэн тодорхой хэмжээний.

Ц.Цэрэнпунцаг: Батлут гишүүн нэмж нэг минут өгье. Нэмж асуулт асууя.

Д.Батлут: Дор хаяж бид нар энэ статистикийн мэдээ мэдээлэл цуглуулж байгаа асуудал дээрээ ч гэсэн анализ хийгээд хэр бодитой байгаа вэ гэдгээ ч бид дүгнэж чадахгүй байгаа шүү дээ. Би орон нутагт ажиллаж байсан хүн сайн мэдэж байна наадхыг чинь. Ямар байдлаар статистик мэдээллүүд цуглагдаж ирдэг вэ гэдгийг ч зүгээр зах зухаас нь мэднэ хэлнэ. Тэгээд энэ Батдаваа дарга ч гэсэн энэ дээр анхаарах хэрэгтэй шүү дээ. Та зүгээр нэг өнөөдрийнхөө хуулийн хүрээнд ч гэдэг юм уу, өнөөдрийнхөө чиг үүргийн дагуу нэг цаас бөглөөд суухаасаа илүүтэйгээр явал бид илүү сайжрах ёстой юм бэ явал илүү бодитой болох ёстой юм бэ асуудалдаа. Бодитой хандах юм. Явал энэ асуудлын гогцоог тайлах юм гээд олон асуудлуудыг бид нар яримаар байна шүү дээ.

Ингэж байж энэ чинь эрүүлжих цаашидаа зөв мэдээлэлтэй болох зөв төлөвлөлтүүд хийгдэх асуудлууд яригдана шүү дээ. Ингэж байж энэ хүнсний энэ өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлттэй

холбоотой асуудалд ч гэсэн нөлөөлөл үзүүлнэ шүү дээ нөхөд өө.

Ц.Цэрэнпунцаг: Батлут гишүүн голлон санал хэллээ тийм ээ. Энэ Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар байна. Та нар яг тодорхой товчхон шиг хэлээрэй. Энэ одоо жишээлбэл энэ гурил дээр жишээлбэл хэдэн гол нийлүүлэгч л байгаа шүү дээ. Цөөхөн эд нар дээр та нар тэр ямар шалгалт хийсэн юм, яг тодорхой шүү. Тойроод юм ярихгүй. Тэр махан дээр та нар энэ хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж байгаа бол тэр энэ нөөцийн мах яаж бэлтгэдэг юм. Яаж хаанаасаа хаашаа яваад эцэстээ тэр хэрэглэгчийн гар дээр яаж очиж байгаа юм. Энэ тал дээр та нар бас араас нь дагаж судалж үзсэн юу байгаа юм. Энэ дээр яаж ажилласан юм. Мах гурил 2 дээр та нар энэ дээр шударга бус өрсөлдөөн явагдаж байна уу үгүй юу. Монопольчлол явагдаж байна уу, үгүй юу тэр мах бэлтгэл эд нар нь цөөхөн хүний гарт байдаг юм уу үгүй юу? Цөөхөн компани энийг шийдээд байна уу, үгүй юу? Ямар асуудлууд шийдсэн юм? Тодорхой нэг хэлээдэх ээ товчхон шүү.

Ажлын хэсгийн нэг номерын микрофоныг нээе.

Ц.Уртнасан: Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга Уртнасан. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас энэ 2022 оны гол нь энэ төрлийн зарим бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт хомсдолоос сэргийлэх тухай хуулийн хүрээнд бол туслах чиг үүрэгтэйгээр оролцсон. Үүнд бол Монголбанк болон Хөдөө аж ахуйн яам бусад байгууллагуудын туслах үүрэгтэйгээр оролцож импортын хүнсний барааны үнийн байдалд бол хяналт шалгалтуудыг явуулсан. Энэ хүрээндээ бол барилгын материал болон өргөн нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн асуудал дээр бол хяналт шалгалтыг хийж гол үйлчилгээ үзүүлж байгаа Дэнжийн мянга бусад хүнсний зах

материалуудаар үнэ тогтворжуулах асуудал дээр ажилласан.

Хуулийн үйлчлэл дууссаны дараа бол тус байгууллагын зүгээс хуулийн хүрээнд хүлээсэн чиг үүргийн хүрээнд давамгайл болон зүй ёсны монопол байдалтай аж ахуйн нэгжүүдийн үнэ тогтворжуулах асуудал, зохиомол үнийг бий болгохгүй тал дээр түүнээс урьдчилан сэргийлэх ажлуудыг хийж байгаа.

Өнөөдрийн яригдаж байгаа гол асуудал мах гурилын үнийн асуудал буюу өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний асуудал дээр мөн бас байгууллагаас тодорхой хяналт шалгалтуудыг өнгөрсөн 7 хоногт хийж гүйцэтгээд явж байна. Энэ хүрээндээ махны зах зээлийн төвлөрсөн худалдаа эрхэлж байгаа Дэнжийн мянга болон бусад хүнсний зах жижиглэн худалдаа эрхлэгч дээр бол мөн түүнчлэн нийслэлийн нөөцийн мах бүрдүүлсэн нөөц бүрдүүлсэн 12 аж ахуйн нэгжийн склад сав агуулах зориудаар очиж газар дээр нь үзлэг хийлээ. Энэ хүрээнд үндсэндээ 3 шатлалт ченжийн тогтолцоо бол Дэнжийн мянга дээр явагдаж байна. Орон нутгаас оруулж ирж байгаа, орон нутгаас Дэнжийн мянга руу оруулж ирж байгаа, Дэнжийн мянга дээрээ жижиглэн худалдаа, лангуу, эрхэлж байгаа этгээдийн гээд.

Тэгэхээр энэ хүрээндээ бол бид бүхэн тухайн зах зээлд эрэлт нийлүүлэлтээсээ үндэслээд үнэ тогтож байна. Энийг төрөөс тодорхой интервес хийх зорилгоор мэдээж нөөцийн махыг бол сүүлийн жилүүдэд бэлтгэн нийлүүлж байгаа. Гэхдээ нөөцийн махыг хангаж байгаа ААН-үүд маань сайн чанарын махаа нэг ёсондоо ардаа үлдээгээд тодорхой туранхай махнуудаа түрүүлж зах зээлд гарах нөхцөл байдал байна гэдгийг бид бүхэн шалгаж тогтоосон.

Хоёрдугаарт нөөцийн махыг иргэдэд худалдаалах мэдээ мэдээллийг хангалтгүй өгч байна. 481 цэг 30-ийг

өргөтгөсөн худалдааны цэгээр бид бүхэн очиход тодорхой хэмжээний хангалтууд багатай нөөцийн мах нь дуусчихсан хэрнээ хангалтыг 12 аж ахуйн нэгж одоо өгөхгүй байгаа.

Дээрээс нь мэдээллээр иргэдийг хангахгүй байгаа нөхцөл байдал тогтоогдсон учраас энэ үйл ажиллагааг явуулж байгаа.

Нийслэлийн Захирагчийн ажлын алба руугаа бид бүхэн хамтарч зөвлөмж байдлаар хамтарч ажиллаж байгаа нөхцөл байна. Гурилын тодорхой давамгайлалтай, гурил үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн хувьд бид бүхэн түрүүн бас яамдын газрын дарга нар ярьж байсан. Нөгөө 51 бодлогын гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдтэй энэ хүрээнд гурилын үнийг зохиомлоор хөөрөгдөхгүй байх өртөг зарлагаас давсан үнийг тогтоохгүй байх гэдэг байдлаар өнгөрсөн онд хяналт шалгалтыг хийгээд Өрсөлдөөний тухай хуульд заасны дагуу хууль бус худалдааны арга хэрэглэсэн. Мөн хэлцэл буюу картелийг хийсэнүү, үүнээс торгуулийн арга хэмжээг оногдуулаад явж байгаа. Манай хяналтад нийтдээ нэг 303 зах зээлийн 370 гаруй давамгайл, олон зүй ёсны, монопол ААН байдаг. Энэ байгууллагуудынхаа бол үндсэндээ үнийн өөрчлөлтийг тарифын өөрчлөлтийг бид бүхэн хяналтаа тогтоогоод явж байгаа. Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн мэдээж түрүүн бас дурдсан ложистик тээврээс шууд хамааралтай.

3 сард төмөр замын 21 нэр төрлийн ачаа тээврийн үнэд өөрчлөлт орсон. Энэ үнэ өөрчлөлт ороход манай зүгээс нефтийн болон хүнсний тээвэрлэлтийн үнэ, тээврийн үнэ өсөхийг хориглож хуучнаар нь хэвийн үлдээсэн ийм нөхцөл байдалтайгаар бид бүхэн үйл ажиллагаанд оролцож байна. Ер нь цаашидаа бид бүхэн энэ улирлын шинж чанартай үнийн асуудал дээр Худалдааны тухай хууль болон энэ үнэ өртгийг тогтоож байгаа энэ хуулийн асуудлыг бодлогын хэмжээнд гаргаж

ирж тогтоох асуудал бол ер нь зайлшгүй.

Ц.Цэрэнпунцаг: Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

Дараа нь тэрийг гүйцээж хариулна шүү. Тэр гурилын үйлдвэр дээр монопол тэр шударга бусаар өрсөлдөж байгаа ийм үйл ажиллагаа тогтоогдсон юм уу үгүй юу. Дараа нь гүйцээж хариулаарай.

Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

Ц.Сандаг-Очир: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе. Хөдөө аж ахуйн сайд маань сууж байгаа юм байна.

Бид нар ер нь өнөөдөр энэ зах зээлийн нийгэмд амьдарч байгаа. Үнийг бууруул гэж, бууруулах ямар арга хэмжээ авч байна гэж ярих ер нь зөв үү буруу юу? Та бүхэн үнийг тогтворжуулах үнийн өсөлтөөс сэргийлэх бодлого барьж ажиллах ямар арга хэмжээ авав?

Нэгэнт ингээд өсчихсөн одоо зах зээлийнхээ зарчмаар ингээд янз бүрийн шалтаг шалтгаанаар өсөөд байгаа асуудлыг бууруулахад маш хүнд. Тэгэхээс урьдчилан сэргийлэхийн тулд энийг мэдэрч гэдэг юм уу, энэний талаар ямар арга хэмжээ авав аа? Энэний тулд яамаар байгаа байх гэж бодож байна. Нөгөө талаасаа би Болорчулуун сайдаас 1-2 удаа бас чуулган дээр сонсож байсан.

Ер нь бол одоо олон улстай харьцуулахад бид хямд үнэтэй мах идэж байгаа гэж, хямд үнэтэй гурил идэж байгаа гэж. Цаашидаа мах гурилыг нь өшөө ч өсгөх болно гэж. Тэгээд 2 талтай. Үйлдвэрлэгчээс талаасаа харвал, хэрэглэгч талаасаа харвал мэдээж өндөр үнэтэй бүтээгдэхүүн идэхийг хүсэхгүй байх. Та ер нь аль талд үйлдвэрлэгч талаа бодлогоо бариад байна уу, хэрэглэгч талынхаа бодлогыг бариад байна уу. Ер нь яг яах ёстой юм? Өнөөдөр орж ирээд ингээд баахан ингээд

тоо баримтууд барьж орж ирээд байна л даа. Тэгээд баахан өнгөрсөн хугацаанд нэг Засгийн газраас үнэ тогтворжуулах нэрийдлээр өгсөн зээл юмнуудаа яриад байна. Энэ нэг талаар бодлого арга хэмжээ байх. Тэглээ гээд үр дүн гараагүй байна шүү дээ. Өнгөрсөн 2022 онд гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг хомсдолоос сэргийлэх үнийн өсөлт хомсдолоос сэргийлэх сөрөг нөлөөллийг бууруулах гэсэн ийм хууль баталсан.

Бензин, мах, гурил. Бензин өнгөрсөн хугацаанд арга хэмжээ аваагүй бол өнөөдөр бараг 3 мянга гараад явж байгаа байх. Тэгэхээр энэ хуулийн хүрээнд авсан арга хэмжээний хүрээнд бензиний хувьд тогтвортой барьж байгаа юм байна. Тэгвэл мах гурилын хувьд энэ хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа юм байна гэж үзэхээр байна.

Тэгэхээр бид нар энэ төрөөс олгоод байгаа энэ урамшуулал энэ нөөцийн бэлтгэлийн энэ хэдэн тэрбумаар яригдаад байгаа мөнгүүд чинь эзнээ олохгүй байгаа юм биш үү. Бодлого нь буруу байгаа юм биш үү? Магадгүй энэ нь явж явж өөрөө бараг үнэ хөөрөгдөх нөхцөл шалтгаан болоод байгаа юм биш үү? Тэгээд энэ зах зээлийн нийгэмд ер нь хэдий болтол ингэж төрөөс үнийг хатуу зохицуулах гэж үзэх юм? Энэ зарчим чинь өөрөө хэр зөв юм? Энэ асуудлаа ярихгүй юм уу? Тэрнээс баахан статистик судалгаанууд гаргаж энийг чинь мэдээд байна. Та нарын цаасан дээр гаргасан судалгаа тэр захууд дээр байгаа судалгаа таарч байна, үнэн байна. Гэхдээ та нарыг ингэж судалгаа гаргаж ир гээгүй. Шийдлүүдийг ярьж цаашидаа яах юм бэ гэдэг цаашидаа өшөө өсөх юм уу, өшөө өсөхөөс сэргийлж ямар бодлого барих гэж байгаа юм бэ? Тогтвортой хэмжээнд барих нь юу юм бэ гэдэг ийм шийдэл ерөөсөө яригдахгүй байна л гэж би харах гээд байх юм.

Тийм учраас би Хүнс, хөдөө аж ахуйн сайд өнөөдөр Эдийн засгийн байнгын хорооноосоо чиглэл өгч тогтоол

гаргаж энэ өнгөрсөн 2022 онд баталсан гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр мах гурилын үнийг өсөлтөөс цаашидаа ахиад ч өсөхийг үгүйсгэхгүй. Ахиад өсөлтөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр энэ хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр тодорхой арга хэмжээ ав гэж би бүр чиглэл өгч тогтоол гаргамаар байгаа юм.

Тэгээд ямар арга хэмжээ авах юм? Энэ чиглэлээ энэ Эдийн засгийн байнгын хороо цаашидаа чуулган дээр ч оруулж ирж танилцуулж арга хэмжээ авах ийм байдлаар ажиллавал яасан юм. Тэрнээс өнөөдөр хэн нэгнийгээ ингээд та бид бүгдээрээ нэг завины нэг талд сууж байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Сандаг-Очир гишүүн нэмж асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Тэрнээс Их Хурлын гишүүд ажиллаад та нар маань ажиллахгүй байгаа ч юм уу та нар ажиллаад Их Хурал нь ажиллахгүй, Засгийн газар нь ажиллахгүй байгаа юм биш шүү дээ. Бид нар бүгдээрээ адилхан. Та бүхний ажил муу байгаа бол бид нарын ажил муу байна л гэсэн үг. Бүгдээрээ төрийн ажил хийж байгаа учраас.

Тийм учраас эндээс хэн нэгнийгээ гэдэг юм уу загнах гэж баалах гэж шүүмжлэх гэж ирээгүй байх гэж бодож байна. Тэгээд өнөөдөр энэ хэмжээнд Эдийн засгийн байнгын хороон дээр асуудлыг яриад цаашидаа ахиад махны нөөцийн чинь нийлүүлэлт багасах юм байна лээ.

Тэгэхээр яана гэсэн үг вэ Засгийн газраас цалин мөнгийг нэмэгдүүлэх арга хэмжээ аваад тодорхой шийдвэр гарвал сургаар нь ахиад инфляц чинь өсдөг байх аа? Тэгвэл яах юм. Хаваржилт маш муу байна малын хорогдол 20 хувьд хүрч байна. Ийм нөхцөлд яах юм ахиад энэ

махны үнэ үнэ чинь ахиад өсөхийг үгүйсгэхгүй шүү дээ. 20 мянга гараад явчихвал яах юм. Энэнээс урьдчилан сэргийлэх гэж ямар арга хэмжээ авах нь эхлээд тодорхой хугацаатай.

Ц.Цэрэнпунцаг: Сандаг-Очир гишүүн асуулт асууж, санал хэллээ.

Асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны сайд Болорчулуун сайд хариулья.

Х.Болорчулуун: Юмны үнэ өслөө гэж ярьж байна. Бүх л юмны үнэ Монголд өссөн. Энд бол бид нар, Монголын төр засаг, Их Хурал бүгд л буруутай. Тэрнээс бид нар унтчихаад гэнэт сэрсэн юм шиг нэг том яриад байх шаардлага байхгүй гэж бодож байна. Яагаад гэвэл Монгол Улс үйлдвэрлэгч хэрэглэгч орон болсон юм өнөөдрийг хүртэл. Дотооддоо эм үйлдвэрлэж чадахгүй байхад хэзээд гаднын хараатай нь хэзээд юмны үнэ өснө.

Өнөөдөр Монгол Улс инфляцыг 70-75 хувь гаднаас импортолж байна гэж байна инфляцыг. Тийм ч учраас валютын хани баригдахгүй жилээс жилд өсдөгийг бүгд мэдэж байгаа. Харин Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам өрх салбарын хэмжээнд нэг талаасаа үйлдвэрлэгчээ дэмжсэн бага хүүтэй зээл Улсын Их Хурлын 36 тогтоолын хүрээнд олох ажлыг энэ хавраас эхэлж байна. 6 хувийн хүүтэй жилийн. Хүнс болон ХАА-н салбарын үйлдвэр. Нөгөө талаасаа бас хийж чадаж байгаа, хийж чадах хүнсний зүйл дээрээ импортын татварыг үе шаттайгаар инфляц нөлөөлөхгүйгээр 2 жилийн хугацаанд, 3 жилийн хугацаанд нэмэгдүүлэхээр бас тогтоолын төсөл Засгийн газраар оруулж байна. Бид ингэж байж үйлдвэрлэж чадах юмаа үйлдвэрлэж байж бид инфляцыг тогтоон барина. Тэрнээс биш хэзээ ч баригдахгүй.

Хоёрдугаарт аливаа өргөн хэрэглээний барааны үнийг хатуу зах

зээлийн нийгэмд ишлэжчихээд бид нар социализмын үе шиг барих боломж байхгүй шүү дээ. Энэ дээр яам ч бай хэн ч бай тэр хүчээр оролцох нөхцөл байхгүй. Гурил будааны үнэ өслөө гэж ярьж байна. Түрүүнд Аубакир гишүүн хэлсэн. Манай Монгол Улс дутагдсан будаагаа ОХУ-аас авдаг. Энэ жил 90 хувь үр тариа өөрсдийгөө хангасан харин 10 хувьд нь дутагдана. Намрын ургац хураалтын наана 1, 2 сарын хугацаатай бас будаа дутагдах Оросоос авах явдал гарна. Тэгэхэд гурил будаа нь гурилын үнэ өсөхөд магадгүй яагаад гэвэл өнөөдөр ОХУ манайхаас өндөр ургац авдаг. Манайх 12-15 центр ургац авч байхад, ОХУ 25-30 центр ургац авдаг. Хэрэглэж байгаа техник түлш шатахуун бүгд дотоодоосоо дотроосоо хямдхан авдаг мөртөө өнөөдөр будааных нь үнэ орж ирэх будааны үнэ Монголд тарьж ургуулсан будаанаас үнэтэй байна шүү дээ.

Монголын газар тариаланч чадан ядан ард хормойгоороо урд хормойгоо нөхөөд ажиллаж байгаа. Монголын газар тариаланчид дунд өргүй компани гэж байхгүй шүү. Бас энэ газар тариалан энэ үйлдвэрлэлийнхээ онцлогийг бас та бүхэн сайн ойлгож ярь. Үнэхээр сүүлийн судалгааг харахад байхгүй байна лээ. Бүр харин бид нар гаднаас ялангуяа ковидын үед нөөц бүрдүүлнэ гэсэн байдлаар 200-аад мянган тонн улаан буудай импортоор оруулж байгаад газар тариаланчдадаа бүүр накутанд оруулсан. Зарим нь тарихаа больсон. Бид энийг сэргээх ёстой. Үндэсний үйлдвэрлэлээ сэргээж байж л инфляц юмны хани буурна.

Хоёрдугаарт өөрөө надаас асуулаа. Өөрөө үйлдвэрлэл талдаа байна уу, хэрэглэгч талдаа байна уу гээд. Мэдээж Засгийн газрын гишүүний хувьд аль аль талдаа байна. Гэхдээ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам бол үндсэндээ үйлдвэрлэл талдаа гэж ойлгож болно. Тэр мах нийслэлд мах тогтвортой байлгах, нөөцтэй байлгахыг

бол нийслэл хот өөрөө хариуцах ёстой. Энэ асуудлыг ч Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нийслэлээр шилжүүлэхээр бичиг тоотоо өгөөд Засгийн газрын тогтоол ер нь удахгүй гарна.

Ц.Цэрэнпунцаг: Болорчулуун сайд бас ерөнхийдөө шулуухан хэлж байна л даа. Ер нь бид нар үнэ ялангуяа энэ хүнсний өргөн хэрэглээний бараануудын үнийг барина гэж байхгүй гээд. Энэ чинь одоо ингээд бүгд л хүлээн зөвшөөрөөд байгаа шүү дээ. Тэгээд энэ цаашидаа үнээр оролдож үнэ тогтоох могоох гэж хууль гэж бид хийж энд сууж байгаа бол ер нь гишүүд бүгд ингээд л яг ярилцаад бид нар ингээд тойролцоод л яг энэ асуудлыг тойроод суух юм ийм л байгаа байхгүй юу.

Тэгэхээр өнөөдөр бид нарын хууль гаргачхаад үнэ тогтоох гэж байгаа, үнэ барих гэж байгаа гээд араас нь үнэ тогтоох хөтөлбөрүүд гээд энэ баахан татвар төлөгчдийн мөнгөнөөс тэр хүүгийн хөнгөлөлтийг нь үзүүлээд 135 тэрбумыг тавьчихсан байгаа юу. Энэ мэнийг бид нар эргээж ярих хэрэгтэй. Эргээж бид нарын бодлого нь буруу байна гэсэн үг. Тэгэхээр зэрэг энэ дээрээ бид нар энэ чигээрээ яваад байвал энэ хэзээ төгсөхгүй юм. Ийм л юм болох нь. Тэгэхээр энийгээ ер нь хүлээн зөвшөөрөөд за больё оо. Төр тэр үнэ гэдэг юмаар оролдохоо больё гээд гараа өргөөд гар хөлийн үсгээ зураад болих хэр хэрэгтэй. Тэрийг бүгд л хэлээд байдаг. Үгүй ээ би нэг жишээ хэчнээн ч олон удаа давтаж хэлээд дахиад хэлэхэд нэг Америкууд чинь нэг нүүрсний үнийг бас зохицуулалт хийх гээд тэгээд тэрнээс шалтгаалаад цаашаа гинжин урвал явагдаад 34 мянган нэр төрлийн ийм үнэд өөрчлөлт дагаж энэ нөлөөнд орж зохицуулалт хийх шаардлага үүсэж бий болж байсан гээд тооцоо гаргаж байсан гэсэн.

Тэгээд тэрнийгээ больсон юм байгаа биз дээ. Тэр үнэ зохицуулах гэж оролдсон, үнэ тогтоох гэж үнийг төр

оролцож зохицуулах гэдэг. Энэ асуудал байхгүй юмыг л бид нар энэ оролдоод байгаа юм биш үү ер нь. Ингээд тэр түрүүн сая махны тэр нөөцийн мах бэлтгэх ийм бэлтгэл зохион байгуулах ажлыг Улаанбаатар нийслэлтэй Хүнс, хөдөө аж ахуйн яам хамтарч хийж байгаа тийм ээ. Энэ дээр одоо зохион байгуулалт хийж байгаа нөхдүүд та бүхэн бас нэг нийслэл тэнд Ерөнхий менежер байж байна. Ноднин гэхэд 7 мянган тонн мах илүү гарсан гэж үнэн үү? Тэгээд ноднин тэр илүү гарсан мах нь хааччихсан юм. Энэ жил дахиад хэдэн мянган тонн мах илүү гарах юм.

Дээрээс нь тэр нэг төрийн Хүнс, хөдөө аж ахуйн яамныхан хариулж байсан уу? Тэр махыг цаанаа чанартай нь үлдчихдэг юм байна лээ. Тэрийг нь гаргуулж барих тал дээр арга хэмжээ авна бодлого байгаа гээд байсан тийм үү? Хаана тэгж хариулав. Тэгэхээр шударга өрсөлдөөнөөс хариулсан уу? Махаа ардаа гайгүй махаа аваад үлдчихдэг юм байна гээд. Бид нар явж судлаад асуухад зарим нь тэр Хүчит шонхор зах дээр байж байгаа тэр бизнес эрхэлдэг улсууд хэлж байна лээ шүү. Энд манай энд байгаа хамгийн муу махыг нь тэр нөөц бэлтгэдэг компаниуд чинь аваад явдаг юм чинь яаж хүмүүс тоож авдаг юм гээд.

Тэгэхээр тийм юм байдаг юм уу үгүй юу? Бас дараагийн дараа наад асуултад бэлтгэж байгаарай.

Өнөрболор гишүүн асуултаа асууя.

Д.Өнөрболор: Улс орны нийгэм эдийн засгийн яг энэ мэдээллийг Үндэсний статистикийн хорооноос энэ мэдээллийг авах ёстой. Тэгээд энэ мэдээж энэ зохих стандартын дагуу гаргадаг байх гэдэгт би бас итгэж байгаа. Тэгээд би бас энэ итгэж байгаа боловчиг маш их олон тодруулмаар, яг энэ Үндэсний статистикийн хорооноос гаргаж байгаа энэ тоон баримтууд түүн дээр үндэслээд

Засгийн газрын гаргаж байгаа энэ шийдвэрүүдийн үр нөлөөллүүд бас ингээд ийм бүтээмжгүй үр дүнгүй байгаад байгаа учраас яг одоо энэ гаргаж байгаа шийдвэр дээр бас тойроод бас хэд хэдэн асуудлуудыг бас би та бүгдээс тодруулмаар байна. Энэ инфляцын түвшин ер нь буурсан энэ статистикийн мэдээг сүүлийн үед бас авч байгаа. Гэтэл яг бодит байгаа байдал дээрээ болохоор чинь бол 7, 7 хоногоор энэ өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өсөж байгаа. Буурч байгаа нөлөөлөл үнэхээр ард иргэдэд мэдрэгдэхгүй байна гэдгийг сая бас гишүүд ч яваад ирсэн. Энэ хэнбгуй ч энэ өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн зарж борлуулж байгаа газруудаар яваад бас ойлгомжтой байгаа. Тэгээд зарим энэ ТББ-ын судалгаагаар хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүнүүд өмнөх 7 хоногоос 9.3 хувиар өссөн гэж бол ийм судалгаа гарсан байна лээ. Тэгээд энэнээс нэн ялангуяа энэ орон нутгийн иргэдийн худалдан авах чадавх үнэхээр буурч байгаа. Өртөг зардал нэмэгдээд үнийн өсөлтөд хамгийн их өртөж байгаа бүлэг бол энэ орон нутгийн иргэд байгаа.

Тэгэхээр энэ инфляцын бууралт ер нь цаасан дээр яваад байгаа юм биш байгаа гэдгийг бол бүх гишүүд л ярьж байна. Би ч бас энэн дээр ийм л хардалттай байна. Дараагийн нэг асуудал нь статистикийн мэдээллээр манай улс 2.3 сая хүн ажиллах хүчинтэй байгаа. Үүнээсээ бол 54 орчим хувь нь ажиллаж байгаа. Тэд нарын дундаж цалин 1.7 сая төгрөг гэж гаргадаг юм байна.

Тэгэхээр энэ нийгмийн даатгалын сангийн мэдээлэлд үндэслээд 2009 оны аргачлалаар энэ аргачлалыг боддог юм байна. Энэ цалинг боддог юм байна гэж би ойлгосон. Тэгэхээр энэ нийгмийн даатгал төлөгддөггүй энэ нийгмийн тодорхой харилцаанд орж байгаа бүлэг улсууд нь яадаг юм бэ? Тэгээд энэ 54 хувь дээрээ л түшиглээд та нар яг энэ тооцооллыг гаргачихдаг юм уу. Тэгвэл

энэ маш өндөр. Харагдах нь ойлгомжтой юм биш үү? Тэгээд энэн дээр чинь үндэслээд шийдвэрүүд гаргаад байгаа шүү дээ. Тэгээд ер нь яг тэдний бодит одоо энэ өрхөөр нь бодит орлогыг тооцдог ийм аргачлал байна уу? Тэгээд энэ статистик яг энэ тэр бүлгийг төлөөлж чадаж байна уу гэж би бас энэ Статистикийн үндэсний хорооноос асуумаар байна. Тэгээд ер нь Статистикийн байгууллага энэ бусад төрийн байгууллагуудтай ер нь мэдээллээ ер нь хэр зэрэг солилцдог юм бэ? Сая энэ тойрогт ажиллах үеэр ч гэсэн энэ хүүхдийн мөнгөн тэтгэмжийн асуудал дээр бол ерөөсөө бүүр маш их том асуудал болсон. Тэгээд бид нар бол яг энэ төсөл хэлэлцэж байх үед маш их шүүмжлээд тэгээд санал гаргаад бол бараагүй л дээ.

Сангийн яам тэгээд л дайрсаар байгаад л батлаад л ингээд явсан. Тэгээд ер нь гол асуудал нь юу юм бэ гээд ингээд судлаад үзэхээр статистикаас гаргасан өрхийн орлогын судалгааг үндэслээд 3 саяас дээш орлоготой 71 мянган өрхийн 116400 хүүхэд нийт өрхийн 10 орчмыг эзэлж байна гэсэн. Энэ судалгааг л гээд Сангийн яам ингээд л дайраад л энүүгээр ингээд тайлбарлаад л зорилтот бүлэг юм гээд л ингээд л өнгөрсөн.

Гэтэл цаана нь бол маш их олон иргэд ингээд л хохироод л асуудал болгоод ч асуудлыг шийдвэрлэж чадаагүй ингээд өнгөрсөн.

Өнөрболор гишүүн хамгийн гол нь статистикийн газраас асууж байна. Тийм ээ ер нь итгэл муутай байна шүү. Энэ 2 асуултад хариулаадах гэсэн шүү тодорхой.

Батдаваа дарга хариулья 2 номер.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын эрхэм гишүүн Өнөрболор гишүүний асуултад хариулья. Инфляцын түвшин буурч байгаа гэдэг тоо гарч байна гээд тэгж байна. Гэтэл үнийн өсөлт явагдаж

байгаа юу гэвэл явагдаж байгаа. Инфляцын түвшин маань бол одоо 12.2 болж байна гэдэг маань өсөлтийн хурдцыг илэрхийлээд байгаа гэсэн үг. Тэрнээс сар дотроо одоо үнийн өсөлтийн хурдац хэвээрээ байгаад байгаа. Дандаа нэг хувиас дээшээ үнэ өсөөд байгаа. Одоо сүүлийн сар хагасын хугацаанд гэхэд махны үнэ 15 хувиар өсчихлөө.

Бүх бараа бүтээгдэхүүний үнэ ингээд сар болгон 1,1 хувиар ингээд өсөөд яваад байгаа. Тэгэхээр энэ хурдцыг харуулаад байгаа шүү. Тэр 12 хувь, 16 хувь гэдэг маань тийм юутай байгаа. Мэдээлэлтэй байгаа. Тэгээд түрүүн Эдийн засгийн байнгын хорооны дарга бас хэллээ. Ер нь инфляцыг бууруулна гээд 1, 2 бүтээгдэхүүн онилж бодлого боловсруулах нь энэ өөрөө үр дүнгүй ээ яагаад гэвэл хүн амын өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн үйлчилгээ маань нийтдээ сагс нь өөрөө 411 бараа бүтээгдэхүүнээс шалтгаалдаг. Энэ ч утгаараа олон Улсын жишигт бол инфляц гэдэг бол мөнгөний үзэгдэл гэж үздэг. Энийг мөнгөний бодлого болон төсвийн бодлогоор макро бодлогын хувьд зохицуулах ёстой гэж үздэг. Орон нутгийн хувьд бол яг сүүлийн жил хагасын хувьд орон нутгийн иргэд дээр инфляц үнийн дарамт хамгийн өндөр орж ирж байгаа гэж статистик мэдээллээр гарч байгаа.

Яагаад вэ гэхээр хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ сүүлийн жил хагасын хугацаанд маш бага өссөн. Орон нутгийн ялангуяа хөдөөгийн иргэдийн хувьд бол өрхийн аж ахуй буюу мал аж ахуй, газар тариалангаас орлого нь бүрддэг учраас энэ инфляцын дарамтад хамгийн их өртөж байна гэдэг статистик гарч байгаа. Одоо жишээ дурдахад бол Улаанбаатар хотын иргэдийн нэг өрхийн дундаж орлого 1.9 сая байхад хөдөөгийн орлого 1.4-5 сая орчим байх жишээтэй. Тэгээд энэ 2 зөрөө бол сүүлийн жил хагасын хугацаанд нэлээн нэмэгдэж гараад байгаа. Дундаж цалингийн хувьд 2014

оны батлагдсан аргачлалаар тооцож явж байгаа. Дундаж цалин гэдэг маань дотроо 2 бас үзүүлэлт явж байгаа. Нэг нь болохоор 1.7 гэдэг маань сая дундаж цалин 1.7 гэдэг маань нөгөө жигнээд үзсэн дундаж дүн байгаа. Голч цалин гэж явж байгаа. Голч цалин бол хамгийн сүүлийн үзүүлэлтээр 1.2 сая байгаа. Хамгийн эхээсээ бага хүртэлх цалингууд авч байгаа хүмүүсээ жагсаагаад голд нь хамгийн олон давтамжтай авч байгаа цалин гэсэн үг. Ийм мэдээлэл байгаа.

Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хувьд Үндэсний статистикийн хорооноос энэ хүүхдийн мөнгөн тэтгэмжид 91 хувьд нь бол тийм байна, ийм байна гэдэг тийм мэдээлэл шийдвэр гаргалтад өгөөгүй. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн тэр аргачлалыг боловсруулах дээр бол бид нар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамыг дэмжиж буюу хамтарч ажилласан ийм үр дүнтэй байгаа.

Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Өнөрболор гишүүн нэмж асуулт асууя.

Д.Өнөрболор: Тэгээд үндсэндээ бид нар гишүүд ч тэр, Засгийн газрын гишүүд ч тэр ер нь ингээд л бие бие рүүгээ асуулт хариулт шидээд л, тэгээд л үндсэндээ бол үнэхээр аягүй тийм бүтээмжгүй бас энэ хурлууд болж байгаа нь бол бас юу гэдэг юм цаг үрсэн ийм нөхцөл байдалтай байгаад байгаа. Тэгээд би юу гэж бодож байна вэ гэхээр сая энэ гишүүдтэй бүүр үнэхээр санал нэг байна.

Өөрөөр хэлэх юм бол энэ дээр тодорхой шийдэл олох хэрэгтэй бид нар. Тэгээд энэ шийдлийг би бас энэ сая юунаас оролцож байгаа энэ төрийн байгууллагуудаас ингээд харахаар хэн Ган-Очир ахлах эдийн засагч байх шиг байна, тийм ээ Монголбанкны.

Тэгээд сая ингээд хэлж байна шүү дээ. Ер нь энэ асуудлыг шийдэхэд ер нь

макро түвшиндээ асуудлаа шийдвэрлэхгүй бол болохгүй гээд тэгж байна л даа. Тэгээд ер нь яг та бүгд маань ер нь яг энэ шийдлийг яг юу гэж харж байгаа юм? Яг боддоо.

Ц.Цэрэнпунцаг: Өнөрболор гишүүний асуугаад байгаа асуултыг асуугаад тэгээд хариулах хүн байхгүй л байгаа юм даа. Засгийн газрын гишүүн Болорчулуун сайд та хариулах уу?

Ер нь шийдэл нь юу байгаа юм? Бид нар энэ чигээрээ ингээд цаашаа инфляцынхаа энэ араас ингээд л. Хэн хариулах гэж байсан гэнэ ээ? Ган-Очир хариулаадах бодлогыг нь мэдэж байгаа юм байна. Хариултыг нь мэдэж байгаа юм байна. Тэр ажлын хэсгийн тэр дугаартай микрофон дээр уншаадах. Ган-Очир дарга аа нэг тодорхой хэлнэ шүү. Ямар гарц шийдэл байгаа юм. Тэгээд бид нарт нэг дурайтал нь хэлээдэх. Эсвэл одоо бид нар энэ чигээрээ гүйж байтал гүйцчих юм уу болчих гээд байгаа юм уу энэ замаараа.

Ажлын хэсгийн 4 номерын микрофоныг нээе.

Д.Ган-Очир: Сайн байцаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Монголбанк бол макро зургаараа инфляцад юу нөлөөлж байна вэ? Түүний цаашидын төлөвийг бол судалж, тогтоож ямар бодлогын арга хэмжээ авахыг макро дүр зургаар нь бол гаргаж ажиллаж байгаа. Бидний төсөөллөөр бол өмнө нь дэд Ерөнхийлөгчийн тайлбарласнаар энэ оны эцэс гэхэд 8 хувь руу буух бололцоо байна гэж байгаа. Гэхдээ хэрвээ энэ төсвийн огцом тэлэлтүүд одоо батлагдсан төсвөөсөө нэмж зардал гарахгүй тохиолдолд, нийлүүлэлтийн томоохон том цохилтууд орж ирэхгүй тохиолдолд боломжтой гэдгээр нөхцөл таамаглалыг хийдэг.

Бид бүгдийн хувьд макро зураг зургаараа өнөөдрийн энэ инфляц өндөр

яагаад байгаад байна вэ гэдэг дээр нэг эдийн засгийнх нь хамаарлаар 3 хүчин зүйлийг онцолж байгаа юм.

Эхнийх нь бол нэгэнт нийлүүлэлтийн шалтгаанаар өдөөгдчихөж байгаа инфляц маань өөрөө инерцээ хадгалдаг. Инерцээ хадгална гэдэг нэг барааны үнийн өсөлт нь бусад барааныхаа орц болдог гэдэг юм уу эсвэл тэрний дамжих бүтээгдэхүүнийх нь завсарт нь нөлөөлдөг гэдэг утгаараа бол энэ дамжих нөлөөллүүд бол нэлээд хүчтэй явж байгаа.

Хоёр дахь нь сая бол бас гишүүд болон сайд нар хэлж байгаа валютын ханишийн 22 хувийн өнгөрсөн оны сулралт нэг 6-9 сарын хугацааны хоцрогдолтойгоор импортын бараануудын үнийн өсөлт рүү орж ирдэг. Энэ маань өөрөө эцсийн импорт болон завсрын импорт буюу манай дотоодод үйлдвэрлэдэг бараа бүтээгдэхүүний орц болж ашиглагддаг. Импорт эдийн бараануудын үнийн өсөлт энэ нөлөөлөл бол арилаагүй бас ажиглагдаад явж байна. Гэхдээ сүүлийн 1 сарын хугацаанд ажиглагдаж байгаа валютын ханишийн төгрөгийн маань ам.долларын эсрэг чангаралт маань өөрөөр хэлбэл энэ нөлөөллийг тодорхой хэмжээнд сааруулах гэдэг юм уу цаашид нэмэгдэхгүй байхад нь эерэг нөлөө үзүүлэхээр төсөөлж байгаа.

Гурав дахь нэг гол хүчин зүйл төрийн болон хувийн сектор дээр цалингийн өсөлтүүд өнгөрсөн оны 4 дүгээр улирлаас хойш гарч байгаа. Энэ оны хувьд гэхэд дунджаар 30-35 хувийн цалингийн өсөлт гарчихсан явж байна. Энэ нь өөрөө цалин гэдэг бол 2 сувгаар инфляц руу нөлөөлж байна. Эхнийхээрээ бол эрэлтийн нөлөөлөл буюу худалдан авагч талдаа орлогын өсөлт бий болоод нөгөө талдаа нийлүүлэлт нь өөрөө гацаатай байгаа тохиолдолд нийлүүлэлтийн гацаа өндөртэй байгаа зах зээл дээр илүү хурдан үнийн өсөлт нь түрүүлж мэдрэгддэг. Энэ утгаараа

хамгийн зайлиггүй шаардлагатай хүнсний бараанууд дээрээ энэ үнийн өсөлт нь түрүүлж мэдэгдээд байгаа.

Хоёр дахь нь хөдөлмөр гэдэг өөрөө бас нийлүүлэлтийн орц энэ утгаараа цалингийн өсөлттэйгөө бараа бүтээгдэхүүний өртөгт шилжүүлэх ёстой болж байгаа. Энэ утгаараа үйлдвэрлэгчийн үнийн индексийн өсөлт дээр бас энэ нөлөөллүүд нь гараад эхэлчихсэн.

Тэгэхээр хамгийн гол макро дүр зургаараа бол бид бүхэн бол мөнгөний бодлогыг эрэлтийн талдаа гэдэг юм уу цалин орлогын өсөлттэй түүнийг дагаад барьцаа нь цалингийн юм уу тэтгэврийн барьцаа нь өссөнтэй холбоотой хэрэглээний зээлийн өсөлтүүд бас банкны салбар дээр маш хурдан явагдаж байна.

Энэ маань өөрөөр хэлбэл буцаагаад нийлүүлэлтийн гацаа саад тариалалт энэ зүйлс нь арилаагүй байгаа тохиолдолд эдийн засгийн суурь бүтцүүд маань арилаагүй байгаа тохиолдолд эрэлтийнх нь талыг нь яалт ч үгүй мөнгөнийхөө бодлогыг хатуу төлөв дээр нь хангах байдлаар инфляцынхаа зорилт, түвшин хүртэл нь буух хүртэл нь хадгалах зайлиггүй шаардлагыг бий болгож байгаа. Нөгөө талдаа бол мэдээж төсвийн бодлого дээр аль болох урсгал зардлыг нэмэхгүй байх. Энийгээ бол ядаж инфляцын зорилт руугаа бууж ирсний хойно нэмэгдүүлэх гэдэг юм уу эсвэл энэ үнийн өсөлттэй дарамт багатай хэлбэрийг сонгох гэдэг юм уу энэ хэлбэрээр явуулахгүй бол төсвийн бодлого маань өөрөөр хэлбэл мөнгөнийхөө бодлогын үр дүнг сулруулах нөлөөгүй болох. Улмаар өндөр инфляц маань илүү удаан. Илүү удаан байх тусмаа хүмүүс үнийн өсөлтийг илүү удаан хүлээдэг нь дараагийн инфляцын өсөлтүүдийг бас бий болгох гээд байдаг.

Тэгэхээр макро дүр зургаар төсөв мөнгөний бодлогын хосолсон уялдааны хатуу бодлого тодорхой хэмжээнд байх

шаардлага зайлиггүй байна л гэж харж байгаа. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Ган-Очир дарга наана сууж бай. Танаас ганцхан асуулт асуучихъя.

Өнөөдөр талхаа авах гээд гурилаа авах гээд ургамлынхаа тосыг авах гээд махаа авах гээд мөнгө байхгүй байна шүү дээ тэр хүмүүс таны саяын ярьсан тэр цалингаар ирээд байгаа 2 сувгаар ирээд байгаа инфляц чинь ямар 2 сувгаар очиж тэр хүмүүст энэ инфляц болж байгаа юм. Тэр мах, гурил, ургамлын тос нэмэгдчихсэн энэ асуудал болж байна гэж байгаа энэ улсууд дээр, нэгт.

Хоёрт төр хувийн хэвшил 2 цалингаа нэмээд гэж байна. Хэн түрүүлж нэмсэн юм. Хариульъя 4 номер.

Д.Ган-Очир: Яг Монголын эдийн засгийн суурь гол асуудлыг та яг хөндөж байна. Өнөөдөр Монголд орлогын тэгш бус байдал хэмжигдэж байгаа болон хэмжигдэхгүй хэлбэрээр маш өндөр байна гэдэг тооцоо судалгаануудаас гарч байгаа. Энэ агуулгаараа яг энэ таны хэлж байгаа цалингийн өсөлт энэ онд 30-35 хувиар төрийн байгууллагууд дээр болон хувийн хэвчлүүд дээр Үндэсний статистикийн хорооноос гаргаж байгаа тоон мэдээлэл дээр бол бүх ангилал дээр өсөөд явж байгаа. Тэр утгаараа тогтмол орлоготой хэсэг дээр таны хэлж байгаа тэр үнийн өсөлтийн дарамтыг илүү мэдэрч байгаа. Богино хугацаандаа бол цалингийн өсөлт маань бодит орлогын өсөлт болоод хэрэглээг санхүүжүүлж байгаа боловч буцаагаад инфляц нь өсчихөөрөө бодит орлогын өсөлтийг маань сааруулчихаад байгаа.

Харин нэг зах зээл дээрээс нэг хүнсний дэлгүүр дээрээс орлогын өндөр бүлэг дээр дундаж орлоготой, бага орлоготой бүх хүмүүс үйлчлүүлж байгаа тохиолдолд энэ маань үнийн өсөлтийг орлого сайтай хэсгүүд нь илүү дэмжиж өсгөөд бага хэсэг дээр илүү том

дарамтыг үүрээд байгаа ийм бодит нөхцөл байдал бол Монголын эдийн засаг дээр яалт ч үгүй бий болчихсон байгаа. Яг аль аль аж ахуйн нэгжүүд гэдэг мэдээллийг Үндэсний статистикийн хороо бусад яамдууд илүү тодорхой хувиар ярих байх гэж бодож байна.

Ц.Цэрэнпунцаг: Та 2 асуултад нь тодорхой бас хариулчих. Тойруулчихлаа.

Хоёр дахь нь төр хувийн хэвшил хоёрын хэн нь түрүүлж цалингаа нэмээд байгаа юм бэ? Зэрэг нэмээд байгаа юм уу? Та зөв оношилчихсон. Таныг зөв оношилчихсон гэж бодъё. Тэгээд тэр бага орлоготой тийм өрх манайх 30 хувь бага орлоготой. Одоо бид нарын орлого багатай гэж үзэж байгаа өрхүүд маань 30, 40 хувьд хүрч байна. Тэгэхээр энэ бага орлоготой өрхүүд маань нөгөө авч хэрэглэдэг байсан 2 жилийн өмнө, 3 жилийн өмнө авч хэрэглэдэг байсан тэр хүнснийхээ гол өдөр тутмыг хэрэглэдэг өргөн хэрэглээний бараа ялангуяа хүнсний бараа бүтээгдэхүүнийг авч чадахаа болиод байна шүү дээ.

Тэгэхээр энийг төр засаг чинь таны хэлснээр бол болохгүй юм байна тийм үү? Төсөв дээр бол бид нар ямар нэгэн байдлаар тэлсэн ийм үйлдэл хийж болохгүй гээд та зөвлөөд байх юм. Тэгээд яа гэж зөвлөөд байгаа юм бэ?

Д.Ган-Очир: Тодорхой хариулъя. Монголын хувьд яг өнөөдөр сүүлийн энэ жил хагасын хугацаанд хэн нь түрүүлээд цалингаа өсгөсөн бэ гэхээр өнгөрсөн оны 4 дүгээр улиралд буюу 11-12 дугаар сард яг хувийн хэвслүүдийнх бол өсөөд эхэлсэн. Энэ оны 1, 2 дугаар сараас төрийн албаныхных нь өсөөд явсан. Түүнийг дагаад одоо буцаад хувийн хэвслүүдийн цалин дагаад бас нэмээд өсөж байгаа. Ийм дүр зураг яг цалингийн динамик дээр ажиглагдаад явж байна.

Хоёр дахь асуудлын хувьд бол орлогын тэгш бус байдлыг шийддэг нь

өөрөө тусдаа бие даасан том бодлого байгаа.

Тэгээд энэ орлого багатай өрхүүд дээр нь магадгүй нийгмийн халамжийнх нь бодлого нь илүү зорилтот байдлаар том явах магадгүй мөнгөн бус хэлбэрээр буюу яг тэр мах гурил гэдэг юм уу зайлшгүй байгаа хүнснийхээ хэлбэрийг нь биет татаас юм уу хүнсний талон гэдэг юм уу энэ хэлбэрээр нь зорилтот болгох гэдэг энэ бодлогыг бол олон Улсын байгууллагууд сүүлийн жилүүдэд удаа дараа явж байсан. Харин хавтгайруулсан хэлбэрээр орлого хангалттай өсөж байгаа гэдэг юм уу харьцангуй гайгүй байгаа хэсэг дээр нь хавтгайруулж явахаар тэр нь өөрөө нэг зах зээл дээрээс бараа бүтээгдэхүүн авахаар тэрнийх нь дарамтыг нь доод хэсэг дээрээ орлого багатай хэсэг дээрээ дарамт очоод байна гэдэг ерөнхий энэ дүр зургийн макро хандлага байна л гэдгийг би сая онцолж хэлээд байгаа юм.

Ц.Цэрэнпунцаг: Ган-Очир даргаа таны наад хэлж байгааг бид нар Засгийн газраас сонсмоор байна. Засгийн газрын тэр яг энийг хариуцсан тэр яамны сайдын амнаас нь яг ингэж сууж байгааг бид нар сонсмоор байна. Энд сууж байгаа гишүүд тэрийг хүсээд байна.

Өнөөдөр тэр 40 хувийн орлого багатай тэр 30, 40 хувийн өрхүүдэд бид нар ялгаж дэмжлэг үзүүлэх заавал шаардлагатай байна. Тэгэхээр бид нар заавал хавтгайруулж ингэж эхийг нь эцээж тугалыг нь тураахгүй гэж ингэж аваачиж бүгдэнд нь юмыг жигдэлж аваачиж ингэж халамжийг нь хавтгайруулдаг энэ юмаа зогсооё оо гээд бид нарт ингээд хэлчих Засгийн газрын гишүүн Засгийн газрынхнаас хүн байна уу? Болорчулуун сайд сайд та хэлэх үү яах юм. Бид нар жишээлбэл орлого багатай өнөөдөр махаа авч чадахаа больчихсон тэр нэг жилийн өмнө, 2 жилийн өмнө нэг настай хөгшин цайгаа сүлээд уучихдаг байсан бол өнөөдөр сүүгээ авч чадахаа больчихсон сууж

байхад бид нар энийг шийдэх ёстой. Бид нар тэгэхээр энийг шийдэхийн тулд бид нар энэ бодлогын тавьж байгаа энэ зөвлөмжийг бид нар авч хэрэгжүүлээд өнөөдөр тэгвэл тэр 40 хувийнхаа орлого багатай иргэд дээр бид нар өнөөдөр төсвийн эхний улирлын орлого 600 тэрбумаар давсан тийм ээ. Энийгээ яг хэрэгцээтэй тэр шаардлагатай байгаа тэр өрхүүддээ, иргэддээ хүргэе гэж бид нар бас бодож ард иргэд ч тийм хүсэлтэй байна шүү дээ.

Ингээд Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

Ц.Цэрэнпунцаг: Сая Цэрэнпунцаг даргын хэлсэн үгтэй яг л санал нэг байна. Ингэж л хэлэх гэж байна л даа. Одоо Монголчуудын хамгийн өргөн хэрэглэдэг хүнс бол мах, гурил хоёр. Тэгтэл гурилын үнэ 40 хувь, махны үнэ нь 15 хувь, бусад бараа бүтээгдэхүүн нь сар бүр 1-2 хувь өсөж байна гэж байна. Тэгээд өрхийн орлогыг аваад үзэхэд 0.2 хувиар буурсан байсан бол одоо нийт орлого нь 0.7 гээд. Үгүй ээ үнэхээр хэцүү байна шүү дээ. Тэгээд цалин хөлс огт нэмэгдээгүй энэ сүүлийн 2 жил. Мэдээж гадаад нөхцөл байдал, геополитик энэ эдийн засгийг бид нар зөндөө ярьж ойлгож байна. Тэгэхдээ одоо ингээд бас нэг гайгүй болж байна шүү дээ. Засгийн газраа ажлаа хий л дээ. Ядахдаа энэ төсөв мөнгө нэмэх иргэдийнхээ одоо жишээ нь цалин хөлс, энэ үнэ ханишийг бид зах зээлээ бодоод бууруулах боломжгүй гэвэл тэгвэл иргэдийнхээ энэ худалдан авах чадварыг нь нэмэгдүүлэх тал дээр шийдвэр гарга л даа Болорчулуун сайд аа. Та өөрөө түрүүн хэлж байна. Үйлдвэржилт 30 жил Монгол Улс үйлдвэрлэгч орон болж чадаагүйгээс гол шалтгаан гэж байна. Үе үеийн энэ төр засагт удаан байсан хүмүүсийн энэ хор уршиг юм уу? Би энийг бас ойлгохгүй байна л даа. Та өөрөө бас энэ үйлдвэрлэгч хүн байсан. Тэгээд шийдвэр гаргах түвшинд ажиллаж байна.

70 сая малтай Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам махны үнийг тодорхой хэмжээнд бас нэг зохицуулалт хийх тал дээр яг ямар арга хэмжээ авсан бэ? Авч байгаа вэ? Та энэ дээр нэг Болорчулуун сайд маш тодорхой хариулт өгөөч. Зах зээл гэдгийг бид ойлгож байгаа. Угаасаа энэ зах зээл жсамаар явна. Тэгэхдээ энэ чинь арай биш байгаад байна шүү дээ.

Зохицуулалт үгүйлэгдээд байна шүү дээ. Бид нар сая тэр би өөрөө Чингэлтэй дүүргийн 2, 3 том махны зах манайд байдаг. Бид нар ингээд л очоод иргэдээс бас асууж байна. Махны худалдаачдаас асууж байна. Хөдөөгөөс оруулж ирж байгаа нийлүүлж байгаа хүмүүсээс ч асууж байна. Ченжүүдээс дамжиж байгаа энийг зогсоох гээд өмнө арга хэмжээ авдаг байсан. Одоо ийм байдлаар орж байна гээд л энэ чинь ингээд л тэд нар хүртэл янз янзын арга яриад л байдаг. Тэгээд бодлогын яам маань яг бодлогын арга хэмжээ авмаар байна шүү дээ. Би үнэ шууд буулга гэж хэлээгүй байна. Ерөөсөө л бодлогын арга хэмжээ авах хэрэгтэй байна. Та Засгийн газарт ямар бодлогын арга хэмжээ авахаар оруулж байна вэ? 1 дүгээрт энд хариулт өгөөч гэж асуумаар байна.

Хоёрдугаарт нь сая манай Монголбанкны Ган-Өлзий маань хэлээд л байна л даа. Долларын хани сарын өмнө 3510 байсан. Одоо долларын хани 3470 байна. Нэг 40 доллароор буурсан байна. Энэ 40 доллароор буурсан нь долларын ханишийн бууралт жишээлбэл өнөөдрийн энэ үнэ ханишийн өсөлтийг тодорхой хэмжээгээр бууруулахад хэзээ нөлөө үзүүлэх магадлал харагдаж байгаа билээ. Энэ тооцоолол статистикийн газар та нар маань хамтраад хийж байна уу? Хамтарч ажиллаж байна уу үгүй юу. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар гээд нэг шүдгүй арслан байна л даа хөөрхий яваад л байх шиг байгаа юм. Тэр алтан тариаг 5 саяар торгоод л эргээд л нөгөөдөх нь талхныхаа хэмжээг багасгаад юм уу эсвэл иргэдийн авах

юман дээр мөнгийг нь нэмчихнэ гээд л хариулт өгөөд сууж байхад дуугай л байж байна л даа.

Өнөөдөр бензин шатахууны үнэ нэг хэсэг тогтвортой байлгах үнэ тогтворжуулах хөтөлбөр аваад дизелийн түлш 92-оо буулгасан. Одоо тодорхой хэмжээгээр тогтвортой байна. Долларын хани буцаад буурчихлаа. Яг энэ үед тэр үнээ үнэ өсгөсөн газрууд тэр чигээр нь тогтоочихлоо шүү дээ. Энд хэн хяналт тавих юм бэ? Хяналт тавих газар байхгүй байгаа юм аа? Монополын эсрэг хууль гарах ёстой юу Болорчулуун сайдаа. Хэн энийг зохицуулах вэ? Яг үнэнийг хэлэхэд сая Солонгос улсад бензиний үнэ нь өсөх үед бараа бүтээгдэхүүн дагаад өссөн байсан. Сая нефть бүтээгдэхүүний үнэ нь буурсан бүх аж ахуйн нэгж, бүх дэлгүүр хоршоо нь яг эргээд үнээ хэвийн байдалд нь буцааж авчирч байхад манайд тогтсон л бол тэгж тогтоод байна шүү дээ. Сая тэгж байна үнэ цаашидаа бууруулахгүй байх арга хэмжээ авах гээд. Үгүй ээ буурах ёстой шүү дээ.

Хэрвээ сая бензин шатахуун дээр уул уурхайн сайд нь нэмэгдэхгүй тогтвортой байна. Дизель түлш 92 дээр бид тодорхой арга хэмжээ авч байгаа. Нөөц хангалттай байна гэж байна. Долларын хани буурлаа. Валютын нөөц 1 тэрбумаар нэмэгдлээ. Нүүрсээр ашиг овоо олж байна гэнэ, шилэн болгож байна ил тод гээд. Энэ хулгайнаас зөндөө мөнгүүдийг оруулж ирж байна. Үгүй ээ тэгээд иргэд рүүгээ хандсан арга хэмжээ хамтдаа шуурхай авъя л даа. Эдийн засгийн байнгын хорооны дарга гишүүд ингээд л явлаа. Тодорхой арга хэмжээ авах гээд ингээд салбарын Байнгын хороо нь хуралдаад та нараас шийдэл хүсээд байна. Би лав тэр энэ 2 цагийн энэ хурлаас нэг ч тодорхой юм хэлсэнгүй.

Ц.Цэрэнпунцаг: Сая Оюунчимэг гишүүн Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас л асуулт асууж байна шүү

дээ. Энэ үнэ өссөн юм нь аль нь тэр зах зээлийнхээ жамаар өсөөд явчихсан юм. Зарим нь одоо тэр монопол янз бүрийн тэр өрсөлдөөн нь явагдахгүй тэнд гажуудал гараад тэгээд тэр үнэ нь тогтоочоод тэрнийгээ буулгахгүй байгаа юм биш үү. Энэ дээр та нар ямар шалгалт хийсэн юм бэ л гэж байна. Нэг номер, ажлын хэсгийн нэг номер.

Ц.Уртнасан: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар бол үндсэндээ 8 хуульд хэрэгжилтийг улс орон даяар хангуулдаг. Энэний гол 2 хууль Өрсөлдөөний тухай хууль, Хэрэглэгчийн тухай хууль.

Өрсөлдөөний тухай хуулиар бол нэг ёсондоо шударга өрсөлдөөнийг бий болгох түүнээс урьдчилан сэргийлж зах зээлийг өргөтгөх тийм зохион байгуулалтын хуулийн зохицуулалт үйлчилдэг. Хэрэглэгчийн хуулиар бол худалдах, худалдан авах харилцаа буюу бараа, ажил, үйлчилгээ авсан иргэдийн тэр харилцааг зохицуулсан л энэ 2 хуулийн зохицуулалт үйлчилдэг.

Тэгэхээр бид бүхэн бол эрэлт нийлүүлэлтийнхээ үндсэн дээр өртөг зарлагаар тогтсон үнэ бий болохыг л шаарддаг болохоос биш тухайн үнийг яг хүчээр юм уу буулгах тийм зохицуулалтууд бол өнөөдрийн хууль тогтоомжид байдаггүй. Өрсөлдөөний тухай хууль 1993 оноос хойш 1993 онд батлагдаж, түүнээс хойш тийм, тийм.

Тэгэхээр одоо бид бүхэн би бас түрүүн тийм түрүүн дурдаж байсан зарим тарифын зохицуулалттай аж ахуйн нэгжүүд болон бусад тэр үнийн асуудал дээр бид бүхэн бол Худалдааны тухай хууль болон Үнэ өртгийн энэ тухай хуулийн тэр олон улсад жишиг болсон том хуулиудыг хэрэгжүүлж батлуулах зайлшгүй шаардлага бий болж байгаа гэж үзэж байна.

Ц.Цэрэнпунцаг: Оюунчимэг гишүүн та тодруулж нэмж асуух уу? Долларын ханиш буурсан гээд бусад хүчин зүйлүүдээр үнэ өртөг нэмэгдэх. Болорчулуун сайд танаас асуулт асуусан хариулна уу гэж байна.

Болорчулуун сайдын микрофоныг нээе.

Х.Болорчулуун: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя.

Оюунчимэг гишүүн өргөн хэрэглээний барааны үнэ өссөн талаар ярьж байна л даа. Ер нь бүх л юмны үнэ Монголд өсчхөөд байгаа шүү дээ. Энэ олон Улсын байдал, тээвэр логистиктой холбоотой. Харин мах, гурил бол хамгийн өргөн хэрэглэгддэг болохоор хүмүүс дээр мэдээж эмзэг тусаж байгаа нь ойлгомжтой. Махны үнэ тэр тусмаа хавар болгон л үнэ өслөө гэж яригддаг. Ялангуяа ногоо гарахын өмнө энэ хаврын тарчиг цагт 4 сарын сүүл, 5 сар сард үнэ өсдөг. Жил болгон шүү. Энэ график динамикаараа өсдөг. Үхрийн мах бол дэлгүүрт жижиглэнгийн үнэ 18-20 мянгатай байна. Килограмм нь хонины мах 13-15 мянгатай байна. Бүүр 2019 онд 4 жилийн өмнө үхрийн мах 24, 25 мянга хүрч өсөж байсныг бас мартаагүй байх гэж бодож байна, хавар.

Харин махны үнийн эсрэг үнийг тогтворжуулах буулгахын тулд бас нөөцийн мах бэлддэг. Энэ жил 12 аж ахуйн нэгж, 8 мянган тонн нөөцийн мах бэлтгэсэн. Улаанбаатарт 400 гаруй цэгээр борлуулж байна. Өргөтгөсөн худалдааг хагас сайн бүтэн сайн болгонд 40 цэгээр борлуулж байгаа. Нөөцийн махныхаа 30 хувийг ч одоогоор борлуулаагүй байна. Тэгэхээр нөөцийн махны нөөц бол байгаа гэж ойлгож болно оо.

Гурилан дээр бол би түрүүнд хэлсэн дээ өөрөө байхгүй байсан байх. Манай газар тариаланчид бол чадан ядан

ажиллаж байгаа. Тэр будааны үнэ өсөөд дагаад гурилын үнэ өсөж байгаа. Улаан буудайны үнэ. Улаан буудайны өмнө зохиомол өссөн юм ердөө байхгүй шүү. Бас манай гишүүд өөрөө бас гурил будааны үнийг их сонирхдог. Энэ хаврын тариалангийн үед бид нартай цуг газар тариалангийн компаниуд дээр очоод яваад, тэдний үгийг сонсоод, зовлон жаргалыг нь бас нэг нүдээрээ хармаар байна. Тэгж байж энэ хиймэл үнэ өсгөж байна уу? Бодитой гурил будааны үнэ өсөв үү гэдгийг бас ойлгох байх.

Газар тариалангийн компаниуд дунд бол би түрүүнд хэлсэн. Тийм өргүй компани гэж байхгүй болж байна. Өнгөрсөн жил 2022 онд манай улс нийт улаан буудайнхаа 90 хувийг бол үндсэндээ дотоодоосоо авсан. 10 хувь нь намар ургац хураахын наана 1, 2 сар ОХУ-аас улаан буудай авахад буудайн үнэ өшөө үнэтэй буудай авах гэж байна. Тэр үед түр зуур бас энэ гурил будааны үнэ өсөхөд үүсэх арга байхгүй. Ийм л байдалтай байна. Харин бид нар үндэсний үйлдвэр дотооддоо газар тариалан эрхэлж байгаа тулдаа үнийг барьж байгаа шүү гэдгийг бас хэлэхийг хүсэж байна.

Манай улс гаднаас үр, бордоо, ургамал хамгааллын бодис, техник бүгд импорттоор авдаг валют зарж. Энийгээ дагаад бас энэ улаан буудайн үнэ өсөж байгаа юм. Тэгтэл ОХУ хажуугаасаа дотоодоосоо үр, бордоо, техник шатахуун бүгдийг авч байна. Тэгсэн мөртөө гагаас манайхаас 2 дахин илүү ургац авдаг мөртөө улаан буудайн үнэ нь өндөр байна гэж боддоо манайхаас. Тэгэхээр манай газар тариаланчид бол улаан буудайн үнийг зохиомол өсгөсөн юм байхгүй өсгөх боломжгүй угаасаа. Угаасаа гурил будааны үнийг зохиомол өсгөж энэ шударга бус өрсөлдөөнийхөн гурилын үйлдвэрүүд зохиомол өсгөсөн юм шиг бас ярьж хяналт шалгалт хийсэн л гэж байна лээ. Цемент шиг хоёр, гуравхан компани биш шүү. Энэ чинь 10 гаран компани үйлдвэрүүд ажиллаж

байгаа. Зохиомол үнэ хөөрөгдөх ийм боломж байхгүй гэж.

Ц.Цэрэнпунцаг: Тэр үнэ хөөрөгдөж байгааг бол Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар бол энийг сайн мэдэж байх ёстой доо.

Оюунчимэг гишүүн нэмэлт асуулт асууя.

М.Оюунчимэг: Шударга өрсөлдөөний энэ газрыг хэлээд байна шүү дээ.

Ямар ч шийдвэр гаргах эрх зүйн хувьд боломжгүй газар руу бид нар эндээс чичлээд яах вэ дээ. Засгийн газар маань л ажлаа хийчихье гэж хэлмээр байна. Би Болорчулуун сайдыг ойлгож байна амаргүй байгааг. Тэгэхдээ та бол бас ч гэж энэ салбарыг мэддэг хүн жил болгон л нэмэгддэг шүү дээ. 2019 онд 24-25 мянгаар нэмэгдэж байсан шүү дээ гэж суухын оронд ингэж нэмэгдүүлэхгүй байхын тулд ийм зохион байгуулалтын арга хэмжээ авчихъя гээд шахаад сууж байх л ёстой мундаг хүн дээ та. Тэгээд уг нь 10 их наядын хөнгөлөлттэй зээл хөдөө аж ахуйг дэмжих сан, ЖДҮ-ийг дэмжих сан, Тариалан эрхлэлтийг дэмжих сан. Тэгээд гааль НӨАТ-аас дандаа бид хөдөө аж ахуйн чиглэлийн газар тариалан эрхэлж байгаа компаниудыг дэмждэг. Гэтэл бүх компани өртэй байна гэдэг арай л байгаа байхгүй юу. Сая тэгээд Хөгжлийн банкны асуудал болоход яасан бүхий л компаниуд нь зээл аваад өөр юманд зарцуулсан зүйлүүд ч гарч байна. Тариалан эрхлэгчдийг дэмжих санг сая Учрал сайд баахан зарлалаа. Бас шал өөр юм руу явчихсан байна.

Тэгэхээр би таныг бодлогын өөр арга хэмжээ авахгүй бол улс оронд хэцүү байна шүү гэдгийг л.

Ц.Цэрэнпунцаг: Оюунчимэг гишүүн ерөнхийдөө санал хэлчихлээ тийм ээ. Тэгээд энэ гишүүд ерөнхийдөө та бүхэн асуулт асуугаад ингээд саналаа хэлж

дуусаж байна. Цуг явчихсан. Тэгвэл санал тусдаа бол та одоо саналаа хэлнэ шүү. Асуулт асууж саналаа хэлж дуусаж байна.

Ингээд Бат-Эрдэнэ гишүүнийг саналаа хэлсний дараа би бас саналаа хэлээд ингээд дуусгая. Бат-Эрдэнэ гишүүн саналаа хэлье. Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг нээгээрэй, орчихлоо.

Ж.Бат-Эрдэнэ: Түрүүн Болорчулуун сайд байхгүй байсан сайд ороод ирлээ тэгээд сайдад саналаа хэлэх гэсэн юм. Сая Оюунчимэг гишүүн бас хэлэх шиг боллоо. Оюунчимэг гишүүний хэлснийг дэмжиж байна. Тодорхой заалт заалтууд тодорхой арга хэмжээнүүд хэрэгтэй байна.

Та бүхэн мэдэж байгаа Улсын Их Хурлаас Улсын Их Хурлын даргын үүрэгдсэн 5 гишүүн яваад үзээд хараад ард иргэдэд ямар бухимдалтай байгаа гэдгийг та бүхэн харсан шүү дээ. Болорчулуун сайдаа харсан. Одоо бидэнд шийдэл хэрэгтэй байхгүй юу даа. Яах гэж Засгийн газарт ажиллаж байгаа юм бэ? Шийдэл хэрэгтэй. Шийдэх гэж Засгийн газарт орж байгаа шүү дээ бид нар чинь. Тэгээд тэр махны нөөц бүрдүүлэхтэй холбоотой асуудлууд танай дэд сайд ярина лээ. Яг юун дээр нь болохгүй байгаа юм гэдгийг чинь бид нар очоод тэнд чинь харчихлаа шүү дээ. Ерөөсөө бид нар жилийн жилд чанаргүй ийм бүтээгдэхүүн чанаргүй мах цуглуулаад л байгаа шүү дээ. Үгүй ээ хүссэн хүсээгүй бид нар сонгуульд орохдоо мөрийн хөтөлбөрөө батлуулаад үнийг тогтвортой байлгана энэ тэр гээд орчихсон байхгүй юу даа. Тэгэхээр энийг хийхээс өөр арга байхгүй. Хийхээс өөр арга байхгүй хийнэ. Хийх хийхдээ чанартай хийхээс өөр арга байхгүй байхгүй юу даа. Зөв хийхээс өөр арга байхгүй байхгүй юу. Энэ чинь махных нь үнийг яг чанартай нэг түвшинд тэр махны ченжүүд хэлж байна лээ шүү дээ. Хэрвээ энэ махны үнийг нэг ингээд

чанартай цуглуулаад ингээд барьчих юм бол энэ чинь өөрөө махыг тогтворжуулах юу болох юм яг одоо тийм арга хэмжээ нь болох юм. Энэнээс илүү мах бид нар гаргаж ирээд бид нарын махыг авахгүй болчихно.

Тийм болохоор яг энд чанартай мах барьчих юм энэ бол бид нарын үед хувьд махны үнийн дээд хэмжээ болчихно. Бид нар дээшээ гаргаад бид нарын махыг хэн ч авахгүй ингэж хэлж байгаа шүү дээ. Тэгээд энэний учрыг яагаад олчхож болохгүй байгаад байгаа юм бэ? Энэ мэргэжилтнүүд чинь ажиллах хэрэгтэй шүү дээ. Гарцуудыг нийслэлд үүрэг өгөх хэрэгтэй байна тэгвэл. Одоо тэгээд ер нь эндээс даргаа ер нь бол эндээс нэг тийм шийдвэр гаргаж байх ёстой. Би бол эртээд хэлсэн шүү дээ. Заригт хэлсэн, ганцхан тэр Заригийн тэр нэг буруу гарчигласан гарчгаар баахан сэвээд саваад явчихна лээ. Дотор нь зөндөө ярьсан шүү дээ.

Нэгдүгээрт бол Засгийн газарт үүрэг өгье.

Хоёрдугаарт нийслэлд үүрэг өгье.

Гуравдугаарт Хөдөө аж ахуйн яаманд ямар ямар асуудлууд байх юм үүрэг өгье. Тэгж байгаад буцаад их хурал дээр шийдэл гаргаад явъя. Үндсэндээ мөрийн хөтөлбөр дээр юу тусгасан юм. Энэнийхээ дагуу гүйцэтгэх байгууллагууд маань үйл ажиллагаа явуулъя тэр рүү үзье, харъя. Бид нар одоо тэр амьдралаас бүүр нэг их айхтар тасарсандаа биш. Асуудлуудыг тэр тусмаа хөдөөгөөс сонгогдсон гишүүдийн хувьд бол бид нар чинь бүх амьдралыг мэдэж байгаа шүү дээ. Малын үнэ тэнд хэд байгаа билээ? Одоо малын нийлүүлэлт нь хаврын энэ тарчиг цагт нийлүүлэлт нь байхгүй болчихсон. Тэгвэл нийлүүлэлтийг юу барих юм? Нөөцийн мах барина. Үгүй амьдралыг бид нар мэдээд л байгаа шүү дээ. Энэний чинь төлөө өчнөөн жил ажиллаад болж өгөхгүй л явах гээд л зохицуулалтыг нь хийж өгөхгүй л байна

шүү дээ. Одоо зохицуулалтыг нь хийгээд туслаад өг л дөө.

Тэгэхээр нийслэл дээр тэр аймаг орон нутаг дээр байж байгаа нийлүүлэлттэй холбоотой, тээвэрлэлттэй холбоотой тэр хил гааль дээр байж байгаа яг өргөн хэрэглэлийн бараатай холбоотойгоор хил гааль дээр байж байгаа тэр хүмүүс хэлсэн шүү. Камераас тусдаа дуудаж авчирч байгаад гишүүн ээ тэр авлигатай холбоотой асуудлуудаа тэр гааль дээр байж байгаа асуудлуудаа засаж өг гэж хэлсэн шүү. Энэ асуудлуудаа засахгүй бол энэ үнийн хөөргөдөл үнийн нэмэгдлүүд чинь үргэлжийн байх болно гэж ярьсан шүү.

Тэгэхээр бид нар энэ хил гаальтай холбоотой асуудлууд, тэр татвартай холбоотой асуудлууд ямар ямар хөнгөлөлт байж болох юм байж болохгүй бол байж болохгүйгээ хэлье. Тэр ченжүүдийн олон нугалаа байдаг юм тэр ченжүүдийн нугалааг нь багасгая. Бүр ченжгүй явна гэж худлаа. Угаасаа байхгүй бид нар ченжгүй явна гэж худлаа хэлж болохгүй. Тэгэхээр тэр олон нугалаа байхгүй болох энэ зарчмыг л бид нар барих хэрэгтэй байна шүү дээ.

Дотоодын гурилын үнэ яагаад өсөөд байгаа юм гээд ярихаар л тэгээд л гадаадаас орж ирж байгаа үр тариатай холбож яриад байх юм. Дотоодын гурилын үнэ чинь үр буудай чинь яг ямар үнэтэй гарч ирж байгаа юм. Тэндээс өртгийг нь нэмэгдүүлээд гурилын үнэ яг яаж гарч ирж байгаа юм гэдэг юмаа л гаргаад бид нарт бодитойгоор хэлээд өгчих л дөө. Тэгвэл бид нар үнэмшинэ шүү дээ. Тэгэхгүй тэгээд шал ондоо юм яриад байхаар чинь ард иргэд бид нар битгий хэл ард иргэд бүгд аль адилхан нь адилхан энийг чинь ойлгохгүй л байгаад байна шүү дээ. Яагаад өсчхөөд байгаа юм бэ гээд. Тэгвэл үнэхээр ийм болохоор буудай энэ төгрөгт гарч байгаа. Дараа нь ийм үнэтэй болохоор ийм өртөгтэйгөөр гурил ингэж гарч байгаа. Хивэг нь ийм гарч байгаа энэ тэр гээд.

Тэгээд дээрээс нь экспорт руу мах тэр мах зарж байгаа хүмүүс хэлсэн шүү. Хаврын улиралд экспортыг хаачихмаар байна гэсэн шүү.

Яагаад энэ арга хэмжээг бас та нар бодож олж болдоггүй юм бэ энэ чинь. Бүх нийлүүлэлтээ яг ийм хаврын тарчиг үед бүх нийлүүлэлтээ дөнгөж Дундговиос энэ хажуухан Хэнтийгээс л мах орж ирж байгаа. Өөр мах нийлүүлэлт байхгүй. Уртаашаа нэг 20 гаран тонн орж ирж байгаа гэсэн үнэн. Тэгвэл тэр гадныхаа экспортыг хэдүүлээ хаачихъя л даа. Энэ одоо Хятадын ченжүүд авч байгаа энэ махаа бид нар хаачихъя л даа, дотооддоо оруулаад ирье л дээ. Ийм зохицуулалтын арга хэмжээнүүдээ хийе л дээ.

Ц.Цэрэнпунцаг: Бат-Эрдэнэ гишүүн саналаа хэллээ.

Ер нь тэгээд бид нар ингээд өнөөдөр бас хангалттай гишүүд ерөөсөө санал үг асуусан асуулт хэлсэн санал. Тэгээд л голдуу санал хэллээ шүү дээ. Ерөөсөө шийдэл алга байна, шийдэл нь юу байна, гарц нь хаана байгаа юм, гаргалгаа нь хаана байгаа юм гээд тийм ээ. Тэгээд ерөнхийдөө ингээд харж байхад тэр үнэн байлгүй дээ тэр ноднин 7 мянган тонн нөөцийн мах зарагдаагүй үлдсэн гэж үнэн үү? Үнэн байх. Тэр хариулах гээд яах вэ үнэн байх. Тэгээд энэ жил хэд ч үлдэх юм. Одоо тэр хүмүүсийн голж шилж байгаагаар бол авахгүй нь байна шүү дээ. Тэгэхээр энэ нийслэлдээ амьдарч байгаа хэрэглэгч чинь ямар мах авах гээд байгаа юм? Ямар мах чанартай, ямар ямаа, үхэр юм уу, хонь юм уу? Алийг нь ямар хэмжээтэй авах гээд байгаа юм та нар тодорхойлж чадахгүй л байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ бол үнэхээр хүндрэлтэй асуудал. Бид нарын энэ хийгээд байгаа нь зөв ч юм уу, буруу ч юм уу л яригдаж байна шүү дээ. Өнөөдөр нөөцийн мах бэлтгэдэг компаниуд руу хүртэл ярьж байна гэж байна. Энэ

нөөцийн мах бэлтгэх шаардлага байгаа юм уу? Үгүй юу гэж. Энийгээ хүртэл бид нар эргэж харах ёстой юм байна. Энэ чинь хэчнээн жил энүүгээр араас нь ухнатаж явав тийм үү? Тэгээд ер нь ингээд энэ олон асуудал ярихаар зэрэг л бид нар энэ гурил будааны үнээ гадна дотно хямдхан байна, үнэтэй байна гээд ярих юм. Бид нар уг нь энэ худалдан авах гааль тариф нь бага энэнээсээ үүдээд бид нар гаалийнх нь энэ янз бүрийн тарифын бус болон тарифын энэ саад бэрхшээл бол бага байвал зүгээр байгаа юм.

Бид нар энэ дэлхий даяар үйлдвэрлэж байгаа энэ хэрэглээний бараануудын энэ дэлхийн бусад орны хамгийн сайн чанартай юмыг хамгийн бага үнээр үйлдвэрлэдэг энэ бараа бүтээгдэхүүнийг нь аваад ард түмэн нь хэрэглэхивэл бид нар л хожиж байгаа юм л даа. Тэгэхээр бид нар уул нь дэлхий дээр чинь өөрсдийнхөө сайн чаддаг юман дээрээ нарийн мэргэшээд нарийсаад тэрийгээ гүнзгийрүүлээд сайжруулаад л явчихдаг. Нөгөөдүүлийн сайн хийдэг юмыг нь бага үнэтэйгээр бас чанартай юмыг нь аваад хэрэглэхидэг л ийм л сайхан байвал бидэнд уул нь хэрэгтэй байгаа юм.

Тэгэхээр заавал чадахгүй юмыг нь хөгжүүлж хийх ёстой гээд л энд баахан дэмжээд байдаг. Хэчнээн ч дэмжих юм. Энэ газар тариалангийнхан нь хэчнээн ч жил хичнээн ч мөнгө өгөв дөө. Тэгэхэд одоо яасан ч хөл дээрээ босдоггүй юм. Энэ чинь хүүхэд хүртэл 2, 3 жил энэ чинь явж байгаад хөл гараа олоод байж байгаад ингээд өөрийгөө бие даагаад явчихдаг шүү дээ. Хүүхэд гэхэд хугацаатай нь бойжоод явчихдаг. Тэгтэл энэ бойжихгүй тэгээд л энэ 20, 30 жил бойжихгүй явсан ийм салбар үйлдвэрлэлүүд байх юм энийг нь тэгээд заавал ингээд яваад байх шаардлага байдаг юм уу үгүй юу? Ер нь нөөцийн мах бэлдэх энэ гурилын үнэ буулгах тэгээд энэ махны үнийг барих гээд төр бол чадахгүй юманд л оролдож явсан байна

гээд бүгд яриад байна шүү дээ. Одоо тэгэхээр бид нар энийгээ үндсээр нь энэ бодлогоо өөрчлөх цаг болжээ.

Тийм учраас бол энэ хүнсний бараа өргөн хэрэглээний барааны үнэ нэмэгдэж байгаа, ер нь юмны үнэ нэмэгдэж байгаа энэ асуудлууд дээр бид нар энэ шийдэл Засгийн газраас асуугаад байгаа юм. Энэ Засгийн газрын шийдлүүдийг сонсмоор байгаа юм. Тэгээд энэ шийдлүүдийг нь бас бид нар сонсчихоод тэн дээрээ бид нар хэлэлцүүлгээ үргэлжлүүлж хийх ёстой юм байна гэж харж байна.

Ер нь ч бол энэ бас нөөцийн мах бэлтгэхэд энэ ажлаа цааш нь үргэлжлүүлэх юм блд тэр хот нь нөөцийнхөө махыг тусдаа бэлтгэдэг. Тэр хотынхоо иргэдийн асуудлыг шийдэж байгаа шүү дээ нийслэл. Заавал энэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь энд оролцоод явах шаардлага байдаг юм уу үгүй юү? Энийг хүртэл бид нар ярилцах шаардлагатай юм байна гэж бодож байна.

Тэгээд цаашидаа бид нар энэ Статистикийн газар судалгаагаа сайн хийгээд, энэ иргэдээсээ бид нар иргэдийнхээ мэдээллийг зөв гаргаад тэгээд энэ иргэдийнхээ өрхийнхөө орлогыг бид нарийн тогтоогоод тэгээд тэр дэмжлэг шаардлагатай иргэддээ бараг энэ төрөөс дэмжлэг үзүүлээд байдаг энэ дэмжлэгүүдээ шууд үзүүлээд явъя. Төсвөөсөө дэмжье. Тэр бага орлоготой иргэдийнхээ үнэхээр энэ гол нэрийн гол нэрийн бараа бүтээгдэхүүн хүнснийх нь энэ гол хэрэгцээний хүнснийхээ бараа бүтээгдэхүүнийг авч хэрэглэх тэр хэмжээнд нь хүртэл бид нар энэ дэмжлэгүүдийг нь үзүүлсэн нь бараг дээр байна тийм үү?

Тэрнээс нэг баахан гурил хямдхан болгох гэж байгаа гэж дэмжлэг өгдөг тэр нь ямар шугамаараа яваад тэр ямар ямар компаниуд нь авчихдаг юм. Тэр нэр усыг нь хүртэл бид нар жагсааж гаргаж ил тод болгоё. Хэдэн жил сүүлийн хэдэн

жил энэ хөгжил дэмжлэгийг ямар, ямар компаниуд нь аваад явсан юм байна. Банкнуудаас нь ямар компаниуд нь аваад явсан тэр компаниудаа ил гаргаад тавья. Тэр нь зөв замаараа явж уу буруу замаараа явж уу харъя.

Дээрээс нь энэ хэрвээ бид нар энэ дээрээс энэ Засгийн газрын шийдэл нь орж ирээд энэ зохилтой шийдэлд хүрэхгүй бол бид бүхэн санаачилгаа гаргаж явъя тийм үү? Саяын ажлын хэсэг дээр ажилласан Төсвийн байнгын хороон дарга байж байна. Тэгээд тэр Монголбанкны түрүүн манай Ган-Очир захирлын болгоомжлоод байгаа тэр инфляцад нөлөө үзүүлэхгүйгээр өнөөдөр юу нь инфляц үүсгээд байх илүү мөнгө бүтээх гол өдөр тутмынхаа хэрэглэх гурил махаа авч чадахгүй, сүүгээ авч чадахгүй, талхаа авч чадахгүй, ургамлын тосоо авч чадахгүй байгаа өрх гэр бүлдээ бид нар дэмжлэг үзүүлэхэд юуных нь инфляц үзүүлээд байх вэ? Тэгвэл нөгөө талдаа тэгвэл тэр татвар төлөгчдийн мөнгөөр тэр зээлийнх нь хүүгийн тэр дэмжлэг үзүүлдэг үзүүлэх гээд тавьчихсан тэр 135 тэрбумыг тавьчихсан байж л байна. Тэгээд энэ өчнөөн энэ олон сангуудаас дамжиж хийгдэж байгаа энэ зардал чирэгдлийг нөгөө талд нь тэгвэл багасгачихъя л даа. Тэгээд иргэддээ шууд гарт нь өгье л дөө. Тэгвэл наана нь тэр хүргэж байгаа, үйлдвэрлэж байгаа, үйлчилгээ хүргэж байгаа эд нарт нь итгэж өгөхгүй эд нар шударга бус яваад эд нар наагуур цаагуур энэ буруу зөрүү арга чарга хэрэглээд ингээд энэ картель болоод хуйвалдаад ингээд бид нарын тэр зорьж байгаа тэр үнэ буулгах гэсэн зорилт биелэхгүй байгаа тэгвэл заавал энэ болохгүй юмыг бид нар ингэж олон жил оролдож араас нь юу яаж яах вэ? Ингэж бодож байна.

Ингээд Гол нэр төрлийн зарим бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт хомсдолоос сэргийлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилт болон хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтийн асуудлаар холбогдох

байгууллагуудын мэдээлэлтэй танилцаж дууслаа.

Ингээд дараагийн удаагийн удаа энэ Засгийн газраас тодорхой шийдлийг нь сонсъя. Тэгээд энэ дээр дахиж энэ хэлэлцүүлгийг үргэлжлүүлж хийе гэж бодож байна.

Ингээд өнөөдрийн мэдээлэлтэй танилцаж дууслаа. Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна.

15.53 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ